МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

“ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ”

Судалгааны төрөл: **Хэрэгжилтийн үнэлгээ**
Судалгааны код: **БГСТ-24/033**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: Я.Батханд Ph.D

Улаанбаатар хот
2024 он

ТОВЬЁОГ

Нэг. Нийтлэг үндэслэл.....1

Хоёр. Хэрэгжүүлэх үе шат.....5

Гурав. Эрх зүйн онолын үүднээс шинжлэх нь.....7

Дөрөв. Үнэлэх үе шат.....25

Тав. Дүгнэлт 50

Зургаа. Санал 53

Долоо. Ном зүй 54

Нэг. Нийтлэг үндэслэл

Удиртгал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомж мөрдөгдөж эхэлснээс хойш 5 жил тутам хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж, заасан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 3-т “...Монгол Улсын иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй ...”[1], мөн хуулийн оршил хэсэгт Монголын ард түмэн бид эрхэм зорилго болгон тунхаглан зарласан зүйлийн дотор “Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх...”[2] үзэл баримтлал нь иргэний нийгмийн чөлөөт эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэгдсэн эрх зүйн онолын хувьд чухал байр суурь эзэлдэг.

“Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдэл” хэмээн тодорхойлсон ухагдахуун нь хоорондоо харилцан хамаарал бүхий ойлголт төдийгүй “үндэсний эв нэгдэл” нь хүмүүсийн итгэл үнэмшилгүйгээр хангагдах боломжгүй юм. Энэхүү үзэл санаанд тулгуурлан Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, эдийн засгийн хөгжил, Монгол Улсын болон гадаад улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдийн эд хөрөнгийн эрх ашиг, сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах эрх зүйн системийг идэвхжүүлэх, эрх зүйн үүрэг, баталгааг хангах шаардлага бий болж байна.

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр тархаад буй цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор Монгол Улсад төдийгүй Олон Улсын хэмжээнд шинэ төрлийн гэмт хэргүүд гарч, зарим гэмт хэргийн агуулга, хэлбэр, нийгэмд учруулж буй аюул заналыг урьд тогтсон уламжлалт хандлагаар авч үзэх боломжгүй болж, хөгжиж буй нийгмийн харилцаанд учруулах хор уршиг нь нэмэгдэж, хувьсан өөрчлөгдсөөр байна[3].

Монгол Улс дахь залилах гэмт хэргийн гаралт, учруулсан хохирол, хор уршиг жил дараалан байнга өсөж, үйлдлийн арга нь улам бүр нарийсч, зохион байгуулалттайгаар, цахим хэлбэрээр, олон улсын шинжтэй, улс орон дамнан үйлдэгдэх хандлагатай болж байна.

Залилах гэмт хэрэг нь олон улсын болон үндэсний санхүү, эдийн засгийн тогтолцоонд ноцтой хор аюул учруулах боломжтой бөгөөд улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгод туйлын харш гэмт үйлдэл төдийгүй хүмүүс хоорондын бие биедээ итгэх итгэл, эв нэгдэл, шударга ёсонд ноцтой хохирлыг шууд болон шууд бусаар учруулдаг онцлогтой[4].

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2010-2021 онд нийт 317.211 гэмт хэрэг бүртгэгдсэн байгаагаас 2002 оны Эрүүгийн хуулийн 148, 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлгийн 17.3-т заасан “Залилах” гэмт хэрэг 33740 бүртгэгдсэнээс 28458 буюу 84.3 хувь нь Нийслэлд, 5160 буюу 15.3 хувь нь орон нутагт, 139 буюу 0.4 хувь нь бусад газар /хилийн чанадад/ тус тус үйлдэгдсэн байна[5].

---

[1] *Монгол Улсын Үндсэн хууль (legalinfo.mn)*

[2] *Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992, №1*

[3] *Монголбанкны дэргэдэх санхүүгийн мэдээллийн албаны нэрэмжит эрдэм шинжилгээний хурал “Залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт”:УБ.,2022, 1 дэх тал*

[4] *Залилах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах мөрдөгчийн гарын авлага.УБ., 2021, 14 дэх тал*

[5] *Хууль зүй, гэмт хэрэг (1212.mn)*

График 1. Залилах гэмт хэрэг /2010-2021 он/



Сүүлийн 12 жилийн дунджаар авч үзвэл гэмт хэрэг 21.5 хувийн өсөлттэй байна[6]. Урьд өмнө нь зөвхөн хувь хүн энэ төрлийн хэргийн халдлагад өртдөг байсан бол өнөө цагт хувь хүмүүсийн хүрээнээс хальж байгууллага, аж ахуй нэгж, цаашилбал улс орон дамжин үйлдэгдэх, олон хохирогчтой, хор уршиг ихтэй, санхүүгийн тусгай арга ашигладаг зэрэг онцлогтой байна.

Улсын хэмжээнд 2015-2021 онд нийт 8369 гэмт хэрэг цахим орчинд үйлдэгдсэн бөгөөд тэдгээрийн 6592 буюу 78.8 хувь залилах төрлийн гэмт хэрэг байна. Цахим орчинд үйлдэгдсэн залилах гэмт хэргийг он тус бүрээр нь харуулбал 2015 онд 17, 2016 онд 69, 2017 онд 136, 2018 онд 590, 2019 онд 541, 2020 онд 1281, 2021 онд 3858 бүртгэгдэж, өсөлтийн дундаж 2.5 дахин өссөн бол 2022 оны эхний 2 сарын байдлаар 2360 залилах гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8 дахин өссөн байна[7].

Өөрөөр хэлбэл залилах гэмт хэрэг үйлдэгчид шинжлэх ухаан, технологийн орчин үеийн шийдэл, арга зүй, эрх зүйн зохицуулагдаагүй харилцаа, хийдлийг ашиглан үндэсний болон олон улсын санхүүгийн системд хор уршиг учруулж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн хамгаалалтыг сайжруулж, гадаадын бусад орны эрүүгийн эрх зүйн хамгаалалттай ижилсүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгааг харуулж байна.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийсэн ба “төлөвлөх” шатанд дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн хамгаалалт, залилах гэмт хэргийн талаарх ойлголт, онолын үзэл баримтлал, үүсэл хөгжил, олон улсын эрх зүйн болон гадаадын зарим улс орны туршлага, залилах гэмт хэргийн нөхцөл байдал, уг гэмт хэргийн бүрэлдэхүүн, зүйлчлэлийн асуудал, иргэний эрх зүйн харилцааны гэрээний хариуцлагаас ялган зүйлчлэх зэрэг асуудлыг судлан дүн шинжилгээ

[6] $\bar{X}_{\text{гео}} = \sqrt[n]{k_1 * k_2 * \ldots . * k_n}$ *геометрийн дундаж*

[7] *Цагдаагийн Ерөнхий газрын 2022 оны I улирлын мэдээ тайлангаас эшлэв.*

хийж, уг гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход судалгааны ажлын зорилго оршино.

1. Залилах болон түүнтэй төстэй гэмт үйлдлийн ойлголт, онол, үзэл баримтлал, хөгжлийн зүй тогтлыг түүхчилсэн судалгааны аргаар судлах;
2. Залилах гэмт хэргийн бүрэлдэхүүн, нийгмийн хор аюул, эрх зүйн зохицуулалтын онолын үндсийг судалж, дүгнэлт хийх;
3. Залилах гэмт хэргийн олон улсын болон Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг судлан дүн шинжилгээ хийх;
4. Залилах гэмт хэрэгтэй тэмцэж буй гадаадын бусад улсын туршлага, эрх зүйн зохицуулалтын онцлогийг харьцуулсан судалгааны арга ашиглан судлах;
5. Залилах гэмт хэргийг бусад ойролцоо төрлийн гэмт хэрэг болон иргэний эрх зүйн харилцааны гэрээний хариуцлагаас ялгагдах онцлог шинжийг тодорхойлох;
6. Залилах гэмт хэргийг шинжлэх ухаан технологи, нийгэм, эрх зүйн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан шинээр ангилах, төрөлжүүлэх, нэр томьёог тайлбарлах;
7. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд эрх зүйн дүн шинжилгээ хийх, эрүүгийн эрх зүйн зохицуулалтын судлах, түүнийг сайжруулах хэрэгцээ, шаардлага, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, дүгнэх, боловсронгуй болгох саналаа тусгах болно.

Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжид заасан залилах гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийв.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Судалгааг гүйцэтгэхдээ хуулийн бүхий л зүйл, заалтад хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх нь үнэлгээний ач холбогдлыг бууруулдаг. Эрүүгийн хуулийн залилах гэмт хэрэгтэй холбоотой зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд агуулгын хувьд чухал ач холбогдолтой, тулгамдаж буй асуудалд холбогдох дараах зохицуулалтыг сонгон авч үнэлгээний хүрээг тогтоов. Үүнд:

- Залилах болон түүнтэй төстэй гэмт үйлдлийг хуульчилсан Монгол Улсын шинэ үеийн эрүүгийн эрх зүйн шинжтэй эх сурвалж;
- Залилах гэмт үйлдлийг хуульчилсан олон улсын болон гадаадын зарим орны хууль тогтоомж, хэм хэмжээнүүд;
- Залилах болон түүнтэй төстэй гэмт хэргийн талаар туурвисан монголын болон гадаад орны эрдэмтэн, судлаачдын онол, арга зүйн бүтээлүүд (нэг сэдэвт бүтээл, эрдмийн зэрэг горилсон ажил, сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл гэх мэт)
- Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн материал (хавтаст хэрэг, яллах дүгнэлт, шүүхийн шийтгэх тогтоол) зэрэг шүүхийн практик судлалын хэрэглэгдэхүүн;
- Хууль хяналтын байгууллагын залилах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан материалууд;
- Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн гэмт хэргийн статистик мэдээ, судалгааны тайлангууд зэрэг болно.

Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт өмчлөх эрхийн халдашгүй байдлыг зөрчихөөс хамгаалсан нэг төрлийн харилцаагаар, өөрөөр хэлбэл төрлийн объектоор ангилан хуульчилсан юм. Энэ төрлийн гэмт хэргийн объект буюу зөрчихийг хориглож, эрүүгийн хуулиар хамгаалсан харилцаа бол өмчлөх эрхийн халдашгүй байдал юм. Нийтийн болон хувийн өмчийн эзэн /өмчлөгч, эзэмшигч, хариуцагчаас/-ээс өөр хэн ч халдаж үл болохыг халдашгүй эрх гэнэ. Энэхүү

халдашгүй эрхэнд эзний зөвшөөрөлгүйгээр, эсхүл хуулиар зөвшөөрсөн үндэслэл, журмыг зөрчиж халдахыг хууль бус явдал буюу нийгэм, иргэдэд хохирол учруулсан гэмт хэрэг, халдагч нь гэмт хэрэгтэн болдог[8].

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

Хуулийн хэрэгжилтийг үнэлэхдээ оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг харгалзан үнэлгээний аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт заасан 6 шалгуур үзүүлэлтээс “зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлт болон “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтүүдийг сонгон үнэлгээг гүйцэтгэв. Залилах гэмт хэргийн зүйл заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1.

№	Зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	17.3 дугаар зүйл.	1.Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
		2.Энэ гэмт хэргийг: 2.1.албан тушаалын байдлаа ашиглаж; 2.2.бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийг: 3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон; 3.2.олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн; 3.3.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Эрүүгийн хуулийн залилах гэмт хэргийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ аргачлалын 3.5.3 дахь хэсэгт заасан дөрвөн харьцуулах хэлбэрээс аль тохиромжтойг нь сонгох журамтай. Энэ дагуу аргачлалын 3.5.3.1-д заасан хууль тогтоомжийн байх ёстой болон одоо байгаа түвшинд үнэлэх хувилбарыг сонгон үнэлгээг хийсэн болно.

[8] *Мөн тэнд /тусгай анги/.УБ.,2021, 108 дах тал*

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан[9] **"**залилах**"** гэмт хэргийн ойлголт, өнөөгийн байдал, үйлдлийн арга, хэлбэр, түүнээс үүдэн энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэхэд учирч буй бэрхшээлүүд, дэлхийн бусад улс оронд залилах гэмт хэргийг хэрхэн авч үзэж шийдвэрлэдэг талаарх туршлага, эрх зүйн зохицуулалтыг судалж, түүнд тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийж, судалгааны үр дүнд тулгуурлан өөрийн дүгнэлт саналыг дэвшүүлэн шинжлэх ухааны эргэлтэд оруулах, практик үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилгоор энэхүү сэдвийг сонгон судлав "практикт хэр нийцэж байна вэ?" гэсэн асуултын хүрээнд үнэлгээг хийж гүйцэтгэв.

1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Мэдээлэл цуглуулахдаа аргачлалын 3.7.3-т тодорхойлсон дөрвөн аргаас 3.7.3.1 дэх хэсэгт заасан "бэлэн байгаа мэдээллийг цуглуулахдаа тухайн хууль тогтоомжийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, тухайн сэдвээр гарсан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалжийг ашиглах" аргыг сонгон, мөн Эрүүгийн хуулийн хэрэгжиж эхэлснээс хойших Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрүүдийг судлах замаар үнэлгээг хийв.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлгээг хийхдээ дараах эрдэмтэн судалаачдын судалгааны ажил, тайлан, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэлийг ашиглах болно. Үүнд:

Сэдвийн хүрээнд эрүүгийн эрх зүйн онол болон энэ төрлийн гэмт хэргийн талаар Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совд[10], Р.Гүнсэн, Ж.Авхиа[11], С.Нарангэрэл[12], С.Жанцан, Н.Жанцан, Д.Адъяабазар[13], Ц.Цэлмэг зэрэг эрдэмтэд ном, сурах бичиг, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүд хэвлүүлэн гаргасан байдаг. Түүнчлэн тухайн сэдвээр С.Энхцэцэг "Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зарим асуудал"[14] О.Мөнхцэцэг "Залилан мэхлэх гэмт хэргийг иргэний эрх зүйн зөрчил, ойролцоо

---

[9] *Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17 дугаар зүйлийн 17.3 дах хэсэг*

[10] *Түүнчлэн МУ-ын гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совд "Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар" бүтээлд залилах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг эрүүгийн эрх зүйн онолын талаас дэлгэрэнгүй тайлбарлан авч үзсэн байна*

[11] *Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Авхиа, Б.Ганболд "Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар" бүтээлд гэм буруугийн хэлбэр, хохирол, хор уршигийг онолын талаас нь дэлгэрүүлэн тус тус судалсан.*

[12] *"Монгол Улсын Эрүүгийн эрх зүй" /тусгай анги/. УБ., 1998 бүтээлд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүний нийтлэг шинжийг онолын талаас нь судалсан байна.*

[13] *Хууль зүйн ухааны доктор, профессор Д.Адъяабазар "Монгол улсад залилан мэхлэх гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийн тулгамдсан асуудал". УБ., 2004 судалгааны ажлаараа докторын зэрэг хамгаалахдаа бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэгтэй тэмцэж ирсэн Монгол улсын хууль цаазын түүхэн хөгжил, уг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж, төстэй гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс зааглан ялгах асуудал зэргийг дэлгэрэнгүй авч үзсэн байна.*

[14] *Магистрын зэрэг горилсон дипломын ажил.УБ.,2004 он*

төрлийн гэмт хэргээс ялган зүйлчлэх нь”[15] Т.Дэлгэрмэнд “Залилах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал, түүнтэй тэмцэх арга зам”[16] сэдэвт магистрын судалгааны ажлын хүрээнд залилах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, түүний уламжлал шинэчлэл, эрүүгийн загвар хуулиуд болон гадаадын зарим улс орнуудын эрүүгийн хууль тогтоомжид залилах гэмт хэргийг хуульчилсан байдлыг харьцуулан, уг гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх зэрэг асуудлуудыг тус тус авч үзэж судалсан байна.

Гадаадын эрдэмтэн судлаачдаас Nigel Iyer[17] Европ, Америк, Австрали улсын залилах болон авлигатай тэмцэх үр дүнтэй арга, эрсдэлийг үнэлэх, бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр; Sally Ramage[18] залилангийн гэмт хэргийг мөрдөн шалгах, эрүүгийн процесс ажиллагааны талаар, ОХУ-ын судлаач О.С.Беляк залилах гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага[19], Д.Ю.Беляков тээврийн хэрэгслийн даатгалын хүрээнд дэх залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологийн асуудал[20], Ю.М.Быков даатгалын салбарт үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн талаар[21], Л.В.Григорьева орчин үеийн эдийн засгийн харилцааны нөхцөлд залилах гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага сэдвээр[22], Р.Б.Осокин[23], М.Е.Покровский[24], Ю.И.Степанов[25], В.В.Эльзессер[26] нар эдийн засгийн харилцаа, банк, санхүүгийн салбар, даатгалын салбарын залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологийн шинжлэх ухаан талаас нь тусгайлан судалсан байна.

---

[15] *МУИС-ийн Хууль зүйн сургууль.магистрын дипломын ажил.УБ., 2014 он*

[16] *Их Засаг Олон улсын их сургуулийн эрдмийн сургуулийн магистрант Т.Дэлгэрмэндийн эрх зүйн магистрын зэрэг горилсон бүтээл ”.УБ., 2016 он*

[17] *Fraud and Corruption: Prevention and Detection - 1st Edition - Nigel (routledge.com)*

[18] *Fraud Investigation: Criminal Procedure and Investigation - Sally Ramage - Google Books*

[19] *О.С.Беляк. Ответственность за мошенничество по уголовному праву России: автореф. дис. к.ю.н. – Москва, 2006. – 24 с.*

[20] *Д.Ю.Беляков. Противодействие мошенничествам, совершаемым в сфере автострахования: криминологический и уголовно-правовой аспекты: дис. к.ю.н. – Москва, 2007.*

[21] *Ю.М.Быков. Мошенничество в сфере страхования (криминологические и уголовно-правовые проблемы): дис. к.ю.н. – Москва, 2006. – 196 с.*

[22] *Л.В.Григорьева. Уголовная ответственность за мошенничество в условиях становления новых экономических отношений: дис. к.ю.н. – Саратов, 1996. – 197 с.*

[23] *Р.Б.Осокинович. Уголовно-правовая характеристика способов совершения мошенничества: автореф. дис. к.ю.н. – Москва, 2004. – 23 с*

[24] *М.Е. Покровский. Мошенничество в финансово-кредитной сфере: автореф. дис. к.ю.н. – Санкт-Петербург, 2006. – 20 с.*

[25] *Ю.И. Степанов. Уголовно-правовая характеристика обмана как признака преступлений в сфере экономики: дис. к.ю.н. – Санкт-Петербург, 2001. – 253 с.*

[26] *В.В. Эльзессер. Борьба с мошенничеством в банковской сфере: Уголовно-правовой и криминологический аспекты : автореф. дис. к.ю.н. – Санкт-Петербург, 2005. – с 22*

ГУРАВ. ЭРХ ЗҮЙН ОНОЛЫН ҮҮДНЭЭС ШИНЖЛЭН СУДЛАХ НЬ

3.1.Залилах гэмт хэргийн тухай ойлголт, онолын үндэс, хууль зүйн учир холбогдол

Аливаа улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэж байгаа гэмт хэргийн гаралт, хэлбэр, эзлэх хувь зэрэг нь тухайн орны нийгэм эдийн засгийн хөгжлийн бодит байдлын түвшнийг тодорхой хэмжээгээр илэрхийлж байдаг.

Манай улсын хувьд хөдөлмөрийн насны хүмүүсийн ажил эрхлэлт хангалтгүй, орлого бага зэрэг нийгэм эдийн засгийн тогтворгүй нөхцөл байдлаас шалтгаалан хулгайлах, залилах ... зэрэг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн гаралт судалгаанаас үзэхэд буурахгүй, байнга өсөж байгаа нь харагдаж байна[27].

Аливаа төрөөс нийгэм, ард түмнээ айх аюулгүй амгалан тайван байдлыг хангах зорилгоор эрүүгийн хуулийг батлан даган мөрдүүлдэг. Эрүүгийн хууль нь тухайн нийгэм, ард иргэдэд аюул заналхийлэл учруулдаг, учруулж болзошгүй гэмт үйлдэл, эс үйлдэхүйгээс хамгаалах, түүний хэрэглээг зохицуулах чиг үүрэг бүхий эрх зүйн хэм хэмжээнүүдийн нийлбэр байдаг[28].

Хүн төрөлхтөн оюун ухаанаа бусдын ашиг сонирхлыг зөрчих, хор уршиг учруулахад ашиглаж ирсэн нь түүхийн хуудаснаа тэмдэглэгдсэн нь олонтоо бий. Үүний хамгийн хор аюултай илрэл нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдэхэд гэмт этгээдийн зүгээс бусдын өмчлөх эрхэд хууль бусаар халдах явдал юм.

“Залилах”- заль башир гаргах, заль хэрэглэх, хууран мэхлэх гэсэн утгатай[29] бөгөөд хэн нэгнийг ямар нэгэн үнэ цэнтэй зүйлээс нь салгахад эсвэл хууль ёсны эрхээсээ татгалзахын тулд үнэнийг санаатайгаар гуйвуулах гэж тайлбарлагддаг байна.

“Залилах гэмт хэрэг”[30] нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, хүч хэрэглээгүй ашиглан шамшигдуулах нэгэн хэлбэрийг нэрлэж ирсэн эрүүгийн эрх зүйн уламжлал болсон нэр томьёо юм.

Мэхлэх- заль мэх хэрэглэн хуурах; хүмүүсийг мэхлэх (хүмүүсийг арга зальдаа итгүүлж хуурах) гэх зэргээр уламжлал талаас нь тайлбарласан байх ба судлаачийн зүгээс судалгааны ажилдаа “залилах” гэсэн томьёог ашигласан болно. Судлаачдын судалгааны бүтээлээс харахад залилан мэхлэх, залилах гэсэн байх бөгөөд энэ нь хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн үйлчлэл, нэр томьёотой холбоотой юм.

Залилах нь олон зууны туршид цөөн хэдэн алдартай хэргүүдээр тэмдэглэгдсэн илүү хязгаарлагдмал үйл ажиллагаанаас жилд олон тэрбум

---

[27] *Х.Доржпалам “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн” /тусгай анги/.УБ.,2021, 115 дах тал*
[28] *Мөн тэнд /тусгай анги/.УБ.,2021, 5 дах тал*
[29] https://www.merriam-webster.com/dictionary/fraud
[30] *“Заль”- Арга мэх, бааш: **заль гаргах** (ов мэх гаргах)*
“Заль мэх”- хууран мэхлэх арга, башир ов
“Залилах”- заль башир гаргах, заль хэрэглэх, хууран мэхлэх
*“Залилан”- Залилах, мэхлэх гэмт хэрэг: **залилан хийх** (хуурамч аргаар бусдын юмыг шамших, мэхлэх явдал), **залилангийн хэрэг** (бусдын өмч хөрөнгө, эд зүйлийг заль мэх хэрэглэн булаасан хэрэг)*
“Хууран мэхлэх”- итгүүлэн хуурах

долларын ашиг олдог технологийн тусламжтайгаар өргөн тархсан оролдлого болж өөрчлөгдсөн[31] байна.

Залилах гэмт хэргийн анхны тохиолдол нь МЭӨ III зуунаас эхтэй бөгөөд МЭӨ 300 онд Грекийн тэнгисийн хоёр худалдаачин усан онгоц, ачаа тээшиндээ даатгал авч өөрсдийгөө баяжуулах төлөвлөгөө зохиожээ. Гэрээний дагуу тэд бараагаа зарсныхаа дараа зээлсэн мөнгөө хүүтэйгээр эргүүлэн төлөх шаардлагатай болсоноос үүдэн усан онгоцыг живүүлсэнээр тэдний үйлдэл илчлэгдэж, хуулийн дагуу хариуцлага хүлээсэн ажээ.

МЭ 193 онд Ромын эзэн хаан Пертинаксыг торгон цэргийн анги гэж нэрлэдэг тусгай бүлэг цэрэг хороожээ. Тэд эзэнт гүрнийг хамгийн өндөр үнээр худалдан авагчдад 1 тэрбум фунтээр худалдах төлөвлөгөө гаргасан байна. Цэргүүд хамгийн өндөр үнээр худалдан авагч Жулианусыг өөрсдийнх нь биш нэг зүйлийг зарж залилсан үйлдлийг эзэн хаан хүлээн зөвшөөрөөгүйгээс "Таван эзэн хааны жил" хэмээн нэрлэгдэх болсноор иргэний дайн дэгдсэн байна.

1821 онд өмч хөрөнгийн залилан газар дээрээ дэлбэрсэн ба энэ нь зарж борлуулах хүч биш, харин хэзээ ч байгаагүй газар нутаг байлаа. Грегор Мак Грегор хөрөнгө оруулагчдыг байшин барихад тэдний мөнгийг хөрөнгө оруулсан гэж итгүүлжээ.

1911 онд Евдуардо де Валиферно Луврын уран зургийн галерейгаас Мона Лизагийн зургийг хулгайлжээ. Тэрээр эх хувийг биш, хуурамч хувийг газар доорх цуглуулагчдад зарахыг хүссэн оролдож байсан байна.

1920 онд хөрөнгө оруулалтын түгээмэл залилах гэмт хэргийн нэг болох Понзи төлөвлөгөөг боловсруулсан байна[32]. Олон жилийн турш Понзид тоо томшгүй олон төлөвлөгөө байсан бөгөөд анхны төлөвлөгөөгөө 1920 онд хэрэгжүүлсэн юм. Америкийн Чарльз Понзи эх орондоо шуудангийн ваучер худалдан авч, гадаадад гаргана 5%-ийн ашиг олж болохыг олж мэджээ. Тэрээр хөрөнгө оруулагчдад зарахдаа үлдэгдлээ хэтрүүлж, 50%-ийн ашиг олох амлалт өгдөг байв. Хөрөнгө оруулагчид түүнд мөнгөөр анхны хөрөнгө оруулагчдаа илүү их ашгийг өгч байгаа мэтээр итгүүлэн сүүлийн хөрөнгө оруулагчдын мөнгөөр түүнийг төлдөг байсан байна. Сүүлдээ энэ аргаа илүү нарийн боловсруулснаар 10 сая ам.долларын орлого олж, эх орноосоо дүрвэсэн байна.

1980-аад оны сүүлээс технологийн хөгжил дэвшилд залилах гэмт хэргийг үйлдэхдээ илүү нарийн зохион байгуулалттайгаар үйлдэх болжээ. Тухайлбал: хуурамч чек, валют тараахаас эхлээд кредит картыг хуурамчаар үйлдэх болсон байна. Гэмт хэрэгтнүүд хүмүүсийн мэдээллийг ашиглаж, хохирогчдын тоо жилээс жилд нэмэгдсээр байна.

1990 оноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа явуулдаг компаниуд нь банк шиг үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд дэлхийн олон улсад муу хөрөнгө оруулалт хийж уг компани эзэд зориудаар дампууран хөрөнгөжих залилах гэмт хэрэг ихээр гарах болсон байна.

2000 оноос эхлэн хувь хүний мэдээллийг хуурамчаар ашиглан банкин дахь дансыг ашиглах, өмчлөх эрхэд нь халдах залилах гэмт хэрэг ихээр гарч эхэлсэн байна. Тухайлбал: 2016 онд Японд 13 сая америк долларын хохирол учруулсан бөгөөд залилах гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүд нь Япон даяар АТМ-

[31] https://www.trulioo.com/blog/history-fraud-2
[32] *anuharchu.medium.com*

д Өмнөд Африкийн банкны картын мэдээлэл бүхий 1600 хуурамч кредит картыг ашигласан томоохон гэмт хэрэг гарч байсан байна..

2017 оноос криптовалютын биржүүд цахим санхүүгийн үйл ажиллагааны платформыг бий болгон залилах гэмт хэрэг үйлдэх боломжийг бий болгосон байна.

Decentralised Finance (DeFi) платформууд нэмэгдсэний улмаас луйварчид крипто-д суурилсан үйлдлүүдийн нэрээ нууцлах, тогтворгүй байдлыг ашиглан крипто залилангийн үйлдлийг үйлдэж эхэлсэн ба 2020 онд залилах гэмт хэрэг үйлдэгчид Ковид-19 цар тахлын нөхцөл байдлыг ашиглан фишинг имэйл илгээж, хуурамч урамшууллын мэдэгдэл хийж, цахим технологийг ашиглан хуурамч энэрлийн байгууллагуудыг ажиллуулан залилах гэмт хэрэг үйлдэж байна.

2021 онд 14 сая америк доллар крипто залиланд алдсан гэсэн бүртгэл байдаг. Том хэмжээний хөрөнгө оруулалтын залилах гэмт хэрэг, түүний дотор анхан шатны зоос, насос болон хаягжуулалтын схем, зах зээлийн манлайлал, Ponzi схем санал болгон уг гэмт хэргийг үйлдсээр байна. Тухайлбал OneCoin буюу крипто дээр суурилсан Понзи схем нь эргэлзээгүй залилах гэмт хэргийн нэг төрөл бөгөөд одоогоор хөрөнгө оруулагчдын 4 тэрбум америк долларын мөнгийг залилсан хохирол учруулаад байна.

Харин 2022 онд хамгийн ихээр анхаарал татаж буй гэмт хэрэг бол олон улсад ROMANCE SCAM гэж нэрлэгдэж буй шинэ төрлийн залилах гэмт хэрэг юм. Уг гэмт хэргийг цахимаар, хилийн чанадаас үйлдэж байгаа бөгөөд хохирогчтой чин сэтгэлээсээ ярилцаж байгаа дүр эсгэн, итгэл төрүүлж, 3-6 сарын хугацаанд хайр дурлалын сэдвээр яриа өрнүүлж, урхиддаг байна. Эмэгтэйчүүд англи хэлээ сайжруулна, гадны хүнтэй сууж баян тансаг амьдран, гадагшаа явна гэсэн зорилгоор гадны иргэнтэй сошиал орчинд найз болох тохиолдол их байдаг, үүний цаана ихэвчлэн улс дамнасан залилах хэрэг үйлдэгчид бүлэглэн нарийн зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулж байдаг. Тэдний арга нь ихэвчлэн гадаадад амьдрах урилга явуулна, чиний нэр дээр илгээмж явуулна, танай улсад үл хөдлөх хөрөнгө худалдаж аваад амьдарна, энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаа цалингаа шууд чиний дансанд чинь байршуулая гэх мэтээр их хэмжээний ашиг амлаж, энэ бүхнийг хийхийн тулд шимтгэл төлөх хэрэгтэй гэж итгүүлэн олон удаагийн үйлдлээр их хэмжээний мөнгө шилжүүлж авдаг. Ингээд зогсохгүй данс болон интернэт банкийг нь ашиглаж олсон мөнгөө дансруу нь шилжүүлэн, гадаад улсын өөр дансруу шилжүүлүүлж авах замаар залилах гэмт хэрэг үйлдэж байна.

Дэлхийн түүхэн дэх хамгийн сонирхолтой залилах гэмт хэрэг үйлдэж байсан баримтуудыг судалж үзвэл[33]:

1. МЭӨ 300 он – Хамгийн анхны залилангийн оролдлого

Луйврын түүхийг авч үзэхийн тулд МЭӨ 300 оноос эхлэх хэрэгтэй. Грекийн далайн худалдаачин Хегестратос хөлөг онгоц болон ачаандаа даатгал хийлгэж байсан бөгөөд энэ даатгалыг тухайн үед “ёроол” гэж нэрлэдэг байсан байна.

Худалдаачин мөнгө зээлж, хөлөг онгоц зорьсон газартаа хүрч ачаа болон эрдэнэ шишийг хүргэж өгсний дараа зээлийг хүүтэй нь буцааж төлдөг. Зээлээ төлөөгүй тохиолдолд завь болон түүний ачаа, барааг ачааных нь үнээр эргүүлэн авна. Харин залилангийн хамгийн анхны оролдлого болох Хегестратос хоосон

[33] https://www.experian.co.uk/blogs/latest-thinking/fraud-prevention/5-of-the-most-remarkable-instances-in-the-history-of-fraud/

хөлөг онгоцоо живүүлж, эрдэнэ шишийг халхалж, зээлээ хадгалахаар төлөвлөсөн нь бүтэлгүйтэж байсан байна[34].

2. **МЭ 193 он – Таван эзэн хааны жил**

Одоогоос 500 орчим жилийн өмнө Ромын эзэнт гүрний үед залилах гэмт хэрэг үйлдэгддэг байсан бөгөөд тухайлбал: Эзэн хаан Пертинакст үнэнч байх ёстой тусгай бүлэг цэрэг буюу торгон цэргүүд эзэн хааныг алж, хамгийн өндөр үнээр Ромын эзэнт гүрнийг худалдаалах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Уг этгээд Юлианус байсан бөгөөд одон орон судлалын хувьд армийн цэрэг бүрд 250 ширхэг алт санал болгосон нь өнөөгийн 1 тэрбум орчим ам.доллартай тэнцэж байна. Харуулууд бусдын ямар нэг зүйлийг зарсан үйлдлийг санхүүгийн залилан хэмээн үзэж байжээ.

3. **1821 он – Төсөөллийн ноён оргил[35]**

Грегор Макгрегор бол Шотландын армийн генерал байв. Тэрээр хууль ёсны бөгөөд гайхалтай дайны ололт амжилтаараа жижиг арлыг байлдан дагуулж, "казик" буюу ханхүү болжээ. Энэ газар нь Полис нэртэй бөгөөд жижиг арал улсыг бүрдүүлэхийг оролдож байв. Тэрээр хөрөнгө оруулагчдаа тансаг байшин барина гэж амласан ба түүний амлалтын дагуу хүмүүс түүн рүү хошуурч, олон байшин худалдан авч, зарим нь өөрийн хөрөнгөө түүний зохиосон мөнгөн тэмдэгтээр сольж, залилуулан юу ч үгүй үлдсэн байна.

4. **1920 он – Понзи[36]**

Олон жилийн турш Понзид тоо томшгүй олон төлөвлөгөө байсан бөгөөд анхны төлөвлөгөөгөө 1920 онд хэрэгжүүлсэн юм. Америкийн Чарльз Понзи эх орондоо шуудангийн ваучер худалдан авч, гадаадад гаргана 5%-ийн ашиг олж болохыг олж мэджээ. Тэрээр хөрөнгө оруулагчдад зарахдаа үлдэгдлээ хэтрүүлж, 50%-ийн ашиг олох амлалт өгдөг байв. Хөрөнгө оруулагчид түүнд мөнгөөр анхны хөрөнгө оруулагчдаа илүү их ашгийг өгч байгаа мэтээр итгүүлэн сүүлийн хөрөнгө оруулагчдын мөнгөөр түүнийг төлдөг байсан байна. Сүүлдээ энэ аргаа илүү нарийн боловсруулснаар 10 сая ам.долларын орлого олж, эх орноосоо дүрвэсэн байна.

5. **1792 онд АНУ албан ёсоор тусгаар тогтнолоо олж авснаас хойш хэдхэн жилийн дараа тус улсад анхны залилан гарсан байна[37].**

Ерөнхийлөгч Жорж Вашингтоны парламентын гишүүн, сангийн яамны нарийн бичгийн даргын туслах Уильям Дуэр дотоод мэдээллээс ашиг олж болох хамгийн тохиромжтой хүн байсан бөгөөд тэрээр төрийн сангийн бүх үйлдлүүдийг мэддэг учир үнэ өсөх мэдээллийг олон нийтэд дэлгэхээсээ өмнө найз нөхдөөө урьдчилан мэдэгдэж, багцын арилжаа хийдэг байв. Олон жилийн турш ийм төрлийн заль мэх хэрэглэж, өндөр бооцоо тавихын тулд төрийн сангийн хөрөнгө завшиж байсан ба У.Дуэр албан тушаалаа орхисон ч дотоод холбоогоо

---

[34] *Энэ нь санхүүгийн залилангийн гэмт хэргийн анхны бүртгэгдсэн тохиолдол бөгөөд түүнээс хойш олон удаа уг төрлийн гэмт хэрэг гарч байсан байна.*

[35] https://www.experian.co.uk/blogs/latest-thinking/fraud-prevention/5-of-the-most-remarkable-instances-in-the-history-of-fraud/

[36] *anuharchu.medium.com*

[37] https://www.investopedia.com/articles/financial-theory/09/history-of-fraud.asp

хадгалсаар байжээ. Тэрээр өөрийн болон бусад хөрөнгө оруулагчдын мөнгийг банкнуудын хувьцаанд хөрөнгө оруулалт хийсээр байсан байдаг[38].

Эдгээр залилах үйлдлүүд нь тухайн цаг үеийн хамгийн дуулиантай хэргүүдэд тооцогдож байжээ.

Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт өмчлөх эрхийн халдашгүй байдлыг зөрчихөөс хамгаалсан нэг төрлийн харилцаагаар, өөрөөр хэлбэл төрлийн объектоор ангилан хуульчилсан юм. Энэ төрлийн гэмт хэргийн объект буюу зөрчихийг хориглож, эрүүгийн хуулиар хамгаалсан харилцаа бол өмчлөх эрхийн халдашгүй байдал юм. Нийтийн болон хувийн өмчийн эзэн /өмчлөгч, эзэмшигч, хариуцагчаас/-ээс өөр хэн ч халдаж үл болохыг халдашгүй эрх гэнэ. Энэхүү халдашгүй эрхэнд эзний зөвшөөрөлгүйгээр, эсхүл хуулиар зөвшөөрсөн үндэслэл, журмыг зөрчиж халдахыг хууль бус явдал буюу нийгэм, иргэдэд хохирол учруулсан гэмт хэрэг, халдагч нь гэмт хэрэгтэн болдог[39].

Залилах гэмт хэрэг гэдэг нь иргэдийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхэд халдсан, нийгэмд аюултай, Эрүүгийн хуульд заасан гэм буруутай үйлдэл байдаг.

Дэлхийн олон улсад үйлдэгдэж хүрээгээ тэлсээр байгаа залилах гэмт хэргийн талаарх эрдэмтэн, судлаачдын онол, үзэл баримтлалыг авч үзвэл:

1. Дональд Р.Крессей нь залилах гэмт хэргийн талаарх хамгийн өргөн тархсан онол бол 1950-аад оны судалгаанд үндэслэн хийсэн таамаглал юм. Крессейн загварыг залилангийн гурвалжин гэж нэрлэдэг. Залилангийн гурвалжин[40] нь залилах үйлдлийн ердийн урьдал нөхцөл болох боломж, *дарамт буюу шаардлага ба ухаалаг тайлбар* гурвын нэгдэл гэж үзжээ.

Энэ загвар нь анх Donald Cressey-ийн залилангийн гурвалжин буюу FRAUD TRAINGLE (J. & Cressey, 2008) гэдэг загварт үндэслэн тодорхойлсон[41] юм.

Доналд Крессей (1953) санхүүгийн залилангаас болж хоригдсон хэдэн зуун хүмүүстэй шоронгийн нөхцөлд ярилцлага хийж ямар ч тохиолдолд залилан гарахад “Шаардлага, боломж, ухаалаг тайлбар” гэсэн үндсэн гурван төрлийн хүчин зүйл нөлөөлдөг гэж үзсэн[42]. Өөрөөр хэлбэл тухайн этгээд залилан хийх хэрэгцээ шаардлага гарч, боломж бололцоо бүрдмэгц тухайн үйлдлээ хаацайлах

---

[38] *TreasuryDirect. “The 18th century.”Accessed June 26, 2020*

[39] *Мөн тэнд /тусгай анги/.УБ.,2021, 108 дах тал*

[40] *Монголын Криминологичдын холбооны судлаач М.Өүлэн судалгааны ажил*

[41] *Ютагийн их сургууль болон Калифорниагийн их сургуулиудын Christoper j.Skousen, Kevin R.Smith, Charlotte J.Wright нарын эрдэмтэд боловсруулсан байна.*

[42] *Cressey’s Fraud Triangle, Characteristics of Ponzi Perpetrators - The Politics of Ponzi Schemes: History, Theory, and Policy (ebrary.net) (Хамгийн сүүлд 2022.06.07-нд хандав)*

ухаалаг тайлбар олж гэмт хэрэг хийх нөхцөл бүрдүүлж байж сая залиланг үйлддэг байна.

“Боломж”- Боломж бол хуурамч үйл ажиллагааны чухал элемент[43] юм. Ухаалаг залилан мэхлэгчид хүсэл эрмэлзэл байж болох ч боломж бүрдээгүй тохиолдолд түүний үйлдэл нь үр дүнд хүрэхгүй байх магадлалтай. Доналд Крессейгийн үзсэнээр “Боломж” хэсэгт үндсэн хоёр зүйл байдаг бөгөөд эхнийх нь ерөнхий мэдээлэл. Ерөнхий мэдээлэл гэдэг нь албан тушаалаа ашиглан залилах зорилго бүхий үйлдэл хийх боломжтойг мэддэг ажилтны мэдлэгийг хэлдэг. Өөрөөр хэлбэл, ерөнхий мэдээлэлд хүмүүсийн итгэлийг эвдэх, эсхүл өөрийн байр суурийг ашиглан байгууллагын давуу талыг мэдэх явдал юм. Ажилчдын хөрөнгө бүртгэлийн мэдээлэлд нэвтрэх гэх мэт өргөн хүрээний боломжтой байх буюу дотоод хяналт сул байгаа нь залилагчдад боломж олгож буй нөхцөл байдлын нийтлэг жишээ болдог байна[44].

Доналд Крессейгийн тодорхойлсон хоёр дахь боломж бол техникийн ур чадвар юм[45]. Техникийн ур чадвар гэдэг нь үнэн хэрэгтээ залилах үйлдэл хийхэд шаардагдах ур чадварыг хэлнэ. Тухайн ажилчин нягтлан бодох бүртгэл хэрхэн яаж хийхийг мэддэг, хулгайн хэргийг нуун дарагдуулах зэрэг нь залилахад шаардагдах техникийн ур чадвар юм. Ерөнхий мэдээлэл болон техникийн ур чадвар хосолсны дээр залилах үйлдэл хийх хүсэлтэй ажилтнууд аюултай хослолыг бий болгож байна гэсэн үг.

“Шахалт, шаардлага”- Санхүүгийн дарамт бодитоор илэрч эсвэл ухамсарлагдаж болно. Бодит санхүүгийн дарамтын жишээ бол төлбөр, зээл, гэнэтийн зардал эсвэл их хэмжээний өр төлбөрөө барагдуулах боломжгүй байх явдал юм.

Ухамсарлагдаж болохуйц санхүүгийн дарамтад амьдралын хэв маягаа сайжруулах хүсэл эрмэлзэл, эсвэл хувь хүн өөрийн статусыг сайжруулах хүсэл зэрэг орно.

Д.Крессей бодит эсвэл хэрэгжих боломжгүй байгаа ухамсарлагдсан санхүүгийн дарамтыг дараах үндсэн зургаан ангилалд хуваж болно гэж үзжээ.

1*. Оруулсан үүргээ зөрчсөн:* Энэ төрлийн таамаглал нь нийгмийн хэм хэмжээний хувьд хүлээн зөвшөөрөгдөөгүй зүйлийн өмнө санхүүгийн бэрхшээлтэй тулгардаг нөхцөл байдлыг хэлдэг. Жишээлбэл, хэрэв нэр хүндтэй ажилчин нь мансууруулах бодист донтсоны улмаас өрөнд орсон тохиолдолд өр төлбөр бий болгосон үйлдэл нь маргаж болшгүй хэрэг тул санхүүгийн асуудлаа нууц болгон хадгалдаг байна[46].

2. *Хувийн бүтэлгүйтэл*: Хувийн алдаа дутагдал нь хувь хүний дүгнэх чадвар муу эсвэл санхүүгийн төлөвлөлтөөс үүдэлтэй санхүүгийн бэрхшээлийг хэлдэг. Нэмж хэлэхэд, гэмт хэрэгтнүүд бүтэлгүй үйлдлээсээ ичдэг тул тэд үүнийг нууцалж, ачааг өөртөө үүрүүлэх хандлагатай байдаг.

3. *Бизнесийн нөхцөл байдлын өөрчлөлт*: Эдийн засгийн уналт эсвэл компанийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний эрэлт буурах зэрэг хувийн алдаа гэхээсээ илүү гадны хүчин зүйлээс үүдэлтэй санхүүгийн дарамтыг үүнд

---

[43] *Залилах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа яюуулах мөрдөгчийн гарын авлага.УБ.,2021, 6 дах тал*

[44] *The Cressey fraud triangle Source: Adapted from Coenen (2008, p. 10)... | Download Scientific Diagram (researchgate.net)*

[45] *Cressey, D. R. (1953). Other People’s Money. Montclair, NJ: Patterson Smith, pp.1-300*

[46] *Mary-Jo Kranacher, Richard A. (Disk) Riley, Jr “Forensic Accounting and fraud examination”.2019, 7-8 дахь тал, Forensic Accounting and Fraud Examination - Mary-Jo Kranacher, Richard Riley - Google Books*

хамруулан ойлгоно. Хэрэв гадны хүчин зүйл нь ажилчдын амьжиргаанд заналхийлж байгаа бол зарим нь өөрсдийн байр суурь, амьдралын хэв маягаа хадгалж авч үлдэхийн тулд залилан мэхлэлт хийж эхэлдэг байна.

4. ***Бие махбодын тусгаарлалт*:** Энэ хэлбэрийн бэрхшээл нь санхүүгийн асуудалтай хүмүүст итгэх хэн нэгэн байхгүй, тэдний өмнө тулгарч байгаа асуудалд хэн ч зөвлөгөө өгөхгүй гэж бодоход үүсэх нөхцөл байдлыг илэрхийлдэг. Өөрийгөө ийнхүү бусдаас туслалцаа авах боломжгүй хүн гэж үзэх нь залилан хийхэд хүргэж болзошгүй.

5. ***Байр суурь олж авах:*** Энэ төрлийн шахалт, шаардлага нь хувь хүн өөрийн статус буюу байр сууриа дээшлүүлэх, амьдралын хэв маягаа сайжруулах гэсэн хүчтэй хүсэл эрмэлзлэлээс үүдэх санхүүгийн дарамт юм. Хүмүүс одоогийн амьдралдаа сэтгэл хангалуун бус, илүү үнэтэй материаллаг зүйлийг хүсэх эсвэл одоо байгаагаасаа өндөр статустай болохын тулд санхүүгийн дарамтад ордог.

6. Ажил олгогч ба ажилчдын харилцаа: Ажилтан хангалттай цалин аваагүй юм уу эсвэл хэт их ажил хийж, тэдгээр нь дутуу үнэлэгдсэн мэт санагдах үед ажилчид санхүүгийн дарамт мэдэрдэг гэж болно. Ажилчид санаа бодлоо байгууллагынхаа удирдлагад хүргэх нь албан тушаалаа бүр мөсөн алдахад хүргэж болзошгүй гэдэгт итгэж байгаа тохиолдолд санхүүгийн энэ дарамтын талаар бусадтай хуваалцалгүй үлддэг байна[47].

"Ухаалаг тайлбар"- Энэ нь гурвалжны гурав дахь гол элемент юм. Ухаалаг тайлбар нь залилан хийхээс өмнө залилагч гэмт хэрэг үйлдсэнээ хэрхэн зөвтгөдгийг хэлдэг. Боломж ба санхүүгийн дарамт шахалт байгаа үед олон залилагчид өөрсдийн үйлдлээ нийгмийн эсрэг гэмт хэрэг биш юм шиг санагдуулахын тулд өөрсдийн үйлдлээ ямар нэг арга замаар зөвтгөдөг. Залилах үйлдэл хийснээ ухаалгаар тайлбарлах хэд хэдэн жишээ дурдвал, ажилтан хулгайлагдсан мөнгөө буцааж төлөх шаардлага гарсан, ажилтанд хэцүү нөхцөлд байгаа гэр бүлээ тэжээхийн тулд мөнгө шаардагддаг, ажил олгогч өөрийг нь өрөвдөж байгаа юм шиг мэдрэмж төрдөг, ажилчдын цалин хангалтгүй байхад харин компанийн захирлууд нь маш их мөнгө хийдэг юм шиг санагддаг[48] гэжээ.

2. *Залилангийн масштаб онол:*[49] Доктор Стив Альбрехт бол залилангийн чиглэлээр судалгаа хийдэг мэргэжилтэн. 1980-иад оны эхээр, Альбрехт болон түүний хоёр туслах судлаач нар байгууллагынхаа залилангийн гэмт хэрэг үйлдэж байсан дотоод аудиторуудтай ярилцлага хийх замаар залилангийн сэдлийг өдөөгч хүчин зүйлсийн талаар судалгааг хийжээ[50]. (Albrecht, Howe, & Romney, 1984) Энэхүү судалгааг "Залилангийн гэмт хэргийг илрүүлэх: Дотоод аудиторын хэтийн төлөв" нэртэй номд нийтэлсэн байна. Альбрехтийн (1984) хийсэн судалгаагаар залилагчдын арван нийтлэг шинж чанарууд байдаг бөгөөд дор дурдсан шинжүүд тогтоогджээ.

1. Амьдралын утга учир нь нэг л зүйл байдаг;
2. Хувийн ашиг сонирхлын хэт их хүсэл эрмэлзэлтэй байх;
3. Их хэмжээний өртэй байх;
4. Үйлчлүүлэгчидтэй дотно холбоотой байх;
5. Цалин хөлс нь гүйцэтгэж буй үүрэгтэй нь дүйцэхгүй байгаа мэт санагдах;

---

[47] *Journal of Emerging Trends in Economics and Management Sciences (JETEMS) 3(3): 191-195 © Scholarlink Research Institute Journals, 2012 jetems.scholarlinkresearch.org*

[48] *Залилангийн гурвалжин – Criminology.mn цахим сайт*

[49] *Deterring fraud : the internal auditor's perspective in SearchWorks catalog (stanford.edu)*

[50] *W.Steve Albrecht, Keith R, Howe, Marshall B.Romney "Deterring fraud: the internal auditor's perspective" цахим сайт Deterring fraud : the internal auditor's perspective in SearchWorks catalog (stanford.edu)*

6. Тохиролцох чадвар сайтай байх;

7. Бүтцээ өөрчлөхийг шаарддаг, уриалдаг;

8. Мөрийтэй тоглоом тоглох зуршилтай;

9. Гэр бүл эсвэл эргэн тойрны хүмүүсээс дарамт мэдэрдэг;

10. Ажлын гүйцэтгэл нь хүлээн зөвшөөрөгдөхгүй байгаа мэт санагдах зэрэг 10 шинж тогтоогджээ.

Эдгээр нийтлэг шинж чанаруудын талаар дурьдахаас гадна Альбрехт өөрийн судалгаагаар залилангийн гурван үндсэн элемент нь “боломж, дарамт, үнэнч шударга байдлын түвшин”[51] юм гэж үзжээ. Энэ нь түгээмэл хэрэглэгддэг Кressейгийн судалгаагаар тодорхойлсон “Залилангийн гурвалжин”-ыг бүрдүүлдэг гурван элементтэй төстэй байна. Нэг том ялгаа нь ухаалаг тайлбар бий болгохын оронд тухайн хүний үнэнч, шударга байдлыг харгалзан үзэж багтаасан явдал. Альбрехт энэ гурван элементийн тухай ойлголтыг өөр өөр нөхцөл байдалд залилангийн эрсдэлийн түвшинг тодорхойлоход туслах зорилгоор “Залилангийн масштаб”[52] гэж нэрлэсэн зүйлийг бий болгосон гэжээ. Энэхүү хэмжүүр нь залилах магадлалтай хүнийг таамаглах алхмыг шат ахиулсан гэж судлаачид үздэг байна.

Судлаачийн хувьд доктор Стив Альбрехтын залилангийн масштабын онолын чиг хандлагыг дэмжиж байгаа бөгөөд уг онолын онцлог нь залилагчдын гэмт хэрэг үйлдэхдээ үзүүлдэг нийтлэг шинж чанаруудыг судалгааны үндсэн дээр нарийн тодорхойлсон байдаг. Онолын энэхүү үзэл баримтлал нь манай улсын хувьд залилах гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүдийн гэмт хэрэг үйлдэхдээ хэрэглэж буй арга, үйлдэлтэй хамгийн их дөхсөн, бодит байдалтай нийцэж байна гэж үзэж болохоор байна.

Учир нь дээрх 10 шинж чанарт тулгуурлан залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, залилах гэмт хэргийн хохирогчид залилах гэмт хэрэг үйлдэж буй этгээдийн үйлдлийн арга, үг үйлдэл, итгэл төрүүлж буй байдлаар нь таньж, өөрийгөө залилах гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх боломжтой юм.

3. *Дэвид Вольф, Дана Хермансон* нар “Залилангийн гурвалжин” онол дээр тулгуурлан залилангийн алмаз эрдэнийн тухай ойлголтыг нэвтрүүлсэн байна. Вольф ба Хермансон нь “Залилангийн гурвалжин” онол нь залилах үйлдэлд хүргэдэг олон чухал хүчин зүйлийг авч үзэхгүй байна гэж үздэг. Тиймээс тэд дөрөв дэх элемент болох “чадвар”-ыг загварт нэмж оруулахыг санал болгожээ. Вольф ба Хермансон нар нь чадварыг залилан гарахад зайлшгүй шаардлагатай шинж чанар гэж тодорхойлжээ. Энэхүү онолыг бүтээгчид хүн зорилготой, боломж бүхий, ухаалаг тайлбартай байх зэрэг нь шаардлагатай хүчин зүйлс гэж үздэг боловч гэмт хэрэг үйлдэхэд шаардлагатай ур чадваргүйгээр залилах гэмт хэрэг гарахгүй гэжээ.

Залилангийн алмаз эрдэнэ[53] бол залилах боломжийг зөвхөн нөхцөл байдал эсвэл хүрээлэн буй орчны хүчин зүйл гэж үзэхээс илүү гүнзгий харахыг оролддог онол юм. Тэд чадвартай хүн гэдэгт дараах шинжүүдийг багтаажээ[54].

---

[51] *Albrecht, C. C. (2008). Current Trends in Fraud and its Detection: A Global Perspective. Information Security Journal Vol.17. Retrieved from www.ebscohost.com on 11th June, 2014*

[52] *Deterring Fraud: The Internal Auditor's Perspective* Hardcover – January 1, 1984

[53] *European Journal of Business and Management “Fraud Triangle Theory and Fraud Diamond Theory: Understanding the Convergent and Divergent for Future Research”. 2015, paper 30-35* www.iiste.org

[54] *Fraud triangle and fraud diamond theory (linkedin.com)*

1. Байгууллагад тодорхой албан тушаал эрхэлдэг хэн нэгэн бусад мэдээлэл авах боломжгүй хүмүүст өөрийн албан тушаалаа ашиглан тусалдаг;

2. Дотоод хяналт сул байгааг ашиглан гэмт хэрэг үйлдэх ур ухаантай. (Залилах гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн талаас илүү хувь нь дор хаяж бакалаврын зэрэгтэй байна)

3. Өөрийгөө баригдахгүй гэдэгт бүрэн итгэдэг, өндөр эго бүхий хүн;

4. Бусдыг өөртөө итгүүлж чаддаг, бусдыг гэмт хэрэгтээ уруу татаж, үүнийг нь нууж чаддаг;

5. Сайн худлаа ярьдаг;

6. Стрессээ сайн зохицуулж чаддаг хүмүүс үйлддэг гэж үзжээ.

Ерөнхийдөө Вольф, Хермансон нар чадвар нь залилах зан үйлд чухал үүрэг гүйцэтгэдэг тул залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга барилыг өргөн хүрээнд үзэх хэрэгтэй гэж үзсэн байна.

4. Залилах сэдлийн M.I.C.E. онол[55]

Залилах сэдэлтэй холбоотой өөр нэг орчин үеийн онол бол M.I.C.E. юм. Энэхүү товчлолыг анх Баруун Виржиниагийн их сургуулийн профессор Жейсон Томас танилцуулж, 2010 онд *Forensic Accounting and Fraud Examination* буюу Шүүхийн нягтлан бодох бүртгэл, залилангийн шалгалт гэсэн сурах бичигт[56] оруулсан байна. M.I.C.E. гэдэг нь (money, ideology, coercion, ego) мөнгө, үзэл санаа, албадан ятгах, эго гэсэн үгсийн товчлол бөгөөд Томас залилангийн гэмт хэргийг сэдэлжүүлэгч нь дөрвөн хүчин зүйл гэж үзэж байгаагаа илэрхийлжээ[57]. Энэ онолыг “Залилангийн гурвалжин” онолын “шахалт, шаардлага” хэсгийг дэлгэрүүлсэн хувилбар гэж үзэж болно. M.I.C.E үзэл баримтлалд эдийн засаг, санхүүгийн ашиг олох нь бүх залилагчдын сэдэл биш юм гэж тайлбарлаад мөнгө өдөөгч хүчин зүйл нь бодит болоод ухамсарлагдсан санхүүгийн дарамтууд байдаг. Залилан нь үзэл санаагаар өдөөгдсөн тохиолдолд гэмт хэрэг үйлдэгч түүний үйлдэл нь илүү сайн ашиг тусыг өгнө гэж үздэг, эсвэл тодорхой дүрмийг дагаж мөрдөх нь түүний итгэл үнэмшилтэй зөрчилдөж, харшилна гэж үзжээ. Харин албадан ятгах гэдэг нь хэн нэгэн нь гэмт хэрэг үйлдэхийг хүсээгүй, дарамт шахалтанд өртөх, эго нь санхүүгийн шахалт, шаардлагатай гэх ойлголттой нягт холбоотой бөгөөд эрх дархтай, бахархах мэдрэмжийг агуулдаг бөгөөд энэ ойлголт нь санхүүгийн дарамт (мөнгө), эго, шахалт, ховор тохиолдолд үзэл санааны нөлөөтэй зэрэгцэн залилах гэмт хэргийг өдөөх чухал хүчин зүйл болдог. Тиймээс эдгээр бусад өдөөгч хүчин зүйлсийг багтаан судалсан судалгаагаар туршлагаа өргөжүүлдэг байгууллага, ажилтнууд залилан мэхлэгчийг илрүүлэх оролдлогод илүү амжилттай байна гэж үзсэн байна.

Дэлхийн улс орнууд сүүлийн жилүүдэд залилангийн гэмт хэрэг үйлдэж, ял эдэлж байгаа хүмүүсийн нийгмийн нөхцөл байдал буюу хүрээлэн буй орчин, гэмт хэрэг үйлдэх шалтгаан нөхцлийн талаар судлах тал дээр илүү анхаарал тавьж ажиллахаас гадна сэтгэл судлалын шинжлэх ухааныг судалгаандаа өргөнөөр ашиглаж байна. Үүний дагуу бие хүний хэв шинжүүдийг, хууль зүйн салбарын онол, судалгаатай хослуулан практикт ашиглаж эхэлсэн нь үр дүнгээ өгч байгааг тэдгээр улсуудын туршлага харуулж байна.

---

[55] *Залилах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах мөрдөгчийн гарын авлага.УБ.,2021, 10 дахь тал*

[56] *Forensic Accounting and Fraud Examination: Kranacher, Mary-Jo, Riley, Richard, Wells, Joseph T: 9780470437742: Books (amazon.com)*

[57] *What Is Forensic Accounting And Fraud Examination? (trendingaccounting.com)*

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт заасан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн төрөлд залилах гэмт хэрэг хамаарч буй шалтгаан нь төрлийн обьектоороо нийтлэг юм.

Тэгвэл залилах гэмт хэрэг нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн нийтлэг шинжийг агуулахаас гадна өөрийн гэсэн онцлогтой.

Залилах гэмт хэрэг гэж бусдын өмчлөх эрхэд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэм аюултай, гэм буруутай үйлдэл юм[58].

2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: Залилах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний онцлог нь:

А. Хуурч /залилан мэхлэгчид хохирогч эд хөрөнгөө сайн дураараа шилжүүлэн өгөхөд хүрэхүйц итгэл төрүүлэхээр үнэмшүүлэн ярьж хууран мэхэлсэн байх/[59]

Хуурах гэж бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар олж авахын тулд үгээр буюу үйлдлээр эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэхийг ойлгоно[60].

Онолын хувьд хуурч мэхлэхийг “ашиглан шамшигдуулах арга болохын хувьд худал мэдээ сэлт өгөх буюу заавал мэдээлэх нөхцөл байдлын талаар дуугүй өнгөрөх явдал мөн” [61] гэж үздэг. Шүүн таслах ажлын практикт хуурч мэхлэхийг “бусдын эд хөрөнгө, түүнийг өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар олж авахын тулд үгээр буюу үйлдлээр, бодит байдлыг гуйвуулах, нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэхийг хэлнэ.

Хуурч мэхлэх арга нь худал хэлэх, хуурамч баримт бичиг, факс, дүрс болон дуу авианы бичлэг техник хэрэгсэл, компьютерийн мэдээлэл, сүлжээ ашиглах буюу тусгай албаны хувцас, хэрэглэл, цол, тэмдэг хэрэглэж зориудаар төөрөгдүүлэх, дутуу буюу зориулалтын бус, эсхүл хуурамч буюу чанарын доголдолтой эд зүйлээр төлбөр хийх зэргээр илэрнэ”[62] гэж ойлгож байв.

Б. Баримт бичиг /өөр хүний, хуурамч, зассан баримт бичиг үзүүлэх, ашиглах, тодорхой хугацааны дараа баримт бичгийг гарган өгөхөө илэрхийлэн бичиж баталгаа гаргах, ижил нэртэй хүн, аж ахуйн нэгжийн баримт бичиг үзүүлэх ... зэрэг/, эд зүйл /хуурамч, бүрэн бус, зориулалтын бус, чанаргүй, гологдмол эд зүйлээр солио хийх, өөр хүний эд зүйл авчран өгч сольж авах ... зэрэг/, цахим хэрэгсэл ашиглаж /email, message бичиж илгээх, интернет худалдаа хийх нэрээр өөр компани, хүний нэрийн өмнөөс харилцаж, өөрийн данс уу мөнгө шилжүүлэн авах, эзнийг хуурч авсан банкны карт, пин кодыг ашиглан АТМ-ээс мөнгийг авах ... зэрэг цахим хэрэгслээр дамжуулан хуурч мэхэлсэн үйлдлүүдийн үр дүнд эд хөрөнгөө шилжүүлж өгсөн байх/[63],

---

[58] *С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй тусгай анги/сурах бичиг/. УБ.,2018. 186 дахь тал*
[59] *Х.Доржпалам “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн” /тусгай анги/.УБ.,2021, 115 дах тал*
[60] *Мөн тэнд “Эрүүгийн эрх зүй” /тусгай анги/ сурах бичиг.УБ, 2018, 187 дах тал*
[61] *С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй/Тусгай анги/. УБ., 1998. 138 дахь тал*
[62] *С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй, үзэл баримтлал, уламжлал, сургамж. УБ., 2019.197 дахь тал*
[63] *Х.Доржпалам “Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн” /тусгай анги/.УБ.,2021, 116 дах тал*

Судлаач С.Гантулга, Б.Энхболд нар бүтээлдээ тодорхойлохдоо баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах гэж бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар авахын тулд хуурамч бичиг баримт, эд зүйл, цахим хэрэгсэл, цахим сүлжээ, цахим мэдээлэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, техник хэрэгсэл ашиглах, тусгай албаны хувцас, хэрэглэл, цол, тэмдэг хэрэглэж зориудаар төөрөгдүүлэх, дутуу буюу зориулалтын бус, эсхүл хуурамч буюу чанарын доголдолтой эд зүйлээр төлбөр хийх зэргийг ойлгоно[64].

В. Зохиомол байдлыг зориудаар бий болгох /хань хамсаатныгаа цагдаа, авлигын ажилтан, хахууль өгснийг мэдсэн хүн болгон яриулж, үйлдсэн хэрэг нь илрэх гэж байгаа мэт ойлголт төрүүлж, илчлүүлэхгүй, хорьж цагдуулахгүй, аргалж өгч туслана гэж мөнгийг авах, шинжилгээний хариуг зориуд буруу гаргаж, хүнд өвчин илэрсэн мэт ойлголт өгч эмчлүүлэхэд туслана гэж мөнгө, эд хөрөнгийг авах ... зэргээр хохирогч эд хөрөнгөө түүнд өгөхөөс өөр аргагүй эмзэг асуудлын талаар бодит байдлыг зориуд гуйвуулсан худал мэдээлэл тараах, зохиомол нөхцөл байдал бий болгож итгүүлэн үнэмшүүлсэн байх/

Зохиомол байдлыг зориудаар бий болгох гэж эд хөрөнгийн эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх, хууран мэхлэхийн тулд зохиомол байдлыг зориуд бий болгохыг ойлгоно [65] . Тухайлбал, өөрийгөө амжилттай бизнесмен, баян, их хэмжээний эд хөрөнгийн өв залгамжлагч, томоохон үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч мэтээр зохиомол байдлыг бүрдүүлж болно.

Г. Сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж /лам, үзмэрч, бөө, бариачийн дүрээр мэргэлэх, бөөлөх, судас барьж үзэх зэргээр жүжиглэж, аргалж, эмчлэн эдгэрүүлж өгнө, эсхүл эд хөрөнгө нь өөрт таарч, тохирохгүй байгаа мэтээр ойлголт төрүүлэн итгүүлснээс эд хөрөнгө, эрхийг өөртөө шилжүүлэн авах ... зэргээр/

Сүсэг бишрэлийг далимдуулах гэж бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар авахын тулд хохирогчийн сүсэг бишрэл, шашны итгэл үнэмшлийг ашиглан төөрөгдүүлэхийг ойлгоно. Тухайлбал, бусдыг бөө болгож өгөх, хохирогчид болон түүний ойр дотны хүнд таагүй зүйл тохиолдохоос “аргалах” зэргээр хохирогчийг төөрөгдүүлж, түүнээс мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авах явдал түгээмэл байна.

Д. Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах гэж дампуурсан, үйл ажиллагаа нь зогссон, доголдсон, санхүүгийн алдагдалтай, хөрөнгө оруулалт шаардлагатай байдлыг нуух, хуурамч аудитын дүгнэлт гаргуулах зэргээр бусдыг төөрөгдүүлж, эд хөрөнгө, эд хөрөнгийг өмчлөх эрхийг шилжүүлэн авсан байхыг ойлгоно.

Е. Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж /нэр алдартай хүмүүсийн, эцэг, эх, ах, эгч, дүү, найз нөхдийн сайн харилцаатай байсан, сайн сайхан үйл хэргийн эздийн нэрийг ашиглаж, тэдний үр хүүхэд, ах, дүү, найз, хамтрагч гэж өөрийгөө хохирогчид ойлгуулан итгэлийг олсон, эд хөрөнгөө өгөхөд гол хөшүүрэг болсон байх/[66] өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол гэж залилан мэхлэгчдийн түгээмэл хэрэглэдэг, тус бүрдээ бие даасан гэмт хэргийн бүрдлийг хангаж чадах үйлдлийн аргуудыг хориглон хуульчилсан.

---

[64] *С.Гантулга, Б.Энхболд “Эрүүгийн эрх зүй” /тусгай анги/ сурах бичиг.УБ, 2018, 187 дах тал*
[65] *Мөн тэнд 187 дах тал*
[66] *Х.Доржпалам “МонголУлсын Эрүүгийн эрх зүй”.УБ.,2021, 116 дах тал*

Өөрөөр хэлбэл, нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах явдал юм. Тухайлбал, урьд эрхэлж байсан ажил, албан тушаал, нэр хүндийг ашиглах, олон жил хамтран бизнес хийсэн, гэрээт борлуулагчаар ажилласан, олон жилийн өмнөөс бие биенээ мэдэх болсон байдал, итгэлийг урвуулах зэрэг хэлбэртэй байж болно[67].

Бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн, авсан гэж хуульд заасан арга хэрэглэж, хохирогчийг төөрөгдүүлсний үндсэн дээр түүний зөвшөөрлийн дагуу хариу төлбөргүйгээр, бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг өөрийн өмчлөлд хууль бусаар авах үйлдлийг хэлнэ.

Энэхүү хэргийг үйлдсэн гэм буруутай этгээдийг 450-14.000 нэгжтэй тэнцэх буюу 450.000 -14 сая төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цагийн нийтэд тустай ажил хийлгэх, 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх үндсэн ялын төрлөөс гэм буруутай этгээдийн хувийн байдалд тохируулан сонгож хэрэглэх боломж олгосон.

Хүндрүүлэх бүрэлдэхүүн /ЭХ-ийн 17.3.2 дах хэсэг/

Залилах гэмт хэргийг үйлдсэн этгээд:

А) Албан тушаалын байдлаа ашиглаж /албан тушаалын эрх мэдлээ бусдын эд хөрөнгийг залилан авахад ашигласан байх/,

Албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн гэж хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагын шийдвэр, гэрээний үндсэн олгогдсон албаны бүрэн эрх, албан тушаалын байдлаа бусдыг залилж, түүний эдх хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг хууль бусаар шилжүүлэн авах гэмт үйлдэлдээ давуу тал болгон ашигласан байхыг ойлгоно. Тухайлбал, гэмт үйлдлийг хялбарчлах, хууль, захиргааны хэм хэмжээний акт болон бусад байдлаар эрх олгогдсон этгээд үйлдсэн байхыг шаардах ойлголт юм.

Б) Бусдад ноцтой /хохирогчийн амьжиргаагаа залгуулдаг байсан эх үүсвэрээс салгасан, үнийн дүн их байхыг шаардахгүй/, эсхүл их хэмжээний /50 мянган нэгжтэй тэнцэх буюу 50 сая төгрөгнөөс дээш эд хөрөнгийн/ хохирол учруулж үйлдсэн бол гэм буруутай этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ үйлийн 1 дэх хэсэгт зааснаас хүндрүүлэн 10.000- 40.000 нэгжтэй тэнцэх буюу 10-40 сая төгрөгөөр торгох, эсхүл 2-8 жилийн хорих ял шийтгэнэ[68].

Бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эдийн засгийн ач холбогдол бүхий эд хөрөнгийн эрхэд хохирол учирсан, эсхүл тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээний хохирол учруулсныг[69] ойлгоно.

Хүндрүүлэх бүрэлдэхүүн /ЭХ-ийн 17.3.3 дах хэсэг/

Залилах гэмт хэргийг үйлдсэн этгээд:

А) Байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон /бусдыг залилан мэхэлж эд хөрөнгийг авч, түүнээс олсон орлогоороо амьдралаа залгуулдаг болсон байх/,

Байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэж залилах гэмт хэргийн гурав ба түүнээс дээш удаа үйлдэж хууль бус орлогоороо өөрийгөө болон гэр

[67] *С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй тусгай анги/сурах бичиг/. УБ.,2018. 188 дахь тал*
[68] *Х.Доржпалам "Монгол Улсын Эрүүгийн эрх зүй" /тусгай анги/.УБ.,2021, 116 дах тал*
[69] *Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2015. 2.5 дугаар 4.1 дэх хэсэг*

бүл, бусдыг тэжээн тэтгэж байгаа явдлыг ойлгоно[70]. Зарим эрдэмтэд “гэмт хэргийн систем” гэж томьёолох гэж оролдсон байна[71].

Байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэх шинж нь тухайн гэмт хэргийг харьцангуй удаан хугацаанд тогтвортой буюу гурав ба түүнээс дээш удаа үйлдэж, уг гэмт хэргийг үйлдэж олсон орлогоо өөрийн болон гэр бүл, хамаарал бүхий хүмүүсийнхээ амьжиргааг залгуулах гол эх сурвалж эсхүл үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ зэрэг бусад ашиг олох зорилготой үйл ажиллагааныхаа үндсэн хэрэгсэл, эх үүсвэр болгон, тогтвортой ашигласан байхыг хамааруулсан хууль зүйн ойлголт юм. Өөрөөр хэлбэл, онц хүндрүүлэх шинж нь хоорондоо шууд харилцан хамаарал бүхий нэг төрлийн гэмт хэргийг харьцангуй удаан хугацаанд, гурав буюу түүнээс дээш удаа давтан үйлдэж, уг гэмт хэргийг үйлдэж олсон бага бус, түүнээс дээш хэмжээтэй ашиг орлогыг өөрийн болон гэр бүл, хамаарал бүхий хүмүүсийнхээ амьжиргааг залгуулах гол эх сурвалж, эсхүл бусад үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ зэрэг ашиг олох зорилготой үйл ажиллагааныхаа үндсэн хэрэгсэл, эх үүсвэр болгож тогтвортой ашигласан байхыг хамааруулсан хууль зүйн ойлголт болно. Түүнээс гадна “Залилах гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” гэх шинжээр хэргийг хүндрүүлж зүйлчлэхдээ тухайн гэмт хэргийг үйлдсэн этгээд нь тухайн төрлийн гэмт хэргийг үйлдэх нь амьдралынх нь хэвшил, хэв маяг болсон, өөрөөр хэлбэл бусдын эд хөрөнгийг шунахай зорилгоор, хууль бус аргаар өөрийн болгож, амар хялбар аргаар ашиг олох боломжийг байнга эрэлхийлж, түүнд чиглэсэн үйл ажиллагааг тогтвортой явуулдаг, гэмт санаа зорилго бүхий хувийн байдлыг харгалзан практикт хэрэглэж байна.[72]

Тухайн гэмт хэрэг амьдралынх нь хэвшил болсон, бусдын эд хөрөнгийг шунахайн сэдлээр, хууль бус аргаар өөрийн болгож, амар хялбар аргаар ашиг олох боломж байнга эрэлхийлж, үүнийгээ амьжиргааныхаа эдийн засгийн эх үүсвэр болгож байдаг харьцангуй тогтвортой үйлдлийн нэгдэл байдаг[73].

Б) Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны аргаар үйлдсэн аж ахуйн нэгжийн нэрээр халхавчлан албан ёсны үйл ажиллагаа явуулж байгаа мэт ойлголтыг олон түмэнд төрүүлэн хуулиар зөвшөөрөөгүй, хориглосон үйл ажиллагаа явуулсан байна. Ингэхдээ ихэвчлэн хүмүүсийн тодорхой хэмжээний мөнгийг маш хурдан хугацаанд өсгөж өгөхөө амлаж итгүүлэн хуурч өөртөө татан төвлөрүүлж авна. Хамгийн эхэнд мөнгөө өсгүүлэхээр өгсөн цөөн хүний мөнгийг амласныхаа дагуу өсгөж өгч байгаа дүр үзүүлэн шуум тарааж үнэмшүүлэн итгүүлнэ. Энэхүү үйл явцыг сонссон, мөнгөө өсгүүлж авах хүсэлдээ хөтлөгдсөн олон түмэн эцэг, эх, үр хүүхэд, ах, дүүс, төрөл, төрөгсөд, найз нөхөд, ажлын газрынхан, нутаг орон, танил талын хүрээгээрээ нэг нь нөгөөгийнхөө ар араасаа татагдаж орж мөнгөө өгсөөр олон арав, зуу, мянган хүний, хэдэн тэрбумаар тоологдох мөнгийг залилан авч үрэн таран хийсэн байх/. Жишээ нь: Казакстан улсын иргэн Жи тайм компаний захирал М.Матар 2015-2017 онд сүлжээний бизнесийн халхавчаар 11734 хүнээс 24 тэрбум залилсан пирамид тогтолцооны залиланг цагдаагийн байгууллагаас шалгах үед 6,4 тэрбум төгрөг, 400 сая төгрөгний үнэтэй машин, 3 тэрбум төгрөгний эд бараа битүүмжлэгдсэн байдаг[74].

---

[70] *С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй тусгай анги/сурах бичиг/. УБ.,2018. 188 дахь тал*

[71] *Уголовноё право МНР, часть обшая.М.1983, 258*

[72] *Монгол Улсын Дээд шүүх. 684 дүгээр тогтоол., 2020*

[73] *Ц.Цэлмэг, Д.Оросоо “Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ” Нээлттэй нийгэм форум. Шүүхийн шийдвэрийн судалгаа: Цуврал 2.УБ.,2021, 162 дах тал*

[74] *Х.Доржпалам “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй” /тусгай анги/.УБ.,2021, 117 дах тал*

В) Зохион байгуулалттай гэмт бүлэг /гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав ба түүнээс олон хүний тогтвортой нэгдэл/ үйлдсэн гэм буруутай этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэн 5-12 жилийн хорих ял шийтгэнэ.

Зохион байгуулалттай гэмт бүлэг нь гэмт хэрэг үйлдэх явдлыг орлогын эх үүсвэрээ болгож, ашиг олох зорилготой, нэгдсэн материаллаг бааз, мөнгөн сан, банк, санхүүгийн бие даасан сүлжээтэй байх, зохион байгуулалтын нарийн бүтэц, тогтолцоог бий болгосон, удирдах бүрэлдэхүүн, гишүүнчлэл, хяналт мэдээлэл, тагнан турших албатай, өөрсдийн төлөөний хүмүүсийг хууль хяналтын болон төр, засгийн байгууллагад оруулах буюу тэднээс эгнээндээ элсүүлэх, өөрийн болон бусдын эзэмшил газар, аж ахуйн нэгж, үйлдвэр үйлчилгээ, бар, зоогийн газар, мөрийтэй тоглоомын газар зэрэг томоохон обьектыг өмчлөлдөө авах, эзэмшилдээ байлгах, эрхэндээ оруулах, өөрсдийн тунд тогтсон хатуу дэглэм, журам, тангараг, нууц үг хэллэг, дохиолол холбоо, техник хэрэгсэл, зэр зэвсэгтэй байх гэх мэт хамгаалах болон гэмт халдлага хийх бэлтгэлтэй, үйлдлийн арга төлөвлөгөөтэй, гэмт хэрэг үйлдэхэд мэргэшсэн бүлэг этгээдүүдийн нэгдлийг ойлгоно[75].

Зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан, удирдсан үйлдэлд нь зохион байгуулалттай гэмт бүлгийн бусад гишүүний үйлдсэн гэмт хэргийн гүйцэтгэгчид тооцож ял оногдуулна.

Зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн гэмт хэргээ илчлэн ирсэн, зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн, мэдээлэл өгсөн, эрх бүхий байгууллагатай хамтран ажилласан бол түүнийг гэм буруугаа хүлээсэнд тооцон ял оногдуулж, хөнгөрүүлж, чөлөөлж болдгоороо онцлогтой.

Гадаадын зарим улсууд залилах гэмт хэргийг хэрхэн тодорхойлсон талаар онолын ойлголтуудыг товчхон авч үзье.

Англи улсад залилах гэмт хэргийг /criminal fraud/ санхүүгийн ашиг олох эсвэл түүнтэй адилтгах бусад ашиг олох зорилгоор хувь хүн, аж ахуйн нэгжийг хуурч, залилах схемийг агуулсан бөгөөд хувь хүн ямар нэгэн чухал баримтын талаар худал хэлж, гүйлгээ, харилцааны хувьд нөгөө тал нь тэрхүү буруу мэдээлэлд найдаж, хохирол амсах гэмт хэрэг гэж тодорхойлдог байна[76].

Оросын холбооны улсад залилан /Мошенничество/ гэдэг нь бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг залилах, итгэлийг нь эвдэх замаар олж авахыг хэлнэ.

Бүгд найрамдах Хятад ард улсад залилах гэмт хэрэг /欺骗手段犯罪/ гэдэгт хууль бусаар эзэмших зорилгоор төрийн болон хувийн өмчийг бодитойгоор үйлдэх, үнэнийг нуун далдлах замаар үйлдэх гэмт хэргийг хамааруулан авч үздэг байна[77].

Холбооны бүгд найрамдах Герман улсад залилах /Betrug/ гэмт хэрэгт хэн нэгнийг хууран мэхэлж, өөрийн болон бусдын эд хөрөнгийг захиран зарцуулж,

---

[75] *Г.Гантөмөр, Б.Энхболд, С.Гантулга, Л.Бат-Очир, Ж.Төгс-Очир нарын "Эрүүгийн эрх зүй"/ерөнхий анги/.УБ.,2020, 329 дэх тал*

[76] *HG.org Legal Resources*

[77] *https://www.wikipedia.org/*

улмаар гэмт этгээд болон гуравдагч этгээдийн ашиг тусын тулд санхүүгийн хохирол учруулсан үйлдлийг хамааруулан авч үздэг байна[78].

Франц улсад залилах /Fraude/ гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 313-р зүйлийн 1-д зааснаар худал нэр, чанар, жинхэнэ чадвараа урвуулан ашигласан, эсхүл хувь хүн, хуулийн этгээдийг залилах, улмаар түүнийг тогтоох, түүний болон гуравдагч этгээдэд хохирол учруулах, хөрөнгө мөнгө, үнэт цаас, аливаа эд хөрөнгийг шилжүүлэх, үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох үүрэг эсвэл чөлөөлөлт зэрэг хууль бус үйлдлийг залилах гэмт хэрэг гэж үздэг[79].

Турк улсад залилангийн /sahtekar/ гэмт хэрэг нь гэмт хэрэг үйлдэгч нь хуурч мэхлэх замаар бусдыг залилж, хохирогч болон бусдад хохиролтойгоор өөртөө болон бусдад ашиг тусаа өгөх үед үүсдэг. Мэргэшсэн залилах гэмт хэрэг нь шашны, нийгэм, мэргэжлийн, технологийн тодорхой хэрэгсэл, төрийн байгууллагыг хэрэгсэл болгон ашиглан гэмт хэрэг үйлдэхийг хэлнэ[80].

Солонгос улсад залилах (사기죄) гэмт хэрэг нь хүнийг хуурах зорилгоор санаатайгаар залилах гэмт хэргийн шинжтэй үйлдэл гэж тодорхойлдог байна.

Гадаадын зарим улс орнуудын залилах гэмт хэргийг онолын үүднээс хэрхэн тодорхойлсныг судлан авч үзэхэд хуурч мэхлэх, итгэл эвдэх, нуун далдлах шинжээрээ төсөөтэй байна. Гэвч ХБНГУ болон Франц улсууд залилах гэмт хэргийн нэгэн шинжийг гуравдагч этгээдэд хохирол учруулсан гэж авч үздэг байна. Мөн ашиг олох зорилгоор тус гэмт хэргийг үйлдэж байгаа нь төсөөтэй байна.

<u>Залилах гэмт хэргийн үндсэн шинж</u>

Залилах гэмт хэргийн обьектив шинж:

Обьект: Бусдын өмчлөх эрх байна. Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 3-т “Монгол Улсын иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө”, Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1-д “Өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй” гэж тус тус хуульчилсан.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг зөрчихдөө бусдын бие махбодь, эд хөрөнгөд халдаж хохирол, хор уршиг учруулдаг. Гэмт этгээдийн хуулиар хориглосон хэм хэмжээг зөрчсөн халдлагад өртөгдсөн хүн, эд /хогшил/ зүйлийг гэмт хэргийн халдлагын зүйл гэнэ[81].

---

[78] *Мөн тэнд*

[79] https://www.wikipedia.org/

[80] *Хуульч Баран Доган хуулийн фирмийн хуульчид тодорхойлсон.*

[81] *Х.Доржпалам “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй” /ерөнхий анги/.УБ, 2019, 155 дах тал*

Залилах гэмт хэргийн халдлагын зүйл нь бусдад залилагдсан эд хөрөнгө байна. Бусдын эд хөрөнгө гэж Иргэний хуулийн 84 дүгээр зүйлд тодорхойлсон өөр этгээдийн эзэмшил, өмчлөлд байгаа эд юмсыг ойлгоно.

Обьектив тал: Бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан идэвхтэй үйлдэл байна. Залилах гэмт хэргийг хохирлын хэмжээ шаардахгүй буюу хэлбэрийн шинжтэйгээр хуульчилсан. Өөрөөр хэлбэл, хуульд заасан аргаар бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авснаар энэ гэмт хэрэг төгсөнө.

Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт залилах гэмт хэрэг үйлдэх аргыг заасан учраас обьектив талын үндсэн шинжийг илэрхийлж, гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлнө.

Гэмт хэргийн обьектив талын шинж болох үйлдлийн арыг диспозицид дэлгэрэнгүй заасан нь өмчлөх эрхийн эсрэг бусад гэмт хэрэг, иргэний эрх зүйн зөрчлөөс энэ гэмт хэргийг ялган зүйлчлэхэд ач холбогдолтой.

Залилах гэмт хэргийн субьектив шинж:

Субьектив тал: Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг буцааж өгөхгүй, хариу төлбөр огт хийхгүй, эсхүл хагасыг нь хийнэ гэсэн субьектив санаа зорилго этгээдийн хувьд гэмт үйлдлээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө бий болсон байдгаараа залилах гэмт хэрэг нь гэрээний эрх зүйн маргаанаас ялгагдана.

Субьект: Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, тухайн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхгүй Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хоёрдмол харьяалалтай хүн байна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.2 дугаар зүйлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг авч үзсэн бөгөөд мөн зүйлийн нэгдүгээрт, ‘гэмт хэрэг үйлдэх үедээ арван зургаа насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”[82] гэж заасан бөгөөд тодорхой төрлийн гэмт хэргүүдэд арван дөрвөн насанд хүрсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан. Эрүүгийн хуулийн 6.2 дугаар зүйлийн 2 дах хэсэгт заасан гэмт хэргүүдэд “залилах” гэмт хэрэг хамаарахгүй тул залилах гэмт хэргийн эрүүгийн хариуцлага хүлээлгэх нас 16 байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.6 дугаар зүйлд гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хүнд, хөнгөн гэж ангилсан. Энэ ангиллаар авч үзэхэд залилах гэмт хэргийг үндсэн бүрэлдэхүүнээр /17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг/ үйлдсэн тохиолдолд “... дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж хуульчилсан нь хөнгөн гэмт хэрэгт хамаарч байна.

Уг гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн /17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/ “... арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”,

[82] *Эрүүгийн хуулийн 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг* https://legalinfo.mn/mn/detail/11634

онц хүндрүүлэх бүрэлдэхүүн /17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг/ “... таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж хуульчилсан нь хүнд гэмт хэрэгт хамаарч байна.

Эрүүгийн эрх зүйн онолд гэмт хэргийн нийгмийн хор аюулыг тухайн гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрх, ашиг сонирхол, харилцааны үнэлэмж, гэмт үйлдлийн арга, хэлбэр, ашигласан зэвсэг, хэрэгсэл, түүнийг хэрэглэсэн арга, хувилбар, гэмт хэргийн улмаас учирсан хохирол /гэм хор/[83], гэмт буруугийн сэдэлт, удирдлага болгосон зорилго, гэм буруугийн хэлбэр, гэмт хэрэг үйлдэж буй этгээдийн хувийн байдал зэргийг харгалзан тодорхойлдог.

Залилах гэмт хэргийн нийгмийн хор аюул нь гэмт этгээд бусдын өмчлөх эрхэд тэднийг хуурч мэхлэх буюу итгэл эвдэх замаар халдаж, эд хөрөнгө эсхүл түүнийг өмчлөх эрхийг хууль бусаар олж авч байгаагаар тайлбарлагдана. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хууль болон Эрүүгийн хуульд тусгалаа олж, хамгаалагдсан бусдын өмчлөх эрхэд хууль бусаар халдаж болохгүй гэсэн эрх ашгийг буюу эрүүгийн хуулиар хориглосон хэм хэмжээг санаатайгаар зөрчсөн байдаг.

Гэмт этгээдийн залилан мэхлэх үйлдэлд шууд өртөгдөж байгаа эрх, ашиг сонирхол болох бусдын өмчлөх эрх энэ гэмт хэргийн нийгмийн аюулыг тодорхойлоход[84] чухал ач холбогдолтой. Залилах гэмт хэргийн нийгмийн хор аюул нь түүний шинж чанар хэр хэмжээгээр тодорхойлогддог бөгөөд гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ нь харилцан уялдаа холбоотой, онцлог агуулгатай ойлголт байдаг.

Үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар гэдэг бол тухайн хэргийн байдалд эрүүгийн эрх зүйн хууль тогтоомж болон онолын үүднээс өгөх ерөнхий бодлого, үнэлэлт, дүгнэлтээр шалгуур болгодог ойлголт юм[85]. Харин гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ гэдэг бол тодорхой нөхцөлд үйлдэгдсэн хэргийн өвөрмөц нөхцөл байдлыг харгалзан үзэх боломжийг бүрдүүлдэг[86].

Залилах гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн шат нь тухайн хэргийг үйлдэхээр завдсанаас, завдсан шат нь үйлдэж дууссан шатнаас нийгмийн хор аюулын хэр хэмжээний хувьд тус тус бага байх нь мэдээж хэрэг юм.

Иймээс нийгмийн хор аюулын шинж чанарын хувьд нэг төрөлд багтах залилах гэмт хэрэгт тодорхой нөхцөлд уг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, шинж чанар, халдлагын зүйл, өөр төрлийн давхар обьектод халдсан эсэх, залилах гэмт хэргийг үйлдсэн газар, арга, цаг, нөхцөл, тухайн гэмт хэргийн давталтын тоон үзүүлэлт зэргээс шалтгаалан нийгмийн хор аюулын хэр хэмжээний хувьд өөр өөр байдаг.

Профессор Н.Жанцан залилах гэмт хэргийн өсөлт, нийгмийн хор аюулын талаар “Залилан мэхлэх гэмт хэрэг нуугдмал байх, бүртгэгдээгүй байх шинж зонхилох бөгөөд хууль хяналтын байгууллагууд зориуд санаатай тоож үзэхгүй

---

[83] *С.Жанцан. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүйн тусгай ангийг судлах бүдүүвч, тойм. УБ., 1990. 70-71 дэх тал*

[84] *“... Гэмт хэргийн нийгмийн аюул нь юуны өмнө халдлагад өртөгдсөн обьектын чухлаас шалтгаална...” / Н.Д.Дурманов. Понятие преступления по Советскому уголовному праву. М. 1984 стр 132*

[85] *Г.Совд. Эрүүгийн хариуцлага түүний уламжлал, шинэчлэлийн асуудал сэдэвт диссертаци. УБ., 1992.117 дахь тал*

[86] *Мөн тэнд*

байх, ихэнхи тохиолдолд ИХШХШ журмаар шийдвэрлүүлэхээр явуулдаг зэргээс болж уг гэмт хэргийн хүрээ сүүлийн үед тэлэх хандлагатай" байна гэж оновчтой тодорхойлсон[87].

Залилах гэмт хэргийн нэг онцлог нь дийлэнх тохиолдолд үргэлжилсэн шинжтэй байдаг бөгөөд уг гэмт хэргийн нийгмийн хор аюул бага бус болох нь тодорхойлогдож байдаг. Мөн хохирогч өөрөө эд хөрөнгөө буюу өмчлөх эрхээ гэмт этгээдэд сайн дурааараа шилжүүлэн өгсөн байдгаараа бусад төсөөтэй гэмт хэргээс ялгагдаж байна.

[87] *Прокурорын ном /Гарын авлага/. УБ., 2001. 139 дэх тал*

ДӨРӨВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

4.1. Залилах гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний маргаанаас ялган зүйлчлэхэд тулгамдаж буй асуудал

Залилах гэмт хэрэг болон иргэний эрх зүйн гэрээний харилцааг ялган зааглах асуудал нь эрүүгийн болон иргэний эрх зүйн онолын чухал асуудал төдийгүй иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой эрүүгийн болон иргэний процессын явцад тулгамдаж буй асуудал болоод байна.

Учир нь залилах гэмт хэрэг болон иргэний эрх зүйн гэрээний харилцааг зөв ялган зүйлчилснээр залилах гэмт хэргийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, түүнчлэн иргэний хэргийн нэхэмжлэгчийн тухайд гэрээний зөрчлөөс үүсэлтэй зөрчигдсөн эрхээ сэргээлгэхтэй холбоотой гарах цаг хугацаа, хөрөнгө санхүүг хэмнэх, нөгөө талаас залилах гэмт хэрэг үйлдэж буй этгээдийн гэмт үйлдлийг шуурхай таслан зогсоох, түүнд ял шийтгэлийг шударгаар оногдуулахад чухал ач холбогдолтой[88].

Цагдаагийн Ерөнхий газраас “залилах” гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгааны тайланд “Цагдаагийн байгууллагад хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг худалдах, худалдан авах, түрээслэх, түрээслүүлэх, арилжих, өндөр хүүтэй мөнгө зээлэх нэрээр гэрээ байгуулж, хохирогчийн эд хөрөнгийн эзэмших, өмчлөх эрхийг шилжүүлэн авахдаа өөрсдийн үйлдлийг гэмт хэргийн шинжгүй, иргэний эрх зүйн харилцааны явцад үүссэн гэрээний маргаантай асуудал болгож харагдуулах зорилгоор нотариатаар батлуулж, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр акт мэтээр үйлдэж байгаа нь уг гэмт хэргийн нэг шалтгаан болж байна[89] гэжээ.

Практикаас харахад цагдаагийн байгууллагаас гомдол мэдээллийг хүлээн авч бүртгэхдээ гэрээ байгуулсан бол гэмт хэргийн шинжгүй иргэний журмаар шийдвэрлүүлэх маргаан хэмээн хүлээн авах болон шалгахаас аль болох татгалзах, нөгөө талаас иргэдийн хувьд иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган маргааныг шийдвэрлүүлэх талаар эрх зүйн мэдлэг дутмаг, шүүхэд хандахад улсын тэмдэгтийн хураамж төлдөг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширдаг, олон сар, жил үргэлжлэх магадлалтай, шүүхийн шийдвэр биелэгддэггүй зэргээс шалтгаалан иргэний эрх зүйн харилцаанаас үүдэлтэй маргаан зэрэг шалтгааны улмаас Цагдаагийн байгууллагаар шалгуулж шийдвэрлүүлэх сонирхол ихтэй байдаг.

Мөн иргэд хоорондын гэрээнээс үүссэн харилцааны явцад гэрээний нэг тал нь хүлээсэн үүргээ биелүүлэх хөрөнгө, санхүүгийн болон үүрэг хариуцлагын хувьд боломжгүй болсон хэдий ийнхүү нөхцөл байдлаа нуун дарагдуулах, бодит байдлаа үгүйсгэх, цаашид гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх ямар ч боломжгүй болсон хэдий ч биелүүлж чадна гэж хоосон таамаглах, нөгөө талд худал нөхцөл байдлыг бий болгон ярьж итгүүлэн үнэмшүүлэх, төөрөгдүүлэх, нэмж шунахайн сэдэлтээр эд хөрөнгө түүний эрхийг өөртөө шилжүүлэн авах явдал нэн түгээмэл болж байна[90].

Залилах гэмт хэрэг болон иргэний эрх зүйн маргааны ялгаатай ба төсөөтэй талуудыг судлаачид дараах байдлаар тодорхойлжээ.

---

[88] *С.Должин, Д.Бадам Залилах гэмт хэрэг ба гэрээний маргаан. 2018 он*

[89] *ЦЕГ. “Залилах” гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгаа. УБ., 2020, 8 дахь тал*

[90] *Ц.Гантулгабат. Залилах гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэхэд анхаарах асуудал. Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал. 2018 №3. 39 дэх тал*

Судлаач С.Должин, Д.Бадам нар Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд заасан залилах гэмт хэргийг иргэний эрх зүйн харилцаанаас үүссэн маргаанаас ялгах асуудлыг тодорхойлохдоо:[91]

№	Ялгаатай төсөөтэй шинж	Залилах гэмт хэрэг	Гэрээний харилцаанаас үүссэн маргаан /зөрчил/	Тайлбар
1	Объект	Бусдын өмчлөх эрх	Эд хөрөнгийн сонирхол	
2	Халдлагын зүйл	Эд хөрөнгө, мөнгө	Мөнгө, эд хөрөнгийн эрх, анз, олох байсан орлого	
3	Объектив тал	Хуурах, төөрөгдүүлэх, итгэл эвдэх аргаар бусдын өмчлөлийн эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар шилжүүлэн авсан үйлдэл	Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэхүй	
4	Субъект	16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай хувь хүн	Хувь хүн, хуулийн этгээд байж болно.	
5	Хохирол	Ердийн бүрэлдэхүүний хувьд хохирол шаардахгүй	Мөнгө, эд хөрөнгийн эрх, анз, олох байсан орлого	Шууд бус хохирол тооцдог эсэхээрээ ялгаатай
6	Субъектив тал	Хариу төлбөргүйгээр, өөрийн өмчлөлд авч буйгаа мэдэж, түүнийг хүсэж үйлдсэн гэм буруугийн шууд санаатай хэлбэртэй, шунахай сэдэлтэй	Ашиглан шамшигдуулах шинжгүй	Субъектив санаа зорилго гэмт этгээдийн хувьд гэмт үйлдлээ хэрэгжүүлж эхлэхээсээ өмнө бий болсон./дурьдсанаас бусад тохиолдолд/
7	Харилцааны онцлог	Төр давуу эрхтэй буюу гэмт этгээдэд хүлээлгэж оролцоно.	Оролцогч талууд тэгш эрхтэй оролцоно.	

Бусдын хуулиар хамгаалагдсан өмчлөх эрхэд халдаж, хохирол, гэм хор учруулдаг, хуурч мэхлэх үйлдэл болон эс үйлдэхүйгээр илэрдэг, гэмт хэргийн субьект болон хариуцлага хүлээлгэх шинжээр нь авч үзвэл[92]:

1) Бусдын эд хөрөнгө залилах гэмт хэрэг нь нийгмийн хор аюулын шинжээрээ иргэний эрх зүйн төсөөтэй зөрчлөөс үлэмж их байдаг[93].

2) Хуурч мэхлэх, итгэл эвдэх үйлдэл, эс үйлдэхүйн улмаас шууд учирсан хохирол, түүний хэмжээ тухайн гэмт хэргийн шинжийг тодорхойлоход нөлөөлдөг бол иргэний эрх зүйн төсөөтэй зөрчлийн хувьд бодит хохирол, алдагдал, олох байсан орлого, зардал, шууд бус бусад хохирлууд /сэтгэл санааны хохирол, ажил хэргийн нэр хүнд зэрэг/ нөлөөлдөг зэрэг онцлогтой.

3) Обьектив талын гэм хор учруулах шинжээрээ ялгаатай. Эрүүгийн эрх зүйн хувьд обьект нь бусдын өмчлөх эрх байдаг бол иргэний эрх зүйн хувьд иргэний хуулиар хамгаалагдсан субьектүүдийн иргэний эрх зүйн харилцааны

[91] *С.Должин, Д.Бадам Залилах гэмт хэрэг ба гэрээний маргаан. 2018. 70 дахь тал*
[92] *С.Должин, Д.Бадам Залилах гэмт хэрэг ба гэрээний маргаан. 2018. 71 дэх тал*
[93] *Д.Адъяабазар "Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал".УБ, 2002, 13 дахь тал*

хүрээн дэх эдийн засгийн сонирхол юм. Халдлагын зүйл эд хөрөнгө мөнгө эрх, алданги, олох байсан ашиг орлого хамаарна.

4) Объектив тал нь хуурах, төөрөгдөлд оруулах гэх мэт үйлдлээр илэрнэ. Ашиглан шамшигдуулах шинжтэй. Иргэний эрх зүйн хувьд хуурч мэхэлж бусдын эд хөрөнгийг үнэ төлбөргүй авсан үйлдлээр илэрнэ. Ашиглан шамшигдуулах шинжгүй. Эрүүгийн хуульд заасан бусдыг хуурах, төөрөгдүүлэх замаар бусдын эд хөрөнгө, өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар шилжүүлэн авснаар гэмт хэрэг төгсдөг бол иргэн гэрээ хэлцлээс үүссэн үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй эс үйлдэхүйгээр төгсдөг.

5) Субъект нь 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай зөвхөн хувь хүн байна. Иргэн хувь хүн байхаас гадна хуулийн этгээд байж болно[94].

Судлаач Ц.Цэлмэг, Д.Оросоо нар залилах гэмт хэрэг, иргэний хэргийн нийтлэг ба төстэй талыг дараах байдлаар авч үзсэн байна. Үүнд:

- Хуулиар хамгаалагдсан бусдын өмчлөх эрхэнд халдаж гэм хор учруулсан байдаг;
- Иргэний хэргийн хариуцагч болон залилах гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдийн гэм буруутай сэтгэхүйн хандлага нь үйлдэл, эс үйлдэхүйтэй нь нөхцөлдөж байдаг;
- Иргэний хэргийн хариуцагч болон залилах гэмт хэрэг үйлдэж байгаа этгээд нь хэрэг хариуцах чадвартай, эцэстээ хууль зүйн хариуцлага хүлээдэг.

Харин ялгаатай талыг тодорхойлохдоо:

- Залилах гэмт хэргийн иргэний хэргээс ялгагдах гол шинж нь нийгмийн хор аюулаараа ямагт их, гэрээгээр халхавчилж үүргийн гүйцэтгэлийг биелүүлэхгүй гэсэн санаа, зорилго агуулсан байдаг.
- Иргэний хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгч, хуулийн этгээд нь залилах гэмт хэргийн субъект байх боломжгүй, иргэний хэргийн харилцаанд оролцогчид тэгш эрхтэй байдаг бөгөөд талуудын харилцан зөвшилцөл дээр тулгуурладаг. Харин залилах гэмт хэрэгт түүнийг үйлдсэн этгээд, нөгөө талаас төрийн хуулийн байгууллага давуу эрхтэй харилцаанд оролцдог.
- Хохирлын хувьд залилах гэмт хэргийн бодит хохирлыг төлүүлэхэд шүүх анхаарал хандуулдаг бол иргэний хэрэгт олох байсан орлого, алданги, мөнгөний хүү зэргийг тооцон гаргуулдаг[95] гэжээ.

Улсын Дээд шүүх 2006 оны 12 сарын 21-ний өдрийн 51 дугаар тогтоолоор Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан “бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах” гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар тайлбар гаргахдаа “гэрээний харилцаа нь Иргэний хууль тогтоомжийн дагуу үүсч, гэрээний биелэлтийн талаар мэдээлэл солилцож, харилцан гомдлын шаардлага гаргаж, эрсдлийг залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэхгүй. Харин гэрээгээр хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтаглаж бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг бүгдийг буюу заримыг шилжүүлэхгүй байх гэмт санаа зорилго төрж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх замаар хуурч мэхлэх, итгэл эвдэх, тодорхой үйлдэл хийсэн нь хэрэг

---

[94] *С.Должин. Хувийн эрх зүй эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл, УБ. 2017, 61 дахь тал*

[95] *Ц.Цэлмэг, Д.Оросоо "Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ" Нээлттэй Нийгэм Форум. Шүүхийн шийдвэрийн судалгаа: Цуврал 2. УБ., 2021, 153 дахь тал*

бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад тогтоогдвол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”[96] гэж тодорхойлсон байдаг.

Үүнээс үзэхэд залилах гэмт хэрэг нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн нийтлэг шинжийг агуулахаас гадна иргэний эрх зүйн гэрээ хэлцлээр халхавчлагддаг, ихэнх тохиолдолд нуугдмал, ээдрээтэй, зохион байгуулалттай шинж бүхий онцлогтой байдаг. Иймд энэ төрлийн гэмт хэргийн үйлдлийн шинжийг зөв тогтоох, иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүдэлтэй маргаанаас залилах гэмт хэргийг ялган зүйлчлэхэд анхаарах шаардлага байгаа нь гэмт хэргийн бүрэлдэхүүний асуудал нь эрүүгийн эрх зүйн онолын хувьд маргаан дагуулсаар байгаагаас харж болох юм.

Түүнчлэн хохирогчдоос олон зүйл хамаарч байгаа бөгөөд зээлдүүлсэн мөнгөө буцаан авах боломжгүй тохиолдолд “залилуулсан” мэтээр цагдаагийн байгууллагад гомдол гаргаж, зээлдэгч нь “Бизнесийн эрсдэлд орсон, төлнө” гэдэгт үл итгэх шалтгааны улмаас залилах гэмт хэрэг гэж үзэх нь цөөнгүй байна. Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт дүгнэлт хийж үзвэл:

Нэгдүгээрт: Иргэний хэргийн шүүхэд хандахад улсын тэмдэгтийн хураамжийн үнийн дүн өндөр;

Хоёрдугаарт: Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хариуцагчийн хүсэлтээр үндэслэлгүйгээр хойшилж, хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа хэт удааширдаг;

Гуравдугаарт: Иргэний хэргийн шүүхийн шийдвэр биелэгдэх чадвар муутай байдагаас хохирогчид цагдаагийн байгууллагад хандах хүсэл, сонирхол их байдаг нь хохирлыг хурдан төлүүлэх хөшүүрэг хандаж байгаатай холбоотой юм[97].

Шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хуулийн үзэл баримтлалаар “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг нэг хэрэгт нь нэг л удаа шийтгэнэ” гэсэн зарчмын дагуу өмнөх Эрүүгийн хуульд байсан “онц аюултай гэмт хэрэгтэн”, “ялтай байдал”, “давтан гэмт хэрэг” гэсэн ойлголтуудыг хассан байна.

Залилах гэмт хэргийн хувьд 2002 оны Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.2 дахь хэсэгт “... энэ гэмт хэргийг давтан, бүлэглэж, урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг үйлдсэн бол” гэсэн хүндрүүлэх гурван нөхцөл байдал[98] байсныг шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар хассан.

Түүнчлэн зөвхөн залилах гэмт хэрэгт төдийгүй хулгайлах, булаах, завших, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд онц аюултай гэмт хэрэг үйлдсэн бол онцлон хүндрүүлэхээр заасныг хассан нь дэлхий нийтийн жишигт нийцсэн, хүний эрхийг хангасан дэвшилтэт алхам болсон юм.

Байгалийн давагдашгүй хүч, нийгэм, эдийн засгийн харилцааны зохицуулалтын өөрчлөлт, гэнэтийн осол, өвчин эмгэг, хорио цээр зэрэг нөхцөл байдлуудаас үл шалтгаалах хүчин зүйл буюу урьдчилан тооцоолох

---

[96] *С.Амартүвшин “Эрүүгийн болон иргэний эрх зүйн харилцан хамаарал”.Эрх зүйн сэтгүүл, МУИС-ХЗС, УБ., 2014/2, 125-132 дах тал*

[97] *Ц.Цэлмэг, Д.Оросоо "Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ" Нээлттэй Нийгэм Форум. Шүүхийн шийдвэрийн судалгаа: Цуврал 2. УБ., 2021, 154 дэх тал*

[98] *“Залилан мэхлэх гэмт хэрэг” сургалтын гарын авлага, Д.Адьяабазар, УБ, 2008 он, 31 дэх тал*

боломжгүйгээс гэрээний үүрэг биелэгдээгүй нь залилах гэмт хэргийн шинжийг хангахгүй юм.

Залилах гэмт хэргийн бүрэлдэхүүний обьектив талын шинж болох хуурч мэхлэх буюу бусдын эд хөрөнгө эсхүл түүнийг өмчлөх эрхийг өөртөө олж авах санаа зорилго агуулж, үүнд чиглэсэн идэвхтэй үйлдлээр илэрдэг тул хуурч мэхлэх, ямар нэгэн үйлдэл хийгээгүй бол гэмт хэрэгт тооцохгүй. Залилах гэмт хэргийн халхавч болсон гэрээ хэлцэл нь хуурч мэхлэх, төөрөгдөлд оруулах аргад үндэслэгдсэн, ганцаар ашиг олох, гэрээнд оролцогч нөгөө талаа хохироох зорилгоор хийгдсэн байдаг бол иргэний эрх зүйн гэрээний харилцаа нь талуудын чөлөөт байдал, тэгш эрхэд суурилан, харилцан тодорхой үр дүнд хүрэхэд чиглэдэг учир гэрээ анхнаасаа биелэгдэх бодит боломжгүй байсан нь тогтоогдсон, гэрээний нэг тал үүнийг урьдчилан мэдсээр байж байгуулсан, нөгөө тал (хохирогч) нь мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан бол залилах гэмт хэрэг гэж үзнэ[99].

Мөн бусдын эд хөрөнгийг “зээл” нэрээр халхавчлан залилж авах нь уг зээлийг буцаан төлөх бодит баталгаагүй, тухайлбал, барьцаа хөрөнгөгүй, хөрөнгө нь биет байдлын болон эрхийн зөрчилтэй, түүнчлэн Иргэний хуульд заасан барьцааны гэрээ байгуулах журмыг санаатай зөрчсөн байдаг зэргээрээ иргэний эрх зүйн зээлийн гэрээнээс ялгагддаг. Түүнчлэн гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор барьцааны гэрээ байгуулахад барьцаалсан эд хөрөнгө нь үүрэг гүйцэтгүүлэгч гэрээний үүргийн шаардлагаа хангуулахад ямар нэгэн саад бэрхшээлгүй байх ёстой учир барьцааны эд хөрөнгө үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг анхнаасаа хангах боломжгүй байсан, үүрэг гүйцэтгэгч үүнийг мэдэж байсан ч санаатайгаар нуун далдалсан нь тогтоогдвол залилах гэмт хэрэг болно[100].

Худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй эд хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагч буюу хүлээн авагчид шилжүүлэх, худалдан авагч нь тохирсон үнэ хөлс төлдөг[101] бол залилах гэмт хэргийн үед шунахайн сэдэлтээр, өөртөө ашиг олох субъектив санаа зорилгоор чанар муутай эсхүл иж бүрдэл дутуу бүтээгдэхүүн буюу гэрээнд зааснаас цөөн тооны бүтээгдэхүүн нийлүүлэх, үнийг дутуу төлөх зэргээр бусдын эд хөрөнгийг хуурч, итгэл эвдэх замаар бусдын эд хөрөнгийн эрхийг хууль бусаар шилжүүлж авдгааараа ялгагдана[102].

Өөрөөр хэлбэл худалдан-худалдан авах, түрээслэх, эд хөрөнгө хөлслөх гэрээгээр халхавчлан бусдын эд хөрөнгийг залилах гэмт хэрэг нь анхнаасаа хууль, гэрээнд заасан эд хөрөнгийг нийлүүлэхгүй, үнэ болон хөлсийг зохих журмаар төлөхгүй байх санаа зорилго агуулж, түүнийгээ хэрэгжүүлсэн байдаг төдийгүй санаатайгаар чанар муутай буюу иж бүрдэл дутуу бүтээгдэхүүн нийлүүлж өөртөө ашиг олсон, төлбөр төлөх боломжтой атлаа зориуд дутуу төлсөн зэрэг хэлбэртэй байдаг.

Иргэний хуулийн 56 (Хүчин төгөлдөр бус байх хэлцэл), 57 (Хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцэл), 58 (Ноцтой төөрөгдлийн улмаас хийсэн хэлцэл),

---

[99] Ц.Цэлмэг, Д.Оросоо "Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ" Нээлттэй Нийгэм Форум. Шүүхийн шийдвэрийн судалгаа: Цуврал 2. УБ., 2021, 155 дахь тал

[100] Улсын Дээд шүүхийн 51 дүгээр тогтоолын 7 дугаар хэсэг

[101] Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /шинжлэх ухааны тайлбар/.УБ., 2010, 487 дахь тал

[102] Ц.Цэлмэг, Д.Оросоо "Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ" Нээлттэй Нийгэм Форум. Шүүхийн шийдвэрийн судалгаа: Цуврал 2. УБ., 2021, 156 дахь тал

59 (Хууран мэхэлж хийсэн хэлцэл), 60 (Хүч хэрэглэж хийсэн хэлцэл) дугаар зүйлд тус тус заасан хэлцлээс үүссэн маргаанд шунахайн сэдэлтээр, бусдын эд хөрөнгө эсхүл түүнийг эзэмших эрхийг хуурч мэхлэх буюу итгэл эвдэх аргаар олж авах гэсэн гэмт санаа зорилго байдаггүй. Өөрөөр хэлбэл хэлцлээс үүссэн маргаан болгон гэмт хэрэг болохгүй. Харин дээрх хэлцлүүдээр халхавчлан шунахайн сэдэлтээр хуурах буюу итгэл эвдэх аргаар бусдын эд хөрөнгө эсхүл түүний өмчлөх эрхийг хууль бусаар авсан бол залилах гэмт хэрэг гэж үзнэ.

Хэрэв залилах хэрэг үйлдэхдээ хуурамч баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт болон компьютерын программ, сүлжээ, төхөөрөмж зэргийг ашигласан бол нийлмэл гэмт хэрэг болох ба захиргааны журмын болон компьютерын мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээр давхар зүйлчлэхгүй. Харин хуурамч баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт болон компьютерын программ, сүлжээ, төхөөрөмж зэргийг мэдсээр байж бусдад ашиглуулсан этгээдийг залилах гэмт хэргийн хамтран оролцогч гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалттай байдаг.

Уг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар бусдад учруулсан шууд хохирлоор тодорхойлно. Харин шууд бус хохирлыг энэ гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээнд оруулан тооцохгүй бөгөөд түүгээр хэргийн зүйлчлэл өөрчлөгдөхгүй юм.

Харин хохирогч нь өөрийн зайлшгүй олох байсан орлогыг Иргэний хууль хуульд зааснаар нэхэмжлэх эрхтэй бөгөөд иргэний нэхэмжлэгчээр тогтоон, нэхэмжлэлийг эрүүгийн хэрэгтэй нь хамтатган шийдвэрлэдэг[103].

Бусдын өмчлөх эрхийг хуурч, итгэл эвдэх аргаар олж авсан тохиолдолд уг эрхээр баталгаажсан эд хөрөнгийн зах зээлийн үнэлгээгээр бодит хохирлыг тооцно, эд хөрөнгийн эрхийг үнэлж болохгүй тохиолдолд залилах гэмт хэргийг энгийн бүрэлдэхүүнтэй гэж үзнэ[104].

Иймд гэрээний харилцаагаар халхавчлан бусдын эд хөрөнгийг залилах гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд хуурах, төөрөгдүүрэх замаар бусдын эд хөрөнгө эсхүл эд хөрөнгийн эзэмших эрхийг олж авах гэсэн субъектив санаа зорилготой байсан эсэхийг заавал тогтоох шаардлагатай.

Залилах гэмт хэрэг үйлдэхдээ иргэний гэрээ, хэлцлийг ашиглах явдал нь дээрх гэмт хэргийн нэг арга нь хууль ёсны мэт харагдуулах, нуугдмал байдлыг бий болгох явдал юм. Гэвч бодит байдалд гэмт этгээд хохирогчийн эд хөрөнгө, түүнийг эзэмших эрхийг буцааж өгөлгүй, үнэ төлбөргүй авах гэсэн санаа, зорилгыг анхнаасаа агуулсан байдаг бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад түүнийг бүрэн тогтооход төвөгтэй байдаг. Залилах гэмт хэргийн субьектив шинжийг тогтоохдоо хохирогчийн итгэл үнэмшлийг олж авсан арга, гэмт этгээдийн амласан, болзол болгосон зүйл, ажил үйлчилгээ нь бодит байдал дээр биелэгдэх, хэрэгжих боломжтой эсэх, тохиолдлын чанартай бэрхшээл тулгарсан нь үнэн эсэх, уг этгээд урьд нь тухайн төрлийн болон өөр төрлийн гэмт хэрэг үйлдэж байсан эсэхийг тогтоох шаардлагатай[105].

Залилах гэмт хэргийг үйлдсэн үйлдлийн аргаар нь харуулбал: /2012-2017 он/

- Гэрээ, хэлцэл ашигласан- 1160
- Завшсан- 253

---

[103] *Иргэний хуулийн 497 дугаар зүйл*
[104] *http: //Mongolia.hss.de/mn/*
[105] *“Криминалистикийн тактик” ред. Ж.Болдбаатар, УБ. 2001 он. 252 дахь тал*

- Мөнгө зээлсэн- 539
- Итгэл эвдсэн- 4317
- Бусдын нэр барьсан- 441
- Хадгалуулсан эд хөрөнгө завшсан- 55
- Хуурамч бичиг баримт ашигласан- 312
- Хуурч мэхэлсэн- 14697
- Бусад- 1138 зэрэг тоон үзүүлэлтийг Цагдаагийн Ерөнхий газраас гаргажээ[106].

2017 оны 07 сарын 01-ээс хойш буюу Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсноос хойш 2022 оны 02 сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд Улсын Дээд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн залилах гэмт хэргүүдээс гэрээний эрх зүйн харилцаанаас үүдэлтэйгээр үйлдэгдсэн зарим залилах гэмт хэргүүдийг жишээ болгон авч үзлээ. Тухайлбал:

1) Т.Б нь үргэлжилсэн үйлдлээр ганцаараа 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Юнион бюлдинг” барилгын А-1205 тоотод "П" ХХК-ний захирал Ж.Б-тай авто гражийн металл дам нуруу бэлтгэн нийлүүлэх тухай 18/74 дугаартай гэрээг байгуулж 55,000,000 төгрөгийг 2018 оны 7 дугаар сарын 31, 9 дүгээр сарын 20-ны өдрүүдэд 27,500,000 төгрөгөөр тус тус 2 хувааж шилжүүлэн авч бодит байдлыг нуух замаар төөрөгдөлд оруулж, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж уг компанид 55,000,000 төгрөгийн хохирол учруулан бусдад нийт 70,540,000 төгрөгийн их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт тус тус холбогдсон.

Уг хэргийг Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаас дараах байдлаар дүгнэжээ. Үүнд:

- Иргэний хуульд заасны дагуу гэрээ байгуулсан, түүний биелэлтийн талаар мэдээлэл солилцож, харилцан гомдлын шаардлага гаргаж, гэрээгээ дүгнэж байсны эцэст аливаа эрсдэлд орсны улмаас үүссэн маргааныг, өөрөөр хэлбэл, гэрээний эрсдлийг залилах гэмт хэрэгт тооцдоггүй.
- Өөрөөс нь үл шалтгаалах хүчин зүйл буюу нөхцөл байдал үүсээгүй байхад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй, үүнд чиглэсэн идэвхтэй үйлдэл хийгээгүй зэргээр гэрээний үүргээ биелүүлээгүйгээс гэрээний харилцаагаар итгэмжлэн олгосон бусдын эд хөрөнгийг буцааж өгөлгүй ашиглах нь залилах гэмт хэргийн нэг хэлбэр юм.
- Шүүгдэгч Т.Б нь “Б” ХХК-ийн нэрээр “ПБ” ХХК-д авто гражийн барилгын металл дам нурууг бэлтгэн нийлүүлэх гэрээг 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдөр уг компаний захирал Т.Б-тай байгуулж, гэрээний төлбөрт мөн оны 7 дугаар сарын 31, 9 дүгээр сарын 20-ны өдрүүдэд тус тус 27,500,000 төгрөг, нийт 55,000,000 төгрөг авсан мөртлөө элдэв шалтаг заан уг гэрээний үүргээ биелүүлээгүй үйл баримтыг анхан шатны шүүх тогтоож, энэхүү үйлдлийг залилах гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг хангасан гэж дүгнэсэн нь хэргийн бодит байдалтай нийцсэн байна.
- Шүүгдэгч Т.Б нь дээрх барааг бэлтгэн нийлүүлэх гэрээг Н.У-аар дамжуулан хийж урьдчилгаа мөнгийг түүгээр төлүүлсэн, уг бараа нь үлдэгдэл мөнгийг төлөөгүйн улмаас Бүгд Найрамдах Хятад Ард улсын Эрээн хотод байгаа талаар гэрч Н.У, М.А нар мөрдөн шалгах болон шүүх хуралдааны явцад мэдүүлжээ.

---

[106] *ЦЕГ. “Залилах” гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгаа. УБ., 2020, 3 дахь тал*

- Гэрээний төлбөрт 55,000,000 төгрөгийг бүрэн авсан мөртлөө Т.Б нь Н.У-аар урьдчилгаанд төлүүлсэн 10,000,000 төгрөгийг түүнд буцаан өгснөөс өөрөөр үлдэгдэл мөнгийг төлж, бэлэн болсон барааг гэрээний дагуу нийлүүлэх арга хэмжээ авч байсан боловч түүнээс үл шалтгаалах хүчин зүйл, нөхцөл байдлын улмаас тэрээр гэрээний үүргийг биелүүлэх боломжгүйд хүрсэн буюу эрсдэлд орсныг нотолсон ямар нэгэн баримт мэдээлэл хэрэгт авагдаагүй тул шүүгдэгчийн энэхүү үйлдлийг анхан шатны шүүхээс залилах гэмт хэргийн шинжийг хангасан гэж дүгнэснийг үгүйсгэх эсхүл өөрчлөх үндэслэлгүй гэжээ[107].

2) Б.С нь Т.Х-тай бүлэглэн 2016 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн хашаан дотор төмөр гир /гантель/ дотроос улаан мөнгөн ус хайж, цааш үнэд хүргэж зарах гэсэн В.Т, Х.С нарын хүсэл сонирхлыг ашиглан өөрийнхөө олж ирсэн “СССР” гэсэн бичиглэлтэй төмөр гирийг “жинхэнэ гир мөн байна, худалдаж авах нь зүйтэй” гэж итгүүлэн, уг гирийг Т.Х-аар дамжуулан В.Т, Х.С нарт нийт 49,700,000 төгрөгөөр худалдаж мөнгийг нь Т.Х-тай хуваан авсан буюу хуурч, зохиомол байдлыг зориудаар бий болгох, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж залилсан,

Уг хэргийг Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаас дараах байдлаар дүгнэжээ. Үүнд:

- “Уг хэргийг үйлдэхдээ шүүгдэгч нар нь хохирогч В.Т, Х.С нарын иргэний гүйлгээнд байдаггүй эд зүйлийг (улаан мөнгөн ус агуулсан төмөр туухай) худалдан авах гэсэн хүсэл сонирхлыг ашиглан тэдгээрийн хайж буй зүйлийг борлуулж буй мэтээр хуурч дээрх мөнгийг хууль бусаар авсан үйлдлийг хоёр шатны шүүх залилах гэмт хэргийн шинжийг хангасан гэж дүгнэж, гэмт хэрэг үйлдэхэд тэдний гүйцэтгэсэн үүрэг, оролцоог үндэслэлтэй тогтоон хууль буцаан хэрэглэх замаар хэргийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн зохих заалтуудыг журамлан тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зөв зүйлчилжээ” гэж дүгнэжээ.[108]

3) Шүүгдэгч Б.Б-ын хувьд бусдыг хуурч, төөрөгдөлд оруулж хохирогчтой хамтран ажиллах гэрээг хийсэн боловч мөнгөний шаардлагын улмаас дүр үзүүлэн хэлцэл хийж 50,000 ам.долларыг зарцуулж бусдын эд хөрөнгийг залилж авсан хэрэгт холбогджээ.

Уг хэргийг Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаас дараах байдлаар дүгнэжээ. Үүнд:

- Б.Б нь А.Г-аас 50,000 ам.долларыг олон улсын хөрөнгийн зах зээлд өндөр ашигтай арилжаанд хөрөнгө оруулж буй нэрийдлээр авч дийлэнх буюу 35,000 ам.долларыг хувийн хэрэгцээндээ зарцуулж үлдэх 15,000 ам.долларыг өндөр эрсдэл бүхий валют арилжаанд оруулж алдсан үйл баримтыг эргэлзээгүйгээр тогтоосон байна. Б.Б нь А.Г-д өөрийгөө олон улсын хөрөнгийн зах зээлд байнга ашигтай арилжаа хийсээр ирсэн гэж танилцуулан хөрөнгө оруулалт нэрээр авсан мөнгөн хөрөнгийг гэрээнд зааснаас өөр зориулалтаар өөрийн үзэмж сонирхлоор автомашин

[107] *Улсын Дээд шүүхийн тогтоол. 2021 оны 12 сарын 22-ны өдөр дугаар 03*
[108] *Улсын Дээд шүүхийн тогтоол. 2021 оны 04 сарын 02-ны өдөр дугаар 184*

худалдан авах зэргээр зарцуулж заримыг маржин арилжааны данс ашиглан валют арилжаалах чиглэлээр өөрөө хангалттай мэдлэг, ур чадвар эзэмшээгүй, ашиг олох ямар нэгэн баталгаагүй байхад эцсийн үр дүнд санаа зовохгүйгээр оруулж үрэгдүүлсэн нь Б.Б, А.Г нарын байгуулсан санхүүжилт, хөрөнгө оруулалтыг олон улсын хөрөнгийн зах зээлийн арилжаанд оруулж, арилжаанаас олсон өгөөжийг хуваарилах тухай “Хамтран ажиллах гэрээ”-ний агуулга зарчимд нийцэхгүй үйл ажиллагаа явагдсан гэж үзэхээр байна.

- Шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн зүгээс шат шатны шүүхүүдэд шүүгдэгч, хохирогч нарын хооронд гэрээ, хэлцэл байгуулагдсан хэмээн маргасаар ирсэн боловч үүсч болзошгүй өндөр эрсдэл бүхий үр дагаврыг хохирогчид эс танилцуулан, гэрээнд тусгалгүйгээр дарагдуулж их хэмжээний ашгийг ямар нэгэн эрсдэлгүй энгийн явцаар олох мэтээр бодит байдлыг гуйвуулан итгүүлж байгуулсан “хамтран ажиллах гэрээ” гэх бичгийн баримтыг залилах гэмт хэргийн халхавч гэж үзэх үндэслэлтэй. Цаашилбал, уг гэрээнд Б.Б /А тал/ нь А.Г /Б тал/ нь зөвхөн олсон ашиг орлогоос хувь хүртэх атал хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэг болох 35,000 ам.долларыг Б.Б хувьдаа ашиглан захиран зарцуулсан нь энэхүү гэрээг анхнаасаа дүр үзүүлэн хийсэн хуурамч гэрээ, хэлцэл гэж үзэхэд хүргэж байна.

Түүнчлэн, “Хамтран ажиллах гэрээ”-ний 3.4.1-д заасан дэлхийн зах зээлийн огцом хямрал, олон улсын валютын системийн гэнэтийн өөрчлөлт, хөрөнгийн зах зээлийн төв серверийн хэвийн үйл ажиллагаа доголдсон гэх нөхцөл байдал энэ хэрэгт тогтоогдоогүй бөгөөд шүүгдэгч Б.Б нь 15,000 ам.долларыг арилжаанаас татан авах боломжтой байсан хэдий ч аз сорих хэлбэрээр бүгдийг алдсан нь хамтран ажиллах гэрээний зорилгыг хангаж ажиллах хүсэл эрмэлзлэл үгүй байсныг харуулна.

Иймээс 2016 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Peace mall” худалдааны төвийн байранд А.Гас 50,000 ам.долларыг хөрөнгө оруулалт нэрээр авч, 114,483,500 төгрөгийн буюу их хэмжээний хохирол учруулсан нь залилах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг бүрэн хангасан гэж үзсэн бөгөөд энэ талаарх анхан болон давж заалдах шатны шүүхийн дүгнэлт үндэслэл бүхий болсон гэж дүгнэжээ[109].

4) Ү.С- нь 2015 оны 09 дүгээр сараас 11 дүгээр сарын 09-ний хооронд өөрийн эзэмшлийн Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо, 72 дугаар хотхонд байрлах газар дээр Б.Ж-тай 178,000,000 төгрөгийн барилгын хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, 3 давхар барилга бариулах ажлыг гүйцэтгүүлсэн боловч мөнгийг бүгдийг төлөлгүй, 148,495,545 төгрөгийн хохирол учруулсан буюу уг барилгын ажлыг дахин өөр этгээдээр бариулан ашиглалтад оруулж, Б.Ж-гийн хөрөнгө оруулалт хийсэн мөнгийг нь төлөлгүй залилсан гэх гэмт хэрэгт холбогджээ.

Уг хэргийг Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаас дараах байдлаар дүгнэжээ. Үүнд:

- Хэрэгт цугларсан нотлох баримтуудыг шинжлэн судалбал Ү.С- нь Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо, 72 дугаар хотхонд байрлах өөрийн эзэмшил газар дээр баригдаж буй барилгын гүйцэтгэлийг бүрэн дуусгах, холбогдох хөрөнгө оруулалт олох зорилгын хүрээнд иргэн Б.Ж-тай харилцан санал бодол, хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэн тохиролцож,

[109] *Улсын Дээд шүүхийн тогтоол. 2021 оны 01 сарын 08-ны өдөр дугаар 27*

барилгын хөрөнгө оруулалтын гэрээ байгуулжээ. Улмаар гэрээний үүргийн биелэлт, хугацаа, хөрөнгө оруулалтын дүнгийн хэмжээ зэрэг асуудлаар талууд хооронд маргаан өрнөсөн байх бөгөөд энэ талаар Б.Ж- нь цагдаагийн байгууллагад гомдол гаргаж, прокуророос эрүүгийн хэрэг үүсгэж, Y.C-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2.2-т заасан бусдыг хуурч их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэж яллах дүгнэлт үйлдэн хэргийг шүүхэд шилжүүлсэн нь үндэслэлгүй болжээ.

- Эрүүгийн хуульд тодорхойлсон гэмт хэргийн бүх шинжийг агуулж буй үйлдэл хийсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг бөгөөд эрүүгийн эрх зүйн онол болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт нийгэмд аюултай тодорхой үйлдлийг гэмт хэрэг гэж тодорхойлж буй Эрүүгийн хуульд заасан объектив болон субъектив шинжүүдийн нэгдэл юм.

Тодруулбал, энэхүү хоёр шинжийн аль аль нь хангагдсан тохиолдолд гэмт хэрэгт тооцох учиртай бөгөөд дан ганц үр дагаварт түшиглэсэн объектив яллах ажиллагааг Эрүүгийн эрх зүйн онол, хууль ёсны зарчмаар хориглодог.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд заасан залилах гэмт хэргийг шүүх шийдвэрлэхдээ гэм буруугийн сэдэл, санаа зорилго, түүнийгээ хэрэгжүүлсэн арга хэрэгсэл, гэм буруутай хүн болон хохирогчийн хувийн байдал, тэдгээрийн хоорондын харилцааны түүх зэрэг нөхцөл байдлуудад зөв дүгнэлт хийж, яллах болон цагаатгах нотлох баримтыг нэгэн адил цуглуулан, хэргийг бүх талаас нь шалгаж бүрэн бодитой тогтоох ёстой.

Дээрх жишээнээс харахад дуусаагүй барилгын гүйцэтгэл, түүний хөрөнгө оруулалтын гэрээний харилцаанаас үүдэлтэй маргааны шинжийг шүүх буруу тайлбарлаж, гэрээний үүргийн үнэлгээг эс зөвшөөрч маргасан санаа зорилгыг бусдын эд хөрөнгийг буцааж өгөхгүй, хариу төлбөр огт хийхгүй байхаар урьдаас төлөвлөж хэрэгжүүлсэн байдаг залилах гэмт хэргийн субьектив санаатай адилтган буруу дүгнэлт хийснээс иргэний эрх зүйн харилцааны асуудлыг залилах гэмт хэрэгт тооцсон байна.

Мөн Y.C-гийн үйлдэлд хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар бусдын эд хөрөнгийг залилан авах санаа зорилго үгүйсгэгдэж байх бөгөөд тэрээр өөрийн өмчлөлийн барилгад Б.Ж-гийн зүгээс хөрөнгө оруулаагүй, эсхүл түүнийг мөнгийг төлөхгүй гэж маргаагүй бөгөөд гагцхүү барилгын ажлын гүйцэтгэлийн зардал болон түүнд оруулсан бодит хөрөнгийг төлөх хүсэлтэй байгаагаа тогтвортой мэдүүлсэн нь хэрэгт авагдсан бусад нотлох баримтаар давхар батлагдаж байхад түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон нь хууль зүйн үндэслэлгүй байх тул Y.C-д холбогдох хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1.1-д заасныг баримтлан хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгах нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэжээ.

Иймд шийтгэх тогтоол, магадлалыг тус тус хүчингүй болгож, “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр Y.C-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгаж, цагаатгагдсан этгээд Y.C- болон түүний өмгөөлөгч Т.Урангэрэл, Р.Оюунцэцэг, Л.Данзанноров нарын гаргасан “...залилах гэмт хэрэг үйлдээгүй, Иргэний эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан тул хэргийг хэрэгсэхгүй болгож,

цагаатгуулах” агуулгатай гомдлыг хангах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэжээ[110].

5) Х.Б- нь 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Ч.Ү-гаас 4,000,000 төгрөгийг, 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Э.Н-эс 3,500,000 төгрөгийг “Голомт банкнаас орон сууцны зээл авч байгаа, зээл бараг бүтсэн” хэмээн хуурч зохиомол байдлыг зориудаар бий болгож бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулан залилсан гэмт хэрэгт холбогджээ.

Уг хэргийг Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаас дараах байдлаар дүгнэжээ. Үүнд:

- Хэрэгт цугларсан нотлох баримтуудыг шинжлэн судалж үзвэл Х.Б- нь худалдан авах гэж буй орон сууцаа ипотекийн 8 хувийн зээлд хамруулахаар өөрийн гэр бүл, төрөл, садан болон бусдаас мөнгө зээлж авсан нөхцөл байдал тогтоогдож байна. Харин тэрээр Ч.Ү-, Э.Н нараас 7.500.000 төгрөгийг өдрийн болон сарын хүүтэйгээр зээлж авсан боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага түүний данснаас Ч.Ү-гийн зээлсэн 4.000.000 төгрөгийг татан авснаар орон сууцны урьдчилгаа мөнгө бүрдүүлэх асуудал хэрэгжих боломжгүй болж үүнээс шалтгаалан дээрх нэр бүхий хүмүүсийн мөнгийг тохирсон хугацаандаа төлж чадаагүй байх ба үүнийг бусдын эд хөрөнгийг залилж авсан гэж үзэх үндэслэлгүй.
- Өөрөөр хэлбэл, дээрх хэлцлийн хүрээнд Х.Б-ийн хийсэн үйлдлүүдийг бусдын эд хөрөнгийг залилах субьектив санаа зорилгын хүрээнд үйлдсэн байж болзошгүй гэж холбогдох бүх шалгалтуудыг хийсэн байх боловч мөрдөн байцаалтаар түүнийг гэм буруутай болохыг хөдөлбөргүй тогтоож чадаагүй байх бөгөөд энэ нь Х.Б-ийн болон бусад хүмүүсийн хооронд үүссэн харилцаа Иргэний хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэгдвэл зохих, гэрээний эрсдэлээс үүдсэн иргэний эрх зүйн маргааны шинжтэй болохыг харуулж байна.

Эрүүгийн хуульд тодорхойлсон гэмт хэргийн бүх шинжийг агуулж буй үйлдэл хийсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг бөгөөд эрүүгийн эрх зүйн онол болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт гэмт хэргийн шинж гэдэгт тодорхой нийгэмд аюултай үйлдлийг гэмт хэрэг гэж тодорхойлж буй Эрүүгийн хуульд заасан обьектив болон субьектив шинжүүдийн нэгдлийг ойлгодог болно. Тодруулбал, энэхүү хоёр шинжийн аль аль нь хангагдсан тохиолдолд гэмт хэрэгт тооцох учиртай бөгөөд дан ганц үр дагаварт түшиглэсэн обьектив яллах ажиллагааг Эрүүгийн эрх зүйн онол, хууль ёсны зарчмаар хориглодог болно.

- Гэрээний үүргийн биелэлтээс шалтгаалсан маргаантай асуудлыг Иргэний хуульд заасны дагуу шийдвэрлэх бүрэн боломжтой буюу энэ хэрэг нь гэрээнд заасан үүргийн гүйцэтгэлтэй холбоотой байх бөгөөд анхан шатны шүүх Х.Б-ийн үйлдлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1.1-д заасан гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгон түүнийг цагаатгаж шийдвэрлэсэн хууль зүйн үндэслэлтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэжээ[111].

Улсын дээд шүүхийн тогтоолд анализ хийж үзэхэд анхан болон давж заалдах шатны шүүхээс залилах гэмт хэргийг шийдвэрлэхдээ иргэний эрх зүйн

[110] *Улсын Дээд шүүхийн тогтоол. 2019 оны 12 сарын 13-ны өдөр дугаар 646*
[111] *Улсын Дээд шүүхийн тогтоол. 2020 оны 07 сарын 17-ны өдөр дугаар 422*

гэрээнээс үүдэлтэй маргаанаас ялгагдах шинжийг анхаарах шаардлагатай байгаа нь шүүхийн шийдвэрүүд хууль хэрэглээний хувьд харилцан адилгүй байдлаар шийдвэрлэгдэж байгаагаас харагдаж байна. Өөрөөр хэлбэл залилах гэмт хэргийн шинж, сэдэл, санаа зорилгыг зөв тогтоох шаардлагатай байна.

Түүнчлэн Улсын Дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхим гэрээний харилцаанаас үүдэлтэй анхан болон давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргүүдийг хянахдаа Улсын Дээд шүүхийн 2006 оны 12 сарын 21-ний өдрийн 51 дугаар тогтоолоор батлагдсан Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан “бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах” гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар гаргасан тайлбарын агуулгыг тогтоолын тодорхойлох хэсэгт дурьдаж буй нь түгээмэл байгааг хэлэх нь зүйтэй. Мөн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон яллагдагч, шүүгдэгч нарын өмгөөлөгчид болон прокуророос шүүхэд гаргаж буй дүгнэлт, тайлбар, эсэргүүцэлд дээрх тайлбарын агуулга олонтой дурьдагдаж байгаа нь ажиглагдаж байна.

Дээрх тогтоол нь 2017 оны 07 сарын 01-ний өдрийг хүртэл үйлчилж байсан 2002 оны Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан “бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах” гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний маргаанаас ялгаж шийдвэрлэхэд хууль хэрэглээний хувьд хуулийн зохицуулалтыг бүхэлд нь тайлбарлаагүй болохыг анхаарах нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл тухайн үеийн нийгмийн харилцаа, хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулийг хэрхэн нэг мөр ойлгож, хэрэглэхэд дээрх тайлбар нь ач холбогдолтой байсан хэдий ч өнгөрсөн 16 жилийн хугацаанд нийгэмд олон төрлийн шинэ харилцаа тэр дундаа эдийн засгийн шинжтэй харилцаанууд үүсч бий болсоор байгаа нь хууль, тогтоомжийн шинэлэг зохицуулалт шаардлагатай байгааг харуулж байна. Тухайлбал: Криптовалют, цахим мөнгө, виртуал хөрөнгийн арилжаа, худалдаатай холбоотой харилцаанд олон мянган иргэд оролцож энэ явцад арилжаанд оролцогчдын хооронд тодорхой хэлцлүүд хийгдэж уг хэлцлийн улмаас оролцогчид мөнгө, эд хөрөнгөө алдах, цахим залилан буюу сүлжээний бизнес ашиглан залилах гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаа явуулж иргэдийг хохироох зэрэг асуудлууд үүсч буйг дурьдах нь зүйтэй.

4.2. Залилах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдалд хийсэн судалгаа, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн “Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай” 120 дугаар тогтоолын 5 дахь бүлгийн 293 дахь хэсэгт “Ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, авлига, албан тушаалын болон шинэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхитай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголттой болгох” ажлын хүрээнд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлыг төлөвлөсөн нь манай улсын тухайд эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн гол ажлын нэг болсон билээ[112].

---

[112] *Т.Мэндсайхан ахлагчтай судалгааны багаас хийсэн “Монгол Улсын Эрүүгийн хуулийг шинэтгэх төслийн санал”, ХЗҮХ-гээс 2004, 2009 онуудад хийсэн “Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн төлөв байдал” гэсэн суурь судалгаа, ХЗДХЯ-ны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгээс боловсруулсан зарим баримт, бичгат дурдсан схем, шүүмж, санал, дүгнэлт, зөвлөмжүүд, Академич С.Нарангэрэлийн боловсруулсан “Эрүүгийн төрөлжсөн хуулийн төсөл”*

Залилах гэмт хэргийн шинжийг 2015 оны Эрүүгийн хууль тогтоомжоор тогтоосон байдал, Шүүхийн ерөнхий зөвлөл[113], Цагдаагийн ерөнхий газар[114], Улсын Ерөнхий прокурорын газар[115], шүүхийн шийдвэрийн цахим сан[116] зэргээс шүүхийн шийдвэрлэлт, шийдвэрийн хууль зүйн үндэслэл, шүүгдэгчид хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаарх асуудлаар судалгаанд дүн шинжилгээ хийсэн бөгөөд анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхээр залилах гэмт хэргийн шинжийг авч үзэж байгаа талаар дүн шинжилгээ хийсэн болно.

Энэхүү ажлын хүрээнд холбогдох хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Эрүүгийн хуулийн гинэчилсэн найруулгыг баталж, хуулийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөөд 5 жил болж байгаа бөгөөд хуулийн дагуу хэрэгжилтийг нь үнэлэх цаг ирсэн байна[117].

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн 1 дэх заалтад “Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” хэмээн хуульчилсан[118].

Мөн дээрх гэмт хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж, бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн, байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон, олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны залилах аргаар үйлдсэн, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл гэж тусгажээ[119].

Дээрх хуулийн зохицуулалтаас үзэхэд залилах гэмт хэргийн үйлдлийн аргыг:

1. Хуурах;

2. Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах;

3. Зохиомол байдлыг зориудаар бий болгох;

4. Сүсэг бишрэлийг далимдуулах;

5. Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах;

6. Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах зэргээр тодорхойлж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авах боломжийг хуулиар хязгаарлажээ.

Харин өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлд “Бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг

---

[113] *Шүүхийн Ерөнхий зөвлөл (judcouncil.mn)*
[114] *Цагдаагийн ерөнхий газар (police.gov.mn)*
[115] *Монгол улсын ерөнхий прокурорын газар (prokuror.mn)*
[116] *Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)*
[117] *Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т зааснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг 5 жил тутамд үнэлэх бөгөөд шаардлагатай бол уг хугацаанаас өмнө хийнэ.*
[118] *Эрүүгийн хууль (legalinfo.mn)*
[119] *Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг*

хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ" хэмээн заасан ба дээрх гэмт хэргийг үйлдсэн арга хэлбэр, тухайн гэмт хэргийг үйлдсэн субьект, гэмт хэрэгт хамтран үйлдсэн байдал, хохирлын хэмжээ зэргийг харгалзан хүндрүүлэх нөхцөл байдал гэж авч үзэхээр хуульчилсан байв. 2002 оны Эрүүгийн хуулиар "Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх" гэмт хэрэг үйлдэх аргыг "хуурч мэхлэх", "итгэл эвдэх" гэсэн 2 агуулгаар авч үзэж, Улсын Дээд шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн "Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлд заасан "Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах" гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар" 51, 55 дугаар тогтоолын хүрээнд тайлбарлаж[120], иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчилж байсан. Харин 2015 оны Эрүүгийн хуулиар залилах гэмт хэрэг үйлдэгчийн гэмт хэрэг үйлдсэн арга барилыг илүү дэлгэрэнгүй, тодорхой байдлаар тусгасан нь энэ төрлийн гэмт хэргийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэхэд дөхөм болсон байна.

Бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалт, хамгаалалтад байгаа өмч хөрөнгийг хулгайлах, дээрэмдэх, залилах, завших, устгах, гэмтээх, үрэгдүүлэх, зөвшөөрөлгүй авч явах зэрэг хууль бус аргаар эзэмшилдээ авч байгаа гэмт этгээдийн халдлагад өртөгдсөн бүх төрлийн үнэт эд хөрөнгө, мөнгө, мөнгийг орлох, эсхүл шууд худалдан мөнгө болгож болох /шатахуун, үзвэрийн тасалбар зэрэг/ үнэт цаас бол өмчлөх эрхийн халдлагын зүйлийн онцлогийг харгалзан тусгай зүйл болгон хуульчилсан[121].

Обьектив, субьектив шинж нь гэмт этгээд бусдын өмч хөрөнгийг хулгайлсан, дээрэмдсэн, залилсан, завшсан, устгасан, гэмтээсэн, өгөхийг шаардаж заналхийлсэн зэрэг идэвхтэй үйлдлээ шууд санаатайгаар, шунахай сэдэлтээр өдүүлж[122], түүний төгсгөлийн хохирлыг хүсэж бий болгосон, өөрийн юм шиг захиран зарцуулах боломж бүрдүүлсэн байна. Гэм буруутай этгээдийн хууль зөрчсөн үйлдлийн улмаас учруулсан хохиролтой шалтгаант холбоотой байна.

Залилах гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйл/ өмчлөх эрхийн эсрэг бусад гэмт хэрэг, тухайлбал, хулгайлах, дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх, авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах гэмт хэргээс өмчлөгч хууртагдан итгэсэн учраас гэмт этгээдэд эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээ сайн дураараа өгсөн байдгаараа ялгаатай. Мөн гэмт этгээд анхнаасаа бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн аваад буцаан өгөхгүй, өмчлөх эрхийг сэргээхгүй байх санаа зорилготой байх бөгөөд ингэхийн тулд өмчлөгчийг хууран мэхлэж, төөрөгдүүлсний улмаас эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан байна[123].

Залилах гэмт хэргийн онцлог нь хохирогч өөрөө эд хөрөнгөө буюу өмчлөх эрхээ гэмт этгээдэд сайн дураараа шилжүүлэн өгсөн байдгаараа бусад төсөөтэй гэмт хэргээс ялгаатай[124]. Залилах гэмт хэргийг зөв зүйлчлэхэд төсөөтэй бусад гэмт хэргээс ялгагдах онцлог шинжийг нарийвчлан тодорхойлох нь онол,

---

[120] Улсын дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл,УБ,2008 он, Тогтоол 2006.12.21 №51
[121] Х.Доржпалам. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй/Тусгай анги/. УБ., 2021. 109 дэх тал
[122] Мөн тэнд
[123] С.Гантулга. Б. Энхболд. Эрүүгийн эрх зүй/Тусгай анги/. УБ., 2018. 189 дэх тал
[124] Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн тусгай анги/Сурах бичиг/. УБ., 2012. 82 дахь тал

практикийн чухал ач холбогдолтой. Нэн тэргүүнд өмчлөх эрхийн дараах гэмт хэргүүдээс ялган зүйлчлэх нь чухал.

Үүнд:

1. Хулгайлах гэмт хэрэг /17.1 дүгээр зүйл/ нь үндсэн бүрэлдэхүүний хувьд авч үзвэл, обьект нь бусдын өмчлөх эрхэд шууд халддагаараа энэ гэмт хэргүүд төсөөтэй.

Обьектив тал нь хулгайлах гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авахаар илэрдэг.

Харин залилах гэмт хэргийг үйлдэхдээ хуурч, зохиомол байдлыг зориудаар бий болгох, бусдыг төөрөгдөлд оруулах, итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан, эсхүл түүнийг эзэмших эрхийг түүний зөвшөөрөлтэйгээр нүдэн дээр нь илээр хууль бусаар олж авдгаар ялгагдана. Өөрөөр хэлбэл хохирогч төөрөгдөж, хууртагдсаны улмаас эд хөрөнгөө өөрөө гэмт этгээдэд сайн дураараа өгдөг.

Субьектив тал нь шунахайн сэдэлт, зорилготой, санаатай хэлбэрээр гэм буруу нь илэрдгээрээ хоёр гэмт хэрэг төстэй. Харин гэмт хэрэг үйлдэх үеийн гэмт этгээдийн сэтгэл санааны байдал нь хулгайлах гэмт хэрэгт гэмт этгээд өөрийнх нь үйлдэл нууц далд аргаар, хохирогчид мэдэгдээгүй хийгдсэн гэсэн итгэл үнэмшилтэй байдаг.

2. Дээрэмдэх гэмт хэрэг /17.2 дугаар зүйл/ нь үндсэн бүрэлдэхүүний обьектын хувьд үндсэн шууд обьект нь төсөөтэй ч, дээрэмдэх гэмт хэрэгт хүний амь бие, эрүүл мэндийн халдашгүй эрхийг зөрчиж халдсан давхар обьекттой байдгаараа энэ төрлийн гэмт хэргүүдээс ялгаатай.

Обьектив талд бусдын эд хөрөнгийг хууль бусаар авах арга нь түүний эд хөрөнгийг илээр, хүч хэрэглэж эсвэл хүч хэрэглэхгүйгээр, хүч хэрэглэхээр заналхийлж авахаар довтолсон, хууль бусаар авсан байдгаараа залилах гэмт хэргээс ялгаатай. Энэ гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг хууль бусаар авсан гэмт үйлдлийн улмаас хохирол учирсан байхыг шаардахгүй, үйлдэл хийснээр төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм. Өөрөөр хэлбэл бусдын эд хөрөнгийг хууль ёсны өмчлөгч, эзэмшигч, итгэмжлэн хариуцсан, хамгаалах үүрэг бүхий хүнээс өөртөө авснаар төгсдөг. Харин залилах гэмт хэрэг материаллаг болон хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт хамаардаг[125].

Субьектив талд гэмт этгээд бусдын эд хөрөнгийг түүний амь биед аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхгүйгээр, хүч хэрэглэхээр заналхийлж довтолж байна гэсэн сэтгэхүйн шийдэл төрсөн байдгаараа судалж буй гэмт хэргээс ялгагдана.

3. Хөрөнгө завших гэмт хэрэг /17.4 дүгээр зүйл/ нь гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний обьектын хувьд халдлага чиглэсэн эрх ашгаараа залилах гэмт хэрэгтээ төстэй.

Обьектив тал нь гэмт этгээдийн зүгээс санаачлага гаргаагүй байхад хохирогч өөрөө эд зүйлээ сайн дураараа буюу бусад зорилгоор итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг ашиглаж завшсан байдгаараа залилах гэмт хэргийн үйлдлээс ялгаатай. Залилах гэмт хэрэг нь гэмт этгээдийн санаачилгаар буюу хохирогч эд хөрөнгөө гэмт этгээдэд сайн дураараа

[125] *Х.Доржпалам. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй/Тусгай анги/. УБ., 2021. 112 дахь тал*

шилжүүлсэн байдаг бол хөрөнгө завших гэмт хэргийн хувьд эд хөрөнгө гэмт этгээдэд түр шилжсэн байдаг.

Субьектив тал нь шунахай сэдэлт, зорилготойгоор гэм буруугийн санаатай хэлбэрээр илэрдгээрээ нийтлэг юм. Итгэмжлэн өгсөн эд хөрөнгийг хүлээн авсны дараа завших, үрэгдүүлэх гэмт санаа төрдөг онцлогоороо, залилах гэмт хэрэгт уг санаа гэмт үйлдлээс эхэлж төрдөг шинжээс ялгагдана.

Анхан шатны шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.4 дүгээр зүйл буюу “хөрөнгө завших” [126] гэмт хэрэгтэй давхар зүйлчлэх эсвэл залилсан үйлдлийг хөрөнгө завших гэж үзэх, хөрөнгө завшсаныг залилах гэмт хэрэг гэж зүйлчлэх зэргээр дүгнэсэн тохиолдол ч байна. Зүйлчлэлийн энэ мэт маргаантай тохиолдолд мөрдөгч, прокурорын зүгээс тухайн этгээдийг хоёр зүйл ангиар давхар зүйлчилж, шүүхэд шилжүүлэх нь түгээмэл байдаг[127]. Ийм тохиолдолд туршлагатай, чадвартай шүүгч, прокурорын яллах дүгнэлтэд дурдсан хоёр зүйл ангийн нэгийг нь хэрэгсэхгүй болгож, нэг зүйл ангиар яллаж байгаа бол шинээр томилогдсон, залуу шүүгчдийн хувьд прокурорын дүгнэлтэд хөтлөгдөн хэргийг шийдвэрлэх тохиолдол ажиглагдаж байна.

4. Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших /17.5 дугаар зүйл/

Обьект нь үндсэн бүрэлдэхүүний хувьд авч үзвэл, бусдын өмчлөх эрх байдгаараа энэ төрлийн гэмт хэргүүд төсөөтэй[128].

Обьектив талд төлбөр тооцооны алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, эд хөрөнгө, гээгдэл эд хөрөнгө, алдуул малыг завшсан идэвхтэй үйлдэл байдгаараа залилах гэмт хэргээс ялгагдана. Энэ гэмт хэргийн обьектив тал нь гэм буруутай этгээд халдлагын зүйлээ бусдын эд хөрөнгө болохыг мэдсээр байж буцааж өгөөгүй эс үйлдэхүйгээр, өөртөө авч завшсан идэвхтэй үйлдлээр илэрдгээрээ энэ төрлийн гэмт хэргүүдээс ялгагдах онцлогтой [129] . Энэхүү үйлдлийн улмаас бусдад бага хэмжээнээс дээш хэмжээний хохирол учирсан байх бөгөөд завшсан үйлдэл, хохирол хоёрын хооронд шалтгаант холбоо байна.

5. Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх /17.6 дугаар зүйл/ гэмт хэрэг нь үндсэн бүрэлдэхүүний хувьд авч үзвэл, бусдын өмчлөх эрхэд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, эрүүгийн хуулийн тусгай ангид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдгаараа залилах гэмт хэрэгтэй төсөөтэй.

Обьектив тал нь бусдын эд хөрөнгө, эдийн болон эдийн бус эрхийг авахыг шаардаж, зөвхөн хохирогчид төдийгүй түүний ойр дотны хүмүүст хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж, хууль ёсны эрх, ашиг сонирхолд ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт мэдээлэл тараахаар сүрдүүлдэг, уг заналхийлэл, сүрдүүлгийн аюул тухайн цагт тулгараагүй хожим хэрэгжих шинжтэй үйлдэл байдгаараа судалж буй гэмт хэргээс ялгагдана.

---

[126] *Ц.Цэлмэг, Д.Оросоо. “Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ” Нээлттэй Нийгэм Форум. Шүүхийн шийдвэрийн судалгаа:Цуврал 2. УБ., 2021. 62 дахь тал*

[127] *Мөн тэнд*

[128] *С.Гантулга. Б. Энхболд. Эрүүгийн эрх зүй/Тусгай анги/. УБ., 2018. 192 дахь тал*

[129] *Х.Доржпалам. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй/Тусгай анги/. УБ., 2021. 109 дэх тал*

Субьектив тал нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн[130] байдгаараа төсөөтэй.

6. Хууль бусаар нийгмийн халамж, үйлчилгээ авах /18.12 дугаар зүйл/ гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний хувьд авч үзвэл, обьект нь нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ авах талаар хуулиар тогтоосон харилцаа байна.

Обьектив тал нь хуурамч баримт бичиг, эд зүйл ашиглаж, зохиомол байдлыг зориудаар бий болгож, бодит байдлыг нууж нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээг авсан идэвхтэй үйлдэл байна.

Субьектив тал нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Шунахайн сэдэлттэй, нийгмийн халамж үйлчилгээ авах гэсэн зорилготой. Өөрөөр хэлбэл сэдэлтийн хувьд залилах гэмт хэрэгтэй төстэй ч зорилгын хувьд өөр байна.

Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцсон л бол тухайн гэмт хэрэг бүрийн шинж тус тус хангагдсан байх нь нийлмэл гэмт хэрэгт тооцогдох үндэслэл болно.

Залилах гэмт хэргийг үйлдэхдээ Эрүүгийн хуулийн 18.7 дугаар зүйлд нэрлэн заасан мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл, санхүүгийн баримтыг хуурамчаар үйлдсэн, мөн Эрүүгийн хуулийн 23.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэрлэн заасан баримт бичгийг хуурамчаар үйлдсэн болох нь тогтоогдвол нийлмэл гэмт хэргээр зүйлчилж болно[131].

Залилах гэмт хэргийг зүйлчлэхдээ шүүх зарим тохиолдолд нийлмэл гэмт хэрэг гэж зүйлчлээгүй тохиолдол байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.7 дугаар зүйлд заасан “...мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах” болон Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.2 дугаар зүйлд заасан **“**Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах” төрлийн гэмт хэрэг хийсэн бол нийлмэл гэмт хэргээр зүйлчлэх учиртай.

Хэрэв хуурамчаар үйлдсэн баримт бичиг нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.7, 23.2 дугаар зүйлд заасан баримт бичигт хамааралгүй бол нийлмэл гэмт хэрэг хэмээн үзэж зүйлчлэхгүй бөгөөд уг гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн гэж хүндрүүлэн зүйлчлэх тохиолдолд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.3 дугаар зүйлийн тохирох хэсгээр нийлмэл гэмт хэргээр зүйлчилнэ.

Залилагч этгээд өмчлөх эрхийг хязгаарлах, шилжүүлэхтэй холбоотой илт хууль бус хэлцлийг гэрчлүүлэх эсхүл бүртгүүлэхэд нотариатч, улсын бүртгэгчидтэй гэмт санаагаар нэгдсэн буюу хамтран оролцсон бөгөөд харин залилах гэмт хэрэгт нотариатч, улсын бүртгэгчидтэй хамтарсан шинжгүйгээр тухайн илт хууль бус хэлцлийг гэрчилсэн, бүртгэсэн баримт ашигласан бол

[130] *Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 2.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг*
[131] *Х.Доржпалам. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй/Тусгай анги/. УБ., 2021. 142 дахь тал.*

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.10, 17.3 дугаар зүйлүүдийн тохирох хэсгээр нийлмэл гэмт хэрэг гэж зүйлчлэх нь зохимжтой[132].

Залилах гэмт хэргээс олсон орлогыг зориулалтын бусаар зарцуулж үрэн таран хийснийг зарим тохиолдолд мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлэх тохиолдол гарч байна. Тухайлбал, 1902005640238 тоот хэрэгт " Б.Э нь Номин ХХК-ийн захирал Ш.Б-аас 20 тэрбум төгрөгийг бодит байдлыг нуух замаар төөрөгдөлд оруулж залилсан, уг залилах гэмт үйлдлийн улмаас бий болсон хууль бус эх үүсвэртэй мөнгөн хөрөнгийг өөрийн эхнэр, хүүхэд зэрэг дөрвөн хүний .... тоот данснуудад шилжүүлж, бэлэн болон бэлэн бусаар зарцуулан байнга, тогтвортой мөнгө угаасан" хэмээн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтад зааснаар зүйлчилжээ.

Залилсан мөнгө, эд хөрөнгөө бусдад шилжүүлсэн, үрэн таран хийсэн тохиолдолд энэ нь мөнгө угаах гэмт хэргийн шинж агуулахгүй. Учир нь уг мөнгөний эх үүсвэр нь хохирогчийн мөнгө, эд хөрөнгө учир гэмт хэргийн замаар олсон, хууль бус эх үүсвэртэй гэж үзэж болохгүй. Харин банк дээрэмдсэн, хар тамхины наймаа хийсэн зэрэг хууль бус эх үүсвэртэй мөнгийг хууль бус *эх* үүсвэрийг нь нуун далдлах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол мөнгө угаах гэмт хэрэг гэж үзнэ[133].

Залилах гэмт хэргийн сүүлийн 10 жилийн тоон өгөгдлүүд дээр статистик хэлбэлзэл олох далайцыг тооцон үзвэл, 2010 онд хамгийн бага буюу 688, 2021 онд хамгийн их буюу 6558 бол 2022 оны эхний 2 сарын байдлаар 2360 залилах гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Улс орны хөгжлийн төвшин, нийгэм, эдийн засгийн өсөлт, нийгмийн үзэгдлийн хувьсан өөрчлөлтийн үр дүнд Залилах гэмт хэргийн гаралт, түүний шалтгаант холбоо, үйлдлийн арга нь өөрчлөгдөх зэргээр гэмт хэргийн гаралт огцом өссөн үзүүлттэй байна[134]. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2010, 2013 онуудад тус бүр 1 хэрэг шийдвэрлэгдэж байсан бол 2019 оны байдлаар 38 болж өссөн нь анхаарал татаж байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дахь хэсгээр шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн 852 шийдвэрт дүн шинжилгээ хийхэд[135] залилах гэмт хэргийн хуурах шинжээр 349 хэргийг шийдвэрлэсэн байна. Энэ нь хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 41 хувийг эзэлж байгаа нь өндөр үзүүлэлт бөгөөд залилах гэмт хэргийн үндсэн шинж нь хуурах гэдгийг баталж байна. Мөн баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж 117 хэрэг гарсан байна. Үүнд: гэрээгээр халхавчилсан болон цахим мэдээллийн хэрэгсэл ашиглаж үйлдсэн хэргүүд мөн багтаж байна. Шүүгдэгч нь иргэний эрх зүйн журмаар гэрээ байгуулсны дараа залилах гэмт хэргийг үйлддэг байна. Гэрээ байгуулахаасаа өмнө залилах сэдэлт зорилготой байдаг.

---

[132] Ц.Цэлмэг, Д.Оросоо "Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ" Нээлттэй Нийгэм Форум. Шүүхийн шийдвэрийн судалгаа: Цуврал 2. УБ., 2021, 61 дэх тал

[133] Мөн тэнд 64 дэх тал

[134] Монголбанкны дэргэдэх санхүүгийн мэдээллийн албаны нэрэмжит эрдэм шинжилгээний хурал "Залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт":УБ.,2022, 5 дахь тал

[135] Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2017.07.01-ний өдрөөс 2022.05.01-ний өдөр хүртэл 852 хэргийг хянан шийдвэрлэхдээ залилах гэмт хэргийн үйлдлийн аргыг ихэнх тохиолдолд давхардуулан зүйлчилсэн байна.

Өөрөө биелүүлэх боломжгүй санал тавих, үйлдлээ баталгаажуулахын тулд гэмт хэрэг үйлдэх зохиомол байдлыг зориудаар бий болгож үйлдсэн 161 хэргийг шийдвэрлэсэн байна.

Эрдэмтэн, судлаачдын бүтээлд шашинтай холбоотойгоор хүнийг хуурч залилсан бол сүсэг бишрэлийг далимдуулах гэж тайлбарладаг. Уг үйлдлийн аргаар үйлдсэн хэрэг бүртгэгдээгүй байна. Энэ нь хохирогч шашинтай холбоотой асуудал учраас өөрийгөө хохирогч болсон гэдгийг мэддэггүй холбоотой байж болох юм.

Дампуурсан, үйл ажиллагаа нь зогссон, доголдсон, санхүүгийн алдагдалтай, хөрөнгө оруулалт шаардлагатай байдлыг нуух, хуурамч аудитын дүгнэлт гаргуулах зэргээр бусдыг төөрөгдүүлж, эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэн авч бусдыг төөрөгдөлд оруулсан 138 хэргийг шийдвэрлэсэн байна.

Залилах гэмт хэргийг ах, дүү, эцэг, эх, хамаатан садан, танилын хүрээгээ ашигласан үйлдэлтэй 87 хэргийг шийдвэрлэсэн байна.

Д/д	Үйлдлийн арга	Шийдвэрлэсэн хэрэг	Эзлэх хувь
1	Хуурч	349	41%
2	Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах	117	14%
3	Зохиомол байдлыг зориудаар бий болгох	161	18%
4	Сүсэг бишрэлийг далимдуулах	0	0
5	Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах	138	17%
6	Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах	87	10%

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дахь хэсгээр шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн 293 магадлалд дүн шинжилгээ хийхэд:

Д/д	Үйлдлийн арга	Шийдвэрлэсэн хэрэг	Эзлэх хувь
1	Хуурч	127	43%
2	Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах	48	16%
3	Зохиомол байдлыг зориудаар бий болгох	57	19%
4	Сүсэг бишрэлийг далимдуулах	0	0
5	Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах	39	13%
6	Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах	22	8%

Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн УДШ-ийн 185 тогтоолд дүн шинжилгээ хийхэд:

Д/д	Үйлдлийн арга	Шийдвэрлэсэн хэрэг	Эзлэх хувь
1	Хуурч	111	60%
2	Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах	18	9%
3	Зохиомол байдлыг зориудаар бий болгох	21	11%
4	Сүсэг бишрэлийг далимдуулах	0	0
5	Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах	24	13%
6	Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах	11	6%

Залилах гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн практик болон шийдвэрлэлтийн нөхцөл байдлыг тодруулах зорилгоор хуулийн байгууллагын алба хаагчдаас анкетын аргаар судалгаа авахад:

Судалгаанд хуулийн байгууллагын 200 ажилтан, албан хаагчид хамрагдсан бөгөөд тэдний 28 хувь нь прокурор, 27 хувь нь өмгөөлөгч, 22 хувь нь мөрдөгч, 21 хувь нь шүүгч, 2 хувийг эрдэм шинжилгээний ажилтан, бусад албан хаагч эзэлж байна. Судалгаанд хамрагдсан оролцогчдын 88 хувь нь залилах гэмт хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх ажиллагаанд оролцож байсан ба ихэнх тохиолдолд хуурч, зохиомол байдлыг зориудаар бий болгож, цахим хэрэгсэл ашиглаж, гэрээгээр халхавчилж залилдаг байна. Мөн залилах гэмт хэргийг хянан шийдвэрлэх явцад 53 хувь нь олон улсын гэрээ, конвенцийг судлах, гэмт хэргийн бодит хохирлыг нарийвчлан тооцох аргачлалыг бий болгох шаардлагатай байна.

Иргэдийн эрх зүйн мэдлэг дутмаг байдал нь гэрээгээр халхавчилсан залилан бий болоход хүргэх нэг шалтгаан болж байна. Энэ нь Улсын дээд шүүхийн 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 538 дугаартай тогтоолтой[136] холбоотой байж болох юм.

Залилах гэмт хэргийн хохирлын хэмжээг эрүүгийн хуульд нарийвчлан тогтоох шаардлагатай эсэхийг тодруулахад 90 хувь нь онц их хэмжээг нэмж оруулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Залилах гэмт хэрэг үйлдэгчдийн арга нь улам бүр нарийсч, эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг заасан үндсэн шинжүүдээр хязгаарлагдахгүй, зарим тохиолдолд хуульд заагаагүй аргаар үйлдэгдэж байх тул шийдвэрлэхэд хүндрэлтэй нь судалгааны явцад тогтоогдсон.

[136] *Гэрээний харилцаа нь иргэний хууль тогтоомжийн дагуу үүсч, гэрээний биелэлтийн талаар мэдээлэл солилцож, харилцан гомдлын шаардлага гаргаж, гэрээгээ дүгнэж байсны эцэст эрсдэлд орсны улмаас үүссэн маргааныг, өөрөөр хэлбэл гэрээний эрсдэлийг залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэхгүй. "...гэрээгээр хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтаглаж, бусдын эд хөрөнгө, эсхүл түүний өмчлөх эрхийг бүгдийг буюу заримыг шилжүүлэхгүй байх гэмт санаа зорилго төрж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх замаар хуурч мэхлэх, итгэл эвдэх, тодорхой үлдэл хийсэн нь тогтоогдвол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.*

Судлаачийн хувьд Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн танхимаар шийдвэрлэгдсэн Залилах гэмт хэргийн шинжийг хэрхэн практикт хэрэглэж байгаа талаар түүврийн аргаар дараах тогтоолд дүн шинжилгээ хийж үзлээ. Тухайлбал, Монгол Улсын Дээд Шүүхийн Хяналтын Шатны Эрүүгийн Хэргийн Шүүх Хуралдааны “2019 оны 12 сарын 13-ны өдрийн 646 дугаар тогтоол, 2019 оны 10-р сарын 23-ны өдрийн 538 дугаар тогтоол, 2019 оны 11-р сарын 25-ны өдрийн 607 дугаар тогтоол, 2019 оны 12-р сарын 16-ны өдрийн 661-р тогтоол, 2019 оны 09-р сарын 17-ны өдрийн 409 дүгээр тогтоол, 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 430 дугаар тогтоол, 2020 оны 06-р сарын 26-ны өдрийн 259 дүгээр тогтоол, 2020 оны 10 дугаар сраын 23-ны өдрийн 596 дугаар тогтоол, 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 644 дүгээр тогтоол, 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоол, 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 668 дугаар тогтоол, 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 14-р тогтоол, 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 680 дугаар тогтоол, 2020 оны 12 дугаар сарын 684 дүгээр тогтоол”-д дүн шинжилгээ хийсэн бөгөөд дээрх тогтоолын 8-д нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд заасан залилах гэмт хэргийн бусдыг хуурч, зохимол байдлыг бий болгож, бусдыг төөрөгдөлд оруулах замаар хөрөнгийг шилжүүлэн авсан гэх гэмт хэргийн шинжийг авч үзэх бөгөөд 2002 оны Эрүүгийн хуулийн хуурч мэхлэх, итгэл эвдэх зэрэг гэмт хэргийн шинжийг тайлбарлаж ирсэн практик туршлагаас салахгүй, бусдыг хуурч мэхлэх, итгэл эвдэх гэх ойлголтыг хэрэглэж байна. Гэтэл хууль тогтоогчийн зүгээс Эрүүгийн хуульд зааснаар гэмт этгээдийн нийгэмд аюултай гэж үзсэн үйлдлийг хуульчилж гэмт хэргийн шинжийг шинээр томьёолсныг анхаарах нь зүйтэй байна.

Тухайлбал, Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан “бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах” гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаарх 51 дүгээр тогтоолын 3, 4-т тусгаснаар

“… хуурч мэхлэх арга …” гэдэг нь бусдын эд хөрөнгө, түүнийг өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар олж авахын тулд үгээр буюу үйлдлээр, бодит байдлыг гуйвуулах, нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэхийг хэлнэ.[137]

[137] *Монгол улсын дээд шүүхийн тогтоол /дугаар 51/ 2006.12.21*

Хуурч мэхлэх арга нь худал хэлэх, хуурамч баримт бичиг, факс, дүрс болон дуу авианы бичлэг, техник хэрэгсэл, компьютерийн мэдээлэл, сүлжээ ашиглах буюу тусгай албаны хувцас, хэрэглэл, цол, тэмдэг хэрэглэж зориудаар төөрөгдүүлэх, дутуу буюу зориулалтын бус, эсхүл хуурамч буюу чанарын доголдолтой эд зүйлээр төлбөр хийх зэргээр илэрнэ.

"… итгэл эвдэх арга …" гэдэг нь гэрээний буюу гэрээний бус харилцаагаар итгэмжлэн олгосон бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар олж авахын тулд итгэмжлэлээр олгогдсон бүрэн эрхийг санаатайгаар зөрчиж, ашиглах замаар эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэхийг хэлнэ гэсэн хуульзүйн нэр томъёог хэрэглэж ирсэн практикт арилаагүй байна. [138]

2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд итгэл эвдэх арга гэж ерөнхий байлаар энэ төрлийн гэмт хэргийн шинжийг тусгасныг эрүүгийн хуулиар өөрчилж нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах гэж томьёолсон. Тухалбал, итгэл эвдэх арга нь тодорхой цаг хугацаа шаардахгүй, харин урьдын харилцааны явцад бий болсон итгэл гэдэг нь тодорхой цаг хугацаа, орон зайд бий болсон гэмт хэргийн субьект болон хохирогч нарын хооронд үүссэн тогтвортой харилцаа бий болсон байхыг шаардаж байхад өмнөх хууль зүйн ойлголтын уламжлал халагдаагүй байна.

Залилах гэмт хэргийн гаралт нь 2015 онд Эрүүгийн хууль шинэчлэн батлагдсанаас хойш эрс нэмэгдэх, эрүүгийн хариуцлагын бодлого харилцан адилгүй, гэмт хэргийн шинжийг ялимгүй агуулсан үйлдэлд ногдуулах эрүүгийн хариуцлага хэт хатуу, эсхүл 2002 оны Эрүүгийн хуульд зааснаар энэ төрлийн гэмт хэрэгт тодорхой материаллаг бүрэлдэхүүн шаардсанаар гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хуучин байдлаар авч үзэх нь зүйтэй гэж үзсэнийг дараах Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн байдлаар харуулбал, шүүгдэгч Б.Х нь иргэн Б.Ч-д өөрийгөө Дорнод аймгийн Баянхошуу боомтын орлогч дарга гэж танилцуулан түүнтэй гар утсаар холбогдон Дорнод аймгийн Баянхошуу боомтын отрядын орчимд манай 03-ын хамаатнууд хямдхан борц зарж байна, та борц худалдаж аваад ӨМӨЗО-руу гаргаж зарах уу" гэж хуурч, Б.Ч-ээс Хаан банкны 5059235892 дугаарын дансаар Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороонд байрлах Засгийн газрын 11 дүгээр байранд байрлах АТМ-аас 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр 180,000 төгрөгийг, Дорноговь аймгийн Замын-Үүд сумаас 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр 300,000 төгрөгийг бүюу нийт 485,000 төгрөгийг шилжүүлэн авч залилсан байна[139].

Шүүгдэгч С.Б нь 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хорооны нутаг дэвсгэрт иргэн Р.Ц ын эзэмшлийн "Самсунг Галакси Жи-5" маркын гар утсыг "найзтайгаа утсаар ярьчихаад өгье" гэж зохиомол байдлыг зориуд бий болгон хуурч, залилан авч, 160.000 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн болох нь хохирогч, яллагдагч, шинжээчийн дүгнэлт болон хэрэгт авагдсан бусад бичгийн нотлох баримтуудаар нотлогдон тогтоогдсон байна[140].

Залилах гэмт хэргийн шинж нь бусдын эд хөрөнгийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар шууд өөрийн мэдэлд авах, буцааж өгөхгүй, хариу төлбөр огт хийхгүй гэсэн субъектив санаа зорилготой байдаг бөгөөд, бодит байдлыг гуйвуулах, худал хэлэх зэргээр бусдын эд хөрөнгийг эзэмших, өмчлөх эрхийг өөртөө авах

---

[138] *Мөн тэнд*

[139] *Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 2021/ШЦТ/51 шийтгэх тогтоол*

[140] *Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 1006 дугаар шийтгэх тогтоол*

хэлбэрээр илэрдэг ба залилах гэмт хэргийн арга нь хуурамч мэдээллээр төөрөгдүүлэх, худал амлах зэрэг аргаар үйлдэгддэг[141] гэж дүгнэсэн байна.

Мөн Б.И нь 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 9 дүгээр хороо, Малчин ** тоотод байрлах нийтийн байрны ** тоот өрөөг хөлслөн амьдарч байхдаа тус байрны 7 тоотод амьдарч байсан иргэн Д.Б-ийн Вега загварын гар утсыг “ярьчхаад өгье” гэж хуурч, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж, бусдад 278,000 төгрөгийн хохирол учруулсан байна[142].

Өсвөр насны П.Э[143] нь 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо Нарантуул олон улсын худалдааны төвийн хойд талд байрлах Хаан банкны АТМ дээр иргэн Э.Мөнхжаргалыг өөрийн картаа уншуулаад мөнгө шилжүүлээд өгөөч гэж гуйхад нь “картны чинь код буруу байна” гэж хуурч, бодит байдлыг нуух замаар түүний Хаан банкны картыг нь буцааж өгөлгүй, өөрийн нэр дээр бүртгэлтэй картаар сольж өгөөд иргэн Э.Мөнхжаргалын данснаас түүний картыг уншуулан 258.000 төгрөгийг залилсан нь тогтоогдсон байна[144].

Х.Х.Б- нь 2020 оны 07 дугаар сарын 04-ний өдөр Дархан-Уул аймгийн Дархан сумын 5-р багаас иргэн Ж.Ж.Т-ийн 09-** ДАА улсын дугаартай тоёота Приус-20 маркийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлэхдээ “Самсунг жи-7” маркийн гар утсыг утсаар ярьчхаад өгьө гэж хуурч авч 230000 төгрөгийн хохирол учруулсан гэх гэмт хэрэгт холбогджээ[145].

“Капитал зууч” ХХК-ийн хөрөнгийн үнэлгээ хийсэн шинжээчийн дүгнэлтээр 2019 оны “Самсунг Жи-7” маркийн гар утас /хэрэглэж байсан/ 1 ширхэг эд зүйлийн үнэлгээ 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 230 мянган төгрөгөөр үнэлсэн байна.

Шүүгдэгч Х.Х.Б- нь гэмт үйлдэлдээ шууд санаатай хохирол, хор уршгийг хүсч, гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдсэн нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг хангасан тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 6 сарын хугацаагаар хорих ял оногдуулж шийдвэрлэсэн[146] байна.

Иргэн А Чингэлтэй дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Кентаур” зочид буудлын орчимд 2019 оны 11 дүгээр сарын

---

[141] *Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn) Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 1006 дугаар шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт ...*

[142] *Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 1143 дугаар шийтгэх тогтоол*

[143] *П.Э-н насанд хүрээгүй, хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар зэргийг харгалзан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 6 сарын хорих ял оногдуулж, оногдуулсан ялаас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-г үндэслэн чөлөөлсөн байна.*

[144] *Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 08 сарын 11 өдрийн 897 дугаартай шийтгэх тогтоол*

[145] *Дархан-Уул аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2021 оны 07 сарын 23-ны өдрийн шүүх хуралдаанаараа 2021/ШЦТ/0189 дугаартай хэргийг 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авч, хянан хэлэлцсэн байна.*

[146] *Дархан-Уул аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн2021 оны 07 сарын 23 өдрийн 0189 дугаартай шийтгэх тогтоол*

14-ний орой 20 цагийн үед иргэн М-ээс “гар утсаар чинь яриад өгье” гэж хэлэн иргэн Т.Мягмаршагайгийн өмчлөлийн 150.000 төгрөгийн үнэ бүхий Самсунг Эс-6 загварын гар утсыг хуурч эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан байна. гэмт хэрэгт холбогджээ[147].

Дархан-Уул аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс дахин гэмт хэрэгт үйлдсэн байдлыг харгалзан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 1 /нэг/ жил 5 /таван/ сарын хорих ял оногдуулахаар шийдвэрлэсэн[148] байна.

Дээрх шүүхийн шийдвэрүүдийг харьцуулан үзвэл залилах гэмт хэргийн бүрэлдэхүүнд материаллаг бүрэлдэхүүн буюу гэмт үйлдлийн улмаас тодорхой тоон үзүүлэлт бүхий хохирол, хор уршиг шаардаж, гэмт хэргийн нийгэмд аюултай гэх шинжийг хангахад илүү зохимжтой юм. Тухайлбал, Сонгинохайрхан дүүргийн 1143 дугаар шийтгэх тогтоолоор шүүгдэгч Б.И нь бусдын өмч болох 278.000 төгрөгний үнэтэй утас залилах гэмт хэрэг үлдсэн гэж шүүхээс 6 сарын хорих ял сонсож, цагдан хоригдсон 23 хоног байгаа нөхцөл байдлаас үзвэл 2015 оны Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан эрүүгийн хариуцлагын зорилготой нийцэхгүй, гэмт хэргийн шинжтэй ялимгүй үйлдэлд ногдуулсан ял нь хүндэтсэн гэж үзэх талтай. Дээрх эрүүгийн хэргүүдээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг зааж өгөөгүй, хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар хууль тогтоогчийн зүгээс баталсан нь гэмт хэргийн нөхцөл байдлыг өөрчлөх, ихсэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд “Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол...” гэснийг “бага хэмжээнээс ихгүй хохирол учирсан” гэж нэмж, материаллаг бүрэлдэхүүнтэй болгох нь зүйтэй юм.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3.1-д заасан “Амьдралын эх үүсвэр болгох” гэж заасан нь практикт тодийлөн нийцэхгүй байна. Учир нь гэмт этгээд хоёр ба түүнээс дээш удаа гэмт хэрэг үйлдэх нь гэмт хэргийн олонлогийн үндсэн шинж бөгөөд нэг төрлийн болон төсөөтэй гэмт хэргүүдийг үйлдсэн тохиолдолд олонлог нь давталтын хэлбэрээр илэрдэг. Нэг төрлийн эсхүл төсөөтэй гэмт хэргийг хоёр ба түүнээс дээш удаа үйлдэхийг эрүүгийн эрх зүйн онол, хууль хэрэглээний жишигт тусгай давталт гэж үздэг бөгөөд тэдгээр нь гол төлөв Эрүүгийн хуулийн тусгай ангийн нэг зүйл, хэсэг, заалтад тодорхойлсон, халдлагын объект, зүйл нэгтэй хэргүүд байдаг. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн 17.3 дүгээр зүйлд заасан бусдыг залилах гэмт хэргийг хоёр буюу түүнээс дээш удаа үйлдсэнийг хууль тогтоогч тусгай давталтанд хамааруулан зохицуулаагүй ба харин энэ хэргийг “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” бол тусгай давталт гэж хуульчилж уг хэргийн онц хүндрүүлэх бүрэлдэхүүнээр тогтоосон байна.

Гэмт этгээд Эрүүгийн хуульд заасан нэг төрлийн гэмт хэрэг дахин үйлдсэн тохиолдолд тусгай давталтад хамааруулан үздэг ба уг шинжийг Эрүүгийн хуульд

---

[147] Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 сарын 31-ний өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авч, хянан хэлэлцэв.

[148] Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 сарын 31 өдрийн дугаар 214 шийтгэх тогтоол

заасан зарим гэмт хэрэгт “байнга”, “байнга тогтвортой”, “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” гэж өөр өөрөөр заасан боловч эдгээр нь дээрх нөхцөл байдлыг илэрхийлсэн эрх зүйн утга, ач холбогдлын хувьд ижил ойлголтууд юм.

Эрүүгийн хуулиар тогтоосон дээрх хэм хэмжээнээс хамаарч гэмт хэрэг дахин үйлдсэн хүнд холбогдох хэргийг өөр өөрөөр зүйлчлэх боловч гэмт үйлдэл бүрийг тус тусд нь зүйлчлэхгүй бөгөөд нийтлэг ба тусгай давталтын шинж нь тухайн гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнээр хуульчлан тогтоогдсон тохиолдолд зөвхөн түүгээр нь, үгүй бол хуульд заасан бусад хүндрүүлэх шинжийг харгалзан хэргийг хүнд гэмт хэрэгт нь багтаан зүйлчлэх талаар дурджээ.[149]

Өөрөөр хэлбэл залилах гэмт хэргийг давтан үйлдсэн тохиолдолд хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт тооцох нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулах, эрүүгийн хуулийн зарчмыг гажуудуулах нөхцөл байдалд хүргэж болзошгүй юм.

[149] *Монгол Улсын Дээд шүүхийн 656 дүгээр тогтоол., 2019*

ДҮГНЭЛТ

1. Манай эриний өмнөх зуунаас эхтэй залилах гэмт хэрэг 1820, 1920- иод онд хөрөнгө оруулалтын залилан, пирамид залилан, 1980-иад оноос чек, валют, кредит картын залилан зэрэг хэлбэрээр гарч байсан бол 1990 оноос эдийн засгийн залилан, 2000 оноос хувь хүний мэдээллийг хуурамчаар ашиглан банкин дахь дансанд нь нэвтэрч хувьдаа завшин өмчлөх эрхэнд халдах байдлаар илэрч, өдгөө дэлхийн улсуудын хурдтай хөгжлийн шинэ эринд цахим болон сүлжээний залилан, койн, романс скэйм залилангийн үйлдлүүд зэрэг хэлбэр дүрсээ өөрчлөн, хүн төрөлхтнийг сүүдэр мэт дагаж, хор уршиг тарьсаар байгаа нь нэг ёсны эмгэнэлт гэмээр тэвчишгүй үйлдэл болсны улмаас олон улсын эрх зүй болон орон, орны хуулиуд энэ зүгт ихээхэн анхаарал хандуулж буй нь даяаршсан ертөнцийн шийдэх түвэгтэй асуудлын нэг гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй.

2. Худлыг мохоож, хулгайг цээрлүүлэх тухай Их эзэн Чингис хааны айлдвар, тухайн цаг үедээ Монгол гүрний үндсэн хуультай эн зэрэгцэхүйц үйлчилж байсан Их Засаг хуулиас эхлэн тус улсын эрүүгийн хууль тогтоомжид залгамж чанартайгаар шинжлэх ухааны үндэстэй тодорхойлогдсон залилах гэмт үйлдэл өнөө хэр манай нийгэмд амь бөхтэй оршсоор буй нь криминаль чиглэлийн эрдэмтдийн санааг зовоосон асуудал болж байгааг мэдэрч, хамтын дорвитой судалгааг хугацаа алдалгүй хийж, тодорхой үр дүнд хүрэх нь нийгмийн зүй ёсны хүлээлт болж байна.

3. Залилах гэмт хэргийн илрэх хэлбэр, үйлдэгдэж буй арга, ашиглах хэрэгсэл, нөлөөлөх хүчин зүйл, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх, хэрэг бүртгэх, мөрдөх, хянах, шүүх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, төгөлдөржүүлэх асуудлыг багийн бүрэлдэхүүнээр цогц судлан шинжилж, хүч хөрөнгө зориулан, энэ үйлсэд эргэлт гаргахыг эрх бүхий байгууллагууд нэн тэргүүний зорилтоо болгох.

4. 2017 оноос Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлснээр шүүхээр шийдвэрлэх хэргийн тоо нэмэгдсэн бөгөөд 2018 онд 27.000 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 7.000 орчим нь шүүхээр шийдвэрлэгдэж, 3.000 орчим залилах гэмт хэрэг бүртгэгдэж, 700 орчмыг нь шүүхээр хянан шийдвэрлэж байгаа нь анхаарал татаж байна. Залилах гэмт хэрэг үйлдэгчид нь шинжлэх ухаан, технологийн орчин үеийн шийдэл, арга зүй ашиглаж, үндэсний болон олон улсын санхүүгийн системд хор уршиг учруулж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн хамгаалалтыг сайжруулж, гадаадын бусад орны эрүүгийн эрх зүйн хамгаалалттай ижилсүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм. Иймд судалгааны ажилд үндэслэн дараах дүгнэлтэд хүрч байна.

5. “Залилах” нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, хүч хэрэглээгүй ашиглан шамшигдуулах шинжтэй хэлбэрийг нэрлэж ирсэн, эрүүгийн эрх зүйн уламжлал болсон нэр томьёо юм. Монгол Улсад болон дэлхийн олон улсад үйлдэгдэж, хүрээгээ тэлсээр байгаа залилах гэмт хэргийн бүрэлдэхүүн, хор уршиг, үйлдэгдэж буй арга хэлбэрийг “Залилангийн гурвалжин”, “Залилангийн масштаб онол”, “Залилан мэхлэх сэдлийн М.І.С.Е. онол”-ын *хүрээнд* судалж Монгол улсын эрүүгийн эрх зүйн зохицуулалтад дээрх онолуудыг ашиглах боломжтой юм.

6. Гэмт хэрэг бол бүх улс орны нийгмийн асуудал бөгөөд үүнтэй холбогдуулан гадаад улс орнуудад төрөл бүрийн гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжийн зохицуулалтыг судлах нь маш чухал юм. Учир нь гадаадын хууль тогтоомжийг судлах нь хуульчдад шинэ давхарга

нээж, түүнд илүү сайн ажиллах боломжийг олгодог байна.

7. Гадаадын зарим улс орны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж үзэхэд залилах гэмт хэрэг нь өсөх тусам эдийн засагт сөргөөр нөлөөлж, үндэсний хэмжээнд санхүүгийн дэг журмыг алдагдуулахад хүргэдэг учир залилангийн гэмт хэргийг төрөлжүүлэн хуульчилсан байна. Тухайлбал, ОХУ- ын Эрүүгийн хуульд залилах, зээлийн залилан, төлбөр хүлээн авах залилан, цахим төлбөрийн хэрэгсэл ашиглаж залилах, даатгалын салбарын залилан, компьютерийн мэдээллийн салбарын залилан, ХБНГУ-ын Эрүүгийн хуульд залилах, компьютерийн залилан, нөхөн төлбөрийн залилан, хөрөнгө оруулалтын залилан, даатгалын залилан, мөнгөн тусламжийн залилан, хуурах замаар ашиг олох, зээлийн залилан, спортын бооцооны залилан зэргийг гэмт хэрэг гэж үздэг байна. БНСУ мөн адил залилах болон бусад аргаар бусдын эд хөрөнгийг авах, компьютер, тусгай хэрэгсэл ашиглан бусдын эд хөрөнгийг залилан авах, мэргэшсэн залилан, Англи Улсын залилах гэмт хэргийн төрөлд хуурах аргаар бусдын газрыг авах, залилах аргаар мөнгөн шилжүүлэг хийх, зардлын ашигтай байдал үүсгэх, үйлчилгээ авах, өр төлбөрөөс зайлсхийх, комьпютер ашиглан залилах, мэдээллийг мэдэгдэх үүрэгтэй үед мэдэгдэлгүй залилах, албан тушаалын байдлыг урвуулан ашиглаж залилах, компанийн залилан зэргээр нарийвчлан тодорхойлж, гэмт хэрэгт тооцсон байна. Иймд дэлхийн бусад орны жишиг, гэмт хэргийн гаралт, гэмт хэрэг үйлдэж буй этгээдийн үйлдлийн арга зэргээс шалтгаалан залилах гэмт хэргийг төрөлжүүлэн, эрүүгийн хуульд тодорхой хуульчлах шаардлага тулгарч байна. Судалгаанаас үзэхэд Эрүүгийн хуульд залилах гэмт хэргийг цахим, даатгал, үл хөдлөх хөрөнгийн, санхүүгийн, пирамид залилан гэж төрөлжүүлэн хуульчлах боломжтой юм.

8. Монгол Улсын 2002 болон 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн залилах гэмт хэргийн шинжийг заасан диспозици нь хууль зүйн техник талаасаа 2002 оны Эрүүгийн хуульд “бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсан” гэж маш товч байдлаар тодорхойлсон бол 2015 оны Эрүүгийн хуульд “хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан” гэж үйлдлийн аргуудыг нарийвчлан хуульчилсан байна. Иймд Улсын Дээд шүүхээс “залилах” гэмт хэргийн шинжийг харгалзан уг гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар тайлбар гаргах шаардлага тулгарч байна.

9. Түүнчлэн 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдөр Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдаж, Улсын дээд шүүхэд гомдол гаргах 3 үндэслэлийг хуульчилсан. Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5 б) “хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн” гэх үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргах эрх хангагдахгүй байгаа нь Эрүүгийн хуулийн 17.3 дахь хэсгийг тайлбарласан УДШ-ийн албан ёсны тайлбар байхгүй байгаатай холбоотой юм.

10. Мөрдөгч, прокурор нь гэрээгээр халхавчилсан гэмт хэргийн үйлдлийг бүрэн гүйцэд шалгахгүй орхигдуулах, улмаар холбогдогч этгээд шүүхийн шатанд цагаатгах, ял завших тохиолдлууд практикт байсаар байгаа нь иргэдийн хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх, хуулийн байгууллагын үйл

ажиллагаанд үл итгэх сөрөг үр дагаврууды бий болгож байна.

11. Бусдын эд хөрөнгийг “зээл” нэрээр халхавчлан залилах нь уг зээлийг буцааж төлөх бодит баталгаагүй тухайлбал, барьцааны хөрөнгөгүй, хөрөнгө нь байлаа ч эрхийн зөрчилтэй, тухайн эд хөрөнгийг барьцаалах бүрэн эрхгүй этгээд барьцаалсан, түүнчлэн Иргэний хуульд заасан барьцааны гэрээ байгуулах журмыг санаатай зөрчсөн байдаг зэргээр иргэний эрх зүйн гэрээнээс ялгагдана. Залилах гэмт хэргийг мөрдөх, хянан шийдвэрлэхдээ хуульд заасан аргаар бусдын эд хөрөнгө эсхүл эд хөрөнгийн эзэмших эрхийг олж авах гэсэн субьектив санаа зорилготой байсан эсэхийг тогтоосон байвал зохино.

12. Сүүлийн жилүүдэд гэмт хэргийн гаралт, учруулсан хохирол, хор уршиг жил дараалан байнга өсөж, үйлдлийн арга нь улам нарийсч, зохион байгуулалттайгаар, цахим хэлбэрээр, олон улсын шинжтэй, улс орон дамнан үйлдэгдэх хандлагатай болж байна. Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар авч буй үйлдлийн улмаас учирсан хохирлын хэмжээгээр нь зөрчил, гэмт хэрэгт тооцож ирсэн практикийг өөрчилж, хулгайлах үйлдлийг хохирлын хэмжээ харгалзахгүйгээр гэмт хэрэгт тооцох нийгмийн шаардлага үүссэн байна.

13. Олон улс дахь эдийн засгийн үйл явцын хөгжил, даяаршил, хууль эрх зүйн ашиг сонирхолд тулгуурлан дэлхийн улс орнуудад гэмт явдал, гэмт хэрэгтэй тэмцэхдээ эрх зүйн үндсэн нэр томьёог нэгдмэл байдлаар ойлгож тайлбарлах хэрэгцээ шаардлага бий болж байгаа нь эрх зүй судлаачдын дунд онцгой анхаарал татаж байна. Тухайлбал, олон улсын гэрээ, эрх зүйн актуудад **“**Залилах гэмт хэрэг”-ийн мөн чанарыг авлигын гэмт хэрэгт хамаардаг гэх ойлголт түгээмэл дэлгэрч байна.

14. Дэлхий дахиныг хамарсан түгээмэл үйлдэгддэг нуугдмал гэмт хэргийн нэг төрөл “залилах” гэмт хэрэг нь олон улсын баримт бичиг, гэрээ конвенцид өргөн хүрээг хамарсан гэмт хэргийн ангилалд багтаж, энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улсын хэмжээнд орчин үеийн, үр дүнтэй аргуудыг хэрэглэх нөхцөл, шаардлага олон улсад эрчимтэй яригдсаар байна. Дэлхийн эдийн засгийн хямрал, авлигын гэмт хэргийн тоо нэмэгдэж, далд эдийн засаг, бизнес цэцэглэн хөгжиж байгаа нь олон улсын болон улс орны эдийн засгийн хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл нэмэгдсээр байна. Олон улсын баримт бичигт «залилах» гэсэн нэр томъёоны ерөнхий ойлголт, тодорхой тайлбар нь эрх зүйн янз бүрийн нөхцөл байдалтай холбоотой өөр өөр агуулгыг илэрхийлэх тохиолдол байгааг анхааран үзэх шаардлага бий болжээ.

САНАЛ

Залилах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа сэдэвт докторын зэрэг горилсон судалгааны ажлын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол ... “ гэж хэт нарийвчлан зааснаас уг гэмт хэргийн шинжүүдийг тогтоох болон шийдвэрлэхэд хуулийн заалтыг өөрчлөх шаардлага байгааг судалгааны үр дүн харуулж байна. Иймд “Бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсан бол ...” гэж залилах гэмт хэргийн шинжүүдийг нэгтгэх.

2. Хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “бага хэмжээний хохирол”, “үлэмж хэмжээний хохирол”, “их хэмжээний хохирол” байхаар хуульчилсныг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлд заасан зарчимд нийцүүлэн гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутай этгээдийн үйлдэлд тохирсон хариуцлага хүлээлгэх шаардлагатай байна. Иймд хохирлын хэмжээг “онц их хэмжээний хохирол” гэж нэмж, хэмжээг хуульчлан тогтоох.

3. Залилах гэмт хэрэг үйлдэгчид орчин үеийн шинжлэх ухаан, технологийн шийдэл арга зүйг хэрэглэн, эрх зүйгээр зохицуулаагүй харилцаа, хуулийн хийдлийг овжин ашиглаж, үндэсний хийгээд олон улсын санхүүгийн тогтолцоонд хор уршиг учруулж буй нь энэ төрлийн гэмт хэргийн үйлдлийг эрүүгийн эрх зүйн аргаар гаргахгүй байж, гадаадын бусад орны хууль зүйн хамгаалалттай өөрийн орны ижил төрлийн арга хэрэгслийг ойртуулан жигдрүүлж, үр нөлөөг дээшлүүлэхийг бодитоор нөхцөлдүүлж байна. Энэ үүднээс залилах хэргийг зээлийн залилан, төлбөр хүлээн авах залилан, цахим төлбөрийн хэрэгсэл ашиглан үйлдэх залилан, даатгалын салбарын залилан, компьютерийн мэдээллийн салбарын залилан (ОХУ), компьютерийн залилан , нөхөн төлбөрийн залилан, хөрөнгө оруулалтын залилан, даатгалын залилан, мөнгөн тусламжийн залилан, хуурах замаар ашиг олох залилан, зээлийн залилан, спорт бооцооны залилан (ХБНГУ), хуурах аргаар бусдын газрыг авах залилан, залилах аргаар мөнгөн шилжүүлэг хийх, зардлын ашигтай байдал үүсгэх, үйлчилгээ авах, өр төлбөрөөс зайлсхийх, мэдээллийг мэдэгдэх үүрэгтэй ч мэдэгдэлгүй залилах, компанийн залилан (Англи) гэх зэргээр эрүүгийн хуульдаа төрөлжүүлэн ангилсан туршлагаас жишээ авч Монгол Улсын холбогдох хуульд нутагшуулах.

4. Залилах гэмт хэргийн шинжээс хамааран энэ төрлийн гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний маргаанаас ялган зүйлчилж зөв шийдвэрлэх тухай Улсын Дээд Шүүхээс тайлбар гаргах. Мөрдөгч, прокурор гэрээгээр халхавчилсан гэмт хэргийн үйлдлийг хангалттай шалгахгүй орхигдуулах, улмаар холбогдох этгээд шүүхийн шатанд ял завших тохиолдол арилахгүй байгаа нь иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдөх, хуулийн байгууллагын үйл ажиллагаанд үл итгэх,нэр хүндэд нь сөргөөр нөлөөлөх зохисгүй үр дагавар гарахаас сэргийлж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.

НОМ ЗҮЙ

Нэг. Хууль, эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль.1992.
2. Монгол Ардын түр засгийн газрыг сонгон байгуулсан хурлын тогтоол. Дээд шивээ. 1921.03.13.
3. БНМАУ-ын Шүүх цаазын бичиг. УБ., 1926.
4. БНМАУ-ын Шүүх цаазын бичиг. УБ., 1934.
5. БНМАУ-ын Эрүүгийн хууль. УБ., 1942, 1947, 1987, 2002.
6. БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 1991.04.19-ний өдрийн 13 дугаар тогтоол.
7. БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 1997.06.23-ны өдрийн 25 дугаар тогтоол.
8. Монгол Улсын Иргэний хууль.
9. Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. УБ., 2015.
10. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/. УБ., 2017.
11. Монгол Улсын хууль тогтоомжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/., 2015.

Хоёр. Олон улсын гэрээ, конвенци

1. Спортын допингийн эсрэг олон улсын конвенци, 2004.
2. Компьютерийн гэмт хэргийн тухай конвенци, 2001.
3. Олон улсын ачаа тээвэрлэх тухай гаалийн конвенци.
4. Иргэний харьяаллын тухай Европын конвенци.
5. Соёлын өмчийн эсрэг гэмт хэргийн тухай Европын конвенци.
6. Олон улсын бараа худалдах тухай нэгдсэн конвенци, 1980.
7. Санхүүжилтийн болон хөгжлийн зээлийн шинэчилсэн хэлэлцээр соёрхон батлах тухай хэлэлцээрийн баримт бичиг, 2010.
8. Олон талт худалдааны ачилтын өмнөх хяналт шалгалтын тухай хэлэлцээр, 2010.
9. Импортын тусгай зөвшөөрөл олгох журмын тухай хэлэлцээр., 1994.
10. Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенци, 1989.
11. Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенци, 1979.
12. “Холбооны Гаалийн татварын хууль”. 1993.07.02-ны өдрийн N 2454/93

13. “Шударга бус спортын тэмцээн уралдаан зохион байгуулахын эсрэг конвенци 2014.
14. Хүн худалдаалахтай тэмцэх тухай Европын холбооны конвенци., 2005 он
15. Терроризмыг санхүүжүүлэх ба гэмт хэргээс олсон орлогыг хураах, эрэн сурвалжлах, мөнгө угаах тухай., Европын холбооны конвенци 2005.
16. "Гэрийн үйлчлэгчдийн зохистой хөдөлмөрийн тухай". Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 189 тоот. 2011.
17. "Далайчдын мэргэжлийн сургалтын түвшний тухай" 2008.
18. “Баримт бичиг, нотлох баримт авах, шүүхэд хүргүүлэх тухай” 2009.
19. "Европын улс төрийн намууд болон Европын улс төрийн сангуудын дүрэм, санхүүжилтийн тухай" 2014.
20. "Тарифын ерөнхий хөнгөлөлтийн схемийг хэрэглэх” 2012.
21. “Бүтээгдэхүүний гарал үүсэл, тэдгээртэй холбоотой журмын талаарх залилах онцгой тохиолдлуудын талаар”., 2012.
22. Дэлхийн шуудангийн конвенци., 2012.

Гурав. Ном, сурах бичиг

1. Авирмэд. Э, Дашцэдэн. Д, Совд. Г. “Монгол хууль”. УБ., 1997.
2. Авхиа. Ж, Ганболд. Б. “Эрүүгийн хуулийн тайлбар”., 2004.
3. Адъяабазар. Д. “Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт” /I дэвтэр/ УБ.,1998.
4. Адъяабазар.Д. “Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал”.УБ, 2002.
5. Алтангэрэл. Т. Монгол Ойрадын их цааз, түүний судалгаа. УБ., 1998.
6. Алтангэрэл. Т. XVI-XVII зууны монгол цаазын бичгүүд. УБ., 1999.
7. Бадарчи. С. Монголын төр эрх зүйн түүх /цомог-зураглал/. УБ., 1989.
8. Баярсайхан. Д. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2011.
9. БНМАУ-ын Үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхтгэл. УБ., 1971.
10. БНМАУ-ын Дээд шүүхийн Бүгд хурлын тогтоолуудын эмхэтгэл. УБ., 1976.
11. БНМАУ-ын хуулиуд. I. УБ., 1980.
12. Болдбаатар. Ж, Лүндээжанцан. Д. Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 2011.
13. Болдбаатар. Ж, “Криминалистикийн тактик” ред. УБ. 2001
14. Гантулга. С, Энхболд. Б. Эрүүгийн эрх зүй тусгай анги/сурах бичиг/. УБ., 2018.

15. Гантулга. С, Энхболд. Б. Эрүүгийн эрх зүй ерөнхий анги/сурах бичиг/. УБ., 2020.
16. Гантулгабат. Ц. “Залилах гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэхэд анхаарах асуудал, гэмт хэрэгтэй тэмцэх асуудал”.,2018.
17. Гантөмөр. Г, Энхболд. Б, Гантулга. С, Бат-Очир. Л, Төгс-Очир. Ж. нарын “Эрүүгийн эрх зүй”/ерөнхий анги/.УБ.,2020.
18. Гонгор. Д. Халх товчоон. УБ., 1970.
19. Должин.С, Бадам.Д “Залилах гэмт хэрэг ба гэрээний маргаан” 2018.
20. Доржпалам. Х. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй./Ерөнхий анги/. УБ., 2019.
21. Доржпалам. Х. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй./Тусгай анги/. УБ., 2021.
22. Жалан-Аажив. С. Арван буянт номын цагаан түүх. УБ., 1998.
23. Жанцан. С. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүйн тусгай ангийг судлах бүдүүвч, тойм. УБ., 1990.
24. Жиованни Дель Плано Карпини. Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988.
25. Жоужань цзыляо цзилу. Чжунхуа шуцзюй. Бэйцзин. 1962 /Нируны түүхийн хэрэглэгдэхүүний эмхэтгэл. Бээжин. 1962.
26. МАХН-ын тогтоол шийдвэр, баримт бичгүүд. УБ., 1984. II боть
27. МАХН-ын тогтоол шийдвэр баримт бичгүүд. УБ., 1985. боть-3
28. Минжин. Ц. “Их Засаг” УБ., 2009.
29. Монгол, Орос, Хятад, Герман Улсын Эрүүгийн Хууль. 2021.
30. Нарангэрэл. С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ., 1998.
31. Нарангэрэл. С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй/Тусгай анги/. УБ., 1999.
32. Нарангэрэл. С, Эрдэнэбулган. Ж, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй, үзэл баримтлал, уламжлал, сургамж. УБ., 2019.
33. Прокурорын ном/Гарын авлага/. УБ., 2019.
34. Содовсүрэн. Б. БНМАУ - ын Эрүүгийн хууль , тогтоомжийн хөгжилт. УБ., 1971.
35. Содовсүрэн. Б. Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цааз /1911-1920/. УБ., 1989.
36. Соёл гэгээрлийн байгууллагуудын ажлын талаар холбогдолтой зарлиг, тогтоол зааврууд системчилсэн эмхэтгэл. УБ., 1962.
37. Социалист хууль ёсыг бэхжүүлье. УБ., 1696.
38. Сүхбаатар. Г. Монголын түүхийн дээж бичиг. I дэвтэр.УБ., 1992.
39. Сэнгэдорж. Т. Хууль зүйн шинжлэх ухаан, судалгааны арга зүй. УБ., 2021.
40. Сэр-Оджав. Н. Монголын эртний түүх. УБ., 1977.

41. Чой.Лувсанжав “Хууль цааз журам”. Өчил сонин. 1990.
42. Ц.Цэрэндаваа “Цахим худалдааны статистик бүртгэлийн шинжилгээ”, УБ 2020
43. Цэвэл. Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966.
44. Цэлмэг. Ц., Майцэцэг.Д. “Харьцуулсан эрүүгийн эрх зүй”. 2021.
45. ШЕЗ “Эдийн засгийн гэмт хэрэг”. УБ., 2017.

Дөрөв. Гадаад хэл дээрх нэг сэдэвт бүтээл болон сурах бичиг

1. Fraud and Corruption: Prevention and Detection - 1st Edition - Nigel
2. Fraud Investigation: Criminal Procedure and Investigation - Sally Ramage - Google Books
3. Sally Ramage Fraud Investigation: Criminal Procedure and Investigation –
4. О.С.Беляк. Ответственность за мошенничество по уголовному праву России: автореф. дис. к.ю.н. – Москва, 2006. – 24 с.
5. Д.Ю.Беляков. Противодействие мошенничествам, совершаемым в сфере автострахования: криминологический и уголовно-правовой аспекты: дис. к.ю.н. – Москва, 2007.
6. Ю.М.Быков. Мошенничество в сфере страхования (криминологические и уголовно-правовые проблемы): дис. к.ю.н. – Москва, 2006. – 196 с.
7. Л.В.Григорьева. Уголовная ответственность за мошенничество в условиях становления новых экономических отношений: дис. к.ю.н. – Саратов, 1996. – 197 с.
8. Р.Б.Осокинович. Уголовно-правовая характеристика способов совершения мошенничества: автореф. дис. к.ю.н. – Москва, 2004. – 23 с
9. М.Е. Покровский. Мошенничество в финансово-кредитной сфере: автореф. дис. К.Ю.Н. – Санкт-Петербург, 2006. – 20 с.
10. Ю.И. Степанов. Уголовно-правовая характеристика обмана как признака преступлений в сфере экономики: дис. к.ю.н. – Санкт-Петербург, 2001. – 253 с.
11. В.В. Эльзессер. Борьба с мошенничеством в банковской сфере: Уголовно-правовой и криминологический аспекты : автореф. дис. к.ю.н. – Санкт-Петербург, 2005. – с 22
12. Criminal Law of Korea. 1992.
13. Cressey, D. R. (1953). Other People’s Money. Montclair, NJ: Patterson Smith

14. Albrecht, C. C. (2008). Current Trends in Fraud and its Detection: A Global Perspective. Information Security Journal Vol.17. Retrieved from www.ebscohost.com on 11th June, 2014.
15. European Journal of Business and Management “Fraud Triangle Theory and Fraud Diamond Theory: Understanding the Convergent and Divergent for Future Research”. 2015.
16. European Treaty Series-№185, “Convention on cybercrime”, Budapest, 23.XI.2001.
17. Linda Delamaire (UK), Hussein Abdou (UK), John Pointon (UK) Credit card fraud and detection techniques: a review, 2009.
18. International Bureau of the Universal postal union “Decisions of the 2012 Doha congress”. /Final texts of the acts signed at Doha and of the decisions other than those amending the acts/. Berne 2013.
19. TreasuryDirect. “The 18th century.”Accessed June 26, 2020.
20. Mary-Jo Kranacher, Richard A. (Disk) Riley, Jr “Forensic Accounting and fraud examination”. 2019.
21. Journal of Emerging Trends in Economics and Management Sciences (JETEMS) 3(3): 191-195 © Scholarlink Research Institute Journals, 2012
22. Яни П.С. Специальные виды мошенничества // Законность. 2015.
23. Official Journal of the European Union “Noties from European union institutions, bodies, offices and agencies”. 2010.
24. European Treaty Series - №. 166, “European Convention on Nationality”. Strasbourg, 6.XI.1997.
25. European Treaty Series – №119, “European Convention on Offences relating to Cultural Property”. Delphes, 23.VI.1985.
26. K.S. Mamadovich's New regulations on fraud in the Criminal Code of the Russian Federation: Special features and distinctions [J] 2013
27. Law.[J] Vestnik Tomskogo gosudarstvennogo universiteta. Pravo = Tomsk State University Journal of Law, 2020
28. On amendments to the Criminal Code of the Russian Federation: Feder. law of 23 Apr. 2018 No. 111-FZ. Rossiyskaya gazeta. 2018
29. См.: Угаловный кодекс ФРГ/Пер. С немв А.В.Серебренникова. М., 2001
30. Fassung aufgrund des Gesetzes zur Umsetzung der Richtlinie (EU) 2017/1371 des Europäischen Parlaments und des Rates vom 5. Juli 2017 über die strafrechtliche Bekämpfung von gegen die finanziellen Interessen der Union

gerichtetem Betrug vom 19.06.2019 (BGBl. I S. 844), in Kraft getreten am 28.06.2019

31. Vorschrift eingefügt durch das Einundfünfzigste Gesetz zur Änderung des Strafgesetzbuches - Strafbarkeit von Sportwettbetrug und der Manipulation von berufssportlichen Wettbewerben vom 11.04.2017 (BGBl. I S. 815), in Kraft getreten am 19.04.2017
32. Global Economic crime survey- mainland China8 Hong Kong and Macau Supplement, PwG 2014
33. Kan Jifeng. Criminal law protection of the legitimate rights and interests of private enterprises and entrepreneurs [N]. People Court Daily, 2021-06-10 .
34. Jiang Lihong. Basic Situation and Innovative Development of Criminal Law Regulations for Enterprise Fraud Crime [J].Legal latitude and longitude 2021 №7

Тав. Нэг сэдэвт судалгааны бүтээл, өгүүлэл, нийтлэл, тайлан

1. Адъяабазар. Д. Монгол Улсад залилан мэхлэх гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийн тулгамдсан асуудал /Диссертаци/. 2004 62 дахь тал
2. Баярхүү. Г. “Монголын нэгдсэн төрийн болон дараа үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь” (XIII-XVIII зуун) сэдэвт хууль зүйн ухааны дэд докторын зэрэг горилсон зохиол.
3. Должин. С. Хувийн эрх зүй эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхтгэл. УБ., 2017.
4. Дэлгэрмэнд. Т. Залилах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал, түүнтэй тэмцэх арга зам. УБ., 2016.
5. Мөнхцэцэг. О. Залилан мэхлэх гэмт хэргийг иргэний эрх зүйн зөрчил, ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчлэх нь. Магистрын ажил. УБ., 2014.
6. Наранбаатар. Г. Эрүүгийн хэргийн нотлох ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцоо, харьцуулсан судалгаа./Диссертаци/. УБ., 2018.
7. Совд. Г. Эрүүгийн хариуцлага түүний уламжлал, шинэчлэлийн асуудал сэдэвт диссертаци. УБ., 1992.
8. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. “Залилах” гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, судалгаа. УБ., 2020.

9. Цэлмэг. Ц, Д.Оросоо "Залилах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ" Нээлттэй Нийгэм Форум. Шүүхийн шийдвэрийн судалгаа: Цуврал 2. УБ., 2021.
10. Залилах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах мөрдөгчийн гарын авлага.УБ., 2021.
11. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /шинжлэх ухааны тайлбар/.УБ.,2010
12. Залилах гэмт хэргийг иргэний эрх зүйн үүргийн гүйцэтгэлээс ялгах нь /судалгааны тайлан-2010 он/
13. Улсын дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл,УБ,2008 он

Зургаа. Сонин, сэтгүүл

1. Амартүвшин. С. Эрүүгийн болон иргэний эрх зүйн харилцан хамаарал. Эрх зүйн сэтгүүл. МУИС-ХЗС. УБ., 2014.
2. Өнөөдөр сонин. УБ.,2002. №279
3. Төрийн мэдээлэл сэтгүүл. УБ., 2002. №5 /242/
4. Төрийн мэдээлэл. УБ., 1992. №1

Долоо.Архивын баримт

1. Монгол Улсын Үндэсний төв архив. Ф-284 . Т-1. х/н-610.
2. Монгол Улсын Үндэсний төв архив. Ф-1. Д-3. Х/н-165.
3. Монгол Улсын Үндэсний төв архив.ф. 1-8-х

Найм. Шүүхийн тогтоол шийдвэр

1. Монгол улсын дээд шүүхийн тогтоол /дугаар 51/ 2006.12.21
2. Монгол улсын дээд шүүхийн тогтоол /дугаар 51/ 2006.12.21
3. Монгол Улсын Дээд шүүх. 684 дүгээр тогтоол., 2020
4. Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 2021/ШЦТ/51 шийтгэх тогтоол
5. Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 1006 дугаар шийтгэх тогтоол
6. Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 1143 дугаар шийтгэх тогтоол
7. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 08 сарын 11 өдрийн 897 дугаартай шийтгэх тогтоол
8. Дархан-Уул аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн2021 оны 07 сарын 23 өдрийн 0189 дугаартай шийтгэх тогтоол

9. Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 сарын 31 өдрийн дугаар 214 шийтгэх тогтоол
10. Монгол Улсын Дээд шүүх. 656 дүгээр тогтоол., 2019
11. Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 01 сарын 19 өдрийн 103 дугаартай шийтгэх тогтоол
12. Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 11 сарын 19 өдрийн 628 дугаартай шийтгэх тогтоол
13. Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 01 сарын 06 өдрийн 28 дугаартай шийтгэх тогтоол
14. Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 12 сарын 02 өдрийн 836 дугаартай шийтгэх тогтоол
15. Баян-Өлгий аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 11 сарын 24 өдрийн 139 дугаартай шийтгэх тогтоол
16. Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 01 сарын 17 өдрийн 77 дугаартай шийтгэх тогтоол
17. Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 01 сарын 13 өдрийн 67 дугаартай шийтгэх тогтоол
18. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 сарын 08 өдрийн 637 дугаартай шийтгэх тогтоол
19. Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 12 сарын 01 өдрийн 19 дугаартай шийтгэх тогтоол
20. Улсын Дээд шүүхийн тогтоол. 2021 оны 12 сарын 22-ны өдөр дугаар 03
21. Улсын Дээд шүүхийн тогтоол. 2021 оны 04 сарын 02-ны өдөр дугаар 184
22. Улсын Дээд шүүхийн тогтоол. 2021 оны 01 сарын 08-ны өдөр дугаар 27
23. Улсын Дээд шүүхийн тогтоол. 2019 оны 12 сарын 13-ны өдөр дугаар 646
24. Улсын Дээд шүүхийн тогтоол. 2020 оны 07 сарын 17-ны өдөр дугаар 422

Ес. Цахим эх сурвалж

1. https://legalinfo.mn/mn
2. anuharchu.medium.com
3. https://www.experian.co.uk/blogs/latest-thinking/fraud-prevention/5-of-the-most-remarkable-instances-in-the-history-of-fraud/
4. https://www.experian.co.uk/blogs/latest-thinking/fraud-prevention/5-of-the-most-remarkable-instances-in-the-history-of-fraud/
5. https://www.investopedia.com/articles/financial-theory/09/history-of-fraud.asp
6. Cressey's Fraud Triangle, Characteristics of Ponzi Perpetrators - The Politics of Ponzi Schemes: History, Theory, and Policy (ebrary.net)

7. The Cressey fraud triangle Source: Adapted from Coenen (2008, p. 10)... | Download Scientific Diagram (researchgate.net)
8. jetems.scholarlinkresearch.org
9. Залилангийн гурвалжин – Criminology.mn
10. Deterring fraud: the internal auditor's perspective in SearchWorks catalog (stanford.edu)
11. Deterring fraud: the internal auditor's perspective in SearchWorks catalog (stanford.edu)
12. Fraud triangle and fraud diamond theory (linkedin.com)
13. Forensic Accounting and Fraud Examination: Kranacher, Mary-Jo, Riley, Richard, Wells, Joseph T: 9780470437742: Books (amazon.com)
14. What Is Forensic Accounting And Fraud Examination? (trendingaccounting.com)
15. https://www.wikipedia.org/
16. Договор о функционировании Европейского Союза (Рим, 25 марта 1957 г.) (в редакции Лиссабонского договора 2007 г.) (2016/C 202/01). Консолидированная версия | ГАРАНТ (garant.ru)
17. EUR-Lex - 32014R1141 - EN - EUR-Lex (europa.eu)
18. Regulation (EU) No 978/2012 of the European Parliament and of the Council of 25 October 2012 applying a scheme of generalised tariff preferences and repealing Council Regulation (EC) No 732/2008 (europa.eu)
19. directdoc.aspx (wto.org)
20. 23-lic.wpf (wto.org)
21. Microsoft Word - con-e-rev.doc (uwi.edu)
22. Pub615web.pdf (iaea.org)
23. Identity Theft - Definition, Examples, Cases, Processes (legaldictionary.net)
24. Credit Card Fraud - Definition, Examples, Cases, Processes (legaldictionary.net)
25. Insurance Fraud - Definition, Examples, Cases, Processes (legaldictionary.net)
26. Fraud - Definition, Meaning, Types, and Examples (legaldictionary.net)
27. Credit Card Fraud - Definition, Examples, Cases, Processes (legaldictionary.net)
28. Borkov V.N., Nikolaev K.D. Violation of the Rules of Qualification Can Not Compensate Gaps in the Criminal
29. Ст. 159.2 УК РФ. Мошенничество при получении выплат (rulaws.ru)
30. Strafgesetzbuch (StGB) - dejure.org

31. Понятие мошенничества в зарубежном уголовном законодательстве (wiselawyer.ru)
32. УК РФ Статья 159. Мошенничество \ КонсультантПлюс (consultant.ru)
33. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/8012ecdf64b7c9cfd62e90d7f55f9b5b7b72b755/
34. 대한민국 헌법 - 나무위키 (namu.wiki)
35. 형법 (law.go.kr)
36. Federal Criminal Law (justice.gov)
37. EUR-Lex - 32014R1141 - EN - EUR-Lex (europa.eu)
38. The Basel Committee on Banking Supervision | Council on Foreign Relations (cfr.org)
39. https://www.merriam-webster.com/dictionary/fraud